

Захмалагч: Үндэсний Статистикийн Хороо
Гүйцэтгэгч: МУИС-ийн ЭЗС-ийн Статистикийн тэнхим

ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

(Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үр дүнгээр бэлтгэсэн сэдэвчилсэн судалгаа)

Түлхүүр үгс:

- Монголын өрхүүд, түүний төрөл – Households in Mongolia by type
- Монгол дахь гэрлэлтийн дундаж нас- Singulate Age at Marriage in Mongolia
- Гэрлэлтийн байдал - Marital status in Mongolia

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 -д "...Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж заасан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого" –д гэр бүлийн амьдралын түвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжихэд энэхүү бодлогын эрхэм зорилго оршино гэж тодорхойлжээ.

БҮЛЭГ 2. Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод "Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж, түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын анхааралд байлгана" гэж заасан нь өнөөгийн төр, засгаас гэр бүлийн талаар баримтлах бодлогын үндэс болж байна.

Энэ бүхнээс харахад манай орны хувьд өрх, гэр бүлийн асуудал төрийн анхааралд байдаг чухал асуудал юм.

"Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт" гэсэн энэхүү судалгаанд Монгол Улсын өрхийн тоо, бүтэц, өрхийн ам бүлийн тоо, түүнд гарсан өөрчлөлтүүдийг судлаж, түүнд нөлөөлсөн зарим хүчин зүйлийг илрүүлэн гаргах, хүн амын гэр бүлийн байдлыг нас, хүйс, байршил, үндэс угсаагаар ялгаатай байгааг тодорхойлж, анхны гэрлэлтийн дундаж нас, түүний өөрчлөлт, түүнд нөлөөлсөн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүдийг тодорхойлохыг зорилоо. Мөн хосуудын боловсрол, ажил эрхлэлтийн байдлыг зэрэгцүүлэн гаргасан бөгөөд энэ нь гэр бүл, түүний гишүүдийн нийгэмд гүйцэтгэх үүргийн нийтлэг болон ялгаатай талуудыг гаргахад чиглэгдсэн юм.

Хүн ам ,орон сууцны өмнөх 2000 оны улсын тооллогын үр дүнгээр "Хүн амын гэрлэлтийн байдал" сэдэвтэй судалгаа хийгдсэн бөгөөд харин энэхүү сэдэвчилсэн судалгаа нь өрх, гэр бүлийн байдлыг хамарснаараа үүнээс нэлээд өргөн хүрээтэй болсон. Судалгааны 2 ба 3 дугаар бүлэг шинээр орж байгаа бүлгүүд бөгөөд 2010 оны тооллогоор анх цуглуулсан шашин шүтлэгийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийг шинээр хамруулж, өрхийн тоо , ам бүлийн тоо, бүтэц, гэр бүлийн байдал, анхны гэрлэлтийн дундаж насыг эдгээр үзүүлэлтүүдээр тусган харуулснаараа өмнөхөөс ялгагдана. Нөгөө талаасаа тооллогын бус эх үүсвэрийг ашиглан судалгаанд нөлөөлсөн хүчин зүйлийг харуулсанаараа онцлогтой болно.

Төр засгаас өрх гэр бүлийн хөгжил, сайн сайхныг дээшлүүлэх талаар талаар дэвшүүлсэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх, цаашид шинэ зорилт дэвшүүлэх, өмнөх бодлого, хөтөлбөрөө шинэчлэхэд шаардлагатай суурь мэдээллийг бүрэлдүүлж, " Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого" –ын баримт бичгийн 4-дүгээр бүлгийн 3 -д гэр бүлийн холбогдолтой бүхий л асуудлаар мэдээлийн тогтолцоог бүрдүүлнэ гэсэн

заалтыг хэрэгжүүлэхэд энэ сэдэвчилсэн судалгааны мэдээлэл зохих үүрэг гүйцэтгэнэ гэж найдаж байна.

Энэхүү сэдэвчилсэн судалгааг МУИС-ийн ЭЗС-ийн Статистикийн тэнхмийн багш нар бэлтгэсний дотор 1,3,5 болон 8-р бүлгүүдийг доктор, профессор Б.Батмөнх, 2-р бүлгийг доктор Д.Нарантуяа, 4-р бүлгийг залуу багш, магистр Б.Оюун-Эрдэнэ, 6-р бүлгийг доктор багш Д. Хишигт, 7-р бүлгийг доктор, дэд профессор Б. Энх Амгалан хариуцан бэлтгэв.

Сэдэвчилсэн судалгааг бэлтгэсэн багийн ахлагч: Б. БАТМӨНХ

АГУУЛГА

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ҮЗҮҮЛЭЛТ, ТООЦСОН

АРГАЧЛАЛ	1
1.1. Судалгааны зорилго	1
1.2. Ойлголт, тодорхойлолт, үзүүлэлт тооцсон аргачлал	3
1.3. Судалгааны бүтэц, зохион байгуулалт	9

БҮЛЭГ 2. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, БҮТЭЦ

2.1. Өрхийн тоо, хэлбэр	11
2.2. Үндсэн ба хамт суудаг өрх	14
2.3. Ам бүлийн тоо	15
2.4. Ганц бие өрх	15
2.5. Олон ам бүлтэй өрх	17
2.6. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	19

БҮЛЭГ 3. ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТООНД НӨЛӨӨЛСӨН ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛС

3.1. Хүн амын тоо, насны бүтэц болон өрхийн тооны хамаарал	23
3.2. Боловсролын төвшин өрхийн ам бүлийн тоонд нөлөөлсөн байдал	24
3.3. Үндэс угсаа, өрхийн ам бүлийн тооны ялгаатай байдал	26
3.4. Өрхийн хөдөлмөр эрхэлдэггүй, ажилгүй гишүүдийн тоо ба өрхийн ам бүлийн тооны хамаарал	27
3.5. Шинээр төрсөн хүүхэд, гэр бүлд олгосон мөнгөний нөлөөлөл	29

БҮЛЭГ 4. ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

4.1. Гэр бүлийн ерөнхий төлөв байдал	32
4.2. Огт гэр бүл болоогүй хүн амд гарсан өөрчлөлт	38
4.3. Гэр бүлтэй хүн ам	41
4.4. Гэр бүлээ цуцалсан, тусгаарласан хүн ам	43
4.5. Бэлбэсэн хүн ам	45

БҮЛЭГ 5. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС (АГДН), ТҮҮНИЙ ЯЛГАВАРТАЙ БАЙДАЛ

5.1. Анхны гэрлэлтийн дундаж нас, аймаг, нийслэл болон хот, хөдөөгийн байдлаар	50
5.2. Анхны гэрлэлтийн дундаж нас, үндэс угсаагаар	53
5.3. Анхны гэрлэлтийн дундаж нас, боловсролын төвшингөөр	54
5.4. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн идэвхийн байдлаар	56
5.5. Анхны гэрлэлтийн дундаж нас, ажил мэргэжлээр	58
5.6. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	60

БҮЛЭГ 6. ХҮН АМЫН ГЭРЛЭЛТЭНД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БУЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6.1. Хүн амын гэр бүлийн байдалд сөргөөр нөлөөлж буй зарим үзүүлэлтийн аймаг, нийслэл, хот, хөдөөгийн ялгаатай байдал	65
6.2. Хүн амын гэр бүл болоход сөргөөр нөлөөлж буй зарим үзүүлэлт, үндэс угсаагаар	72

6.3. Хүн амын гэр бүл болоход сөргөөр нөлөөлж буй зарим үзүүлэлт, боловсрол, бичиг үсгийн мэдлэгээр	80
БҮЛЭГ 7. ГЭР БҮЛ ХОСУУДЫГ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ЗЭРЭГЦҮҮЛСЭН БАЙДАЛ.....	84
7.1. Гэр бүлийн хосуудыг боловсролын төвшингөөр зэрэгцүүлсэн байдал.....	84
7.2. Гэр бүлийн хосуудыг ажил мэргэжлээр зэрэгцүүлсэн байдал	86
7.3. Гэр бүлийн хосуудыг үндэс угсаагаар зэрэгцүүлсэн байдал	88
7.4. Гэр бүлийн хосуудыг шашин шүтлэгээр зэрэгцүүлсэн байдал	89
7.5. Гэр бүлийн хосуудыг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нь зэрэгцүүлсэн байдал	91
БҮЛЭГ 8. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	93
8.1. Дүгнэлт.....	93
8.2. Зөвлөмж	97
ХАВСРАЛТ.....	100

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1. Өрхийн тоо, хэлбэрээр, 2010 он	11
Хүснэгт 2.2. Арван тав хүртэлх насны хүүхэдгүй өрхийн тоо ба хувь	13
Хүснэгт 2.3. Арван тав, түүнээс дээш насны ганц бие өрхийн тоо, тэргүүлэгчийн нас, ажил эрхлэлтийн байдлаар, 2010 он.....	16
Хүснэгт 2.4. Арван тав, түүнээс дээш насны ганц бие өрхийн тоо, тэргүүлэгчийн нас, боловсролын байдлаар, 2010 он	16
Хүснэгт 2.5. Олон ам бүлтэй өрхийн тоо, аймаг, нийслэл, хувиар, 2010 он	18
Хүснэгт 2.6. Эмэгтэй тэргүүлэгчтэй, хөгжлийн бэрхшээлтэй гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	20
Хүснэгт 2.7. Өрх толгойлсон эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо, тэргүүлэгчийнх нь эдийн засгийн идэвх, хот, хөдөөгөөр, 2010 он	21
Хүснэгт 3.1. Хүн ам, өрхийн тоо, түүний өсөлт	23
Хүснэгт 3.2. Хүн амын насны бүтэц	24
Хүснэгт 3.3. Өрхийн тоо, эхнэрийн боловсролын төвшин ба өрхийн ам бүлийн тоогоор, хувиар, 2010 он.....	24
Хүснэгт 3.4. Өрхийн тоо, нөхрийн боловсролын төвшин ба өрхийн ам бүлийн тоо, хувиар, 2010 он.....	25
Хүснэгт 3.5. Өрхийн тоо, тэргүүлэгчийн үндэс угсаа, ам бүлийн тоо, хувиар, 2010 он.....	26
Хүснэгт 3.6. Өрхийн тоо, ам бүлийн тоо болон сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй гишүүдийн тоогоор, 2010 он.....	28
Хүснэгт 3.7. Өрхийн тоо, ам бүлийн тоо болон сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй хүний тоогоор, хувиар, 2010 он	29
Хүснэгт 3.8. Өрхийн тоо, түүний өсөлт	30
Хүснэгт 3.9. Гэрлэлт, цуцлалтын тоо, түүний өөрчлөлт	31
Хүснэгт 4.1. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он	34
Хүснэгт 4.2. Арван тав, түүнээс дээш насны гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн амын тоо, насны бүлэг, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	35
Хүснэгт 4.3. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, насны бүлэг, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он	37
Хүснэгт 4.4. Арван тав, түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он	39
Хүснэгт 4.5. Арван тав, түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй хүн амын эдийн засгийн идэвх, насны бүлэг, хот, хөдөө, хүйс, хувиар, 2010 он	41
Хүснэгт 4.6. Арван тав, түүнээс дээш настай гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он	42
Хүснэгт 4.7. Арван тав, түүнээс дээш насны гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он	44

Хүснэгт 4.8. Арван тав, түүнээс дээш насны бэлбэсэн хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он	46
Хүснэгт 4.9. Арван тав, түүнээс дээш насны бэлбэсэн хүн амын тоо, насны бүлэг, хүйс, ажил эрхлэлтийн байдал, хувиар, 2010 он	47
Хүснэгт 5.1. Дэлхийн зарим орны хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас, хүйс, оноор	49
Хүснэгт 5.2. Анхны гэрлэлтийн дундаж нас, хот, хөдөөгөөр	50
Хүснэгт 5.3. Анхны гэрлэлтийн дундаж нас аймаг, нийслэл, хүйсээр, 1979, 1989, 2000, 2010 он	51
Хүснэгт 5.4. Анхны гэрлэлтийн дундаж насны бүлэглэлт, аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он.....	52
Хүснэгт 5.5. Анхны гэрлэлтийн дундаж нас, үндэс угсаа, хүйсээр, 2000, 2010 он	53
Хүснэгт 5.6. Анхны гэрлэлтийн дундаж насны бүлэглэлт, үндэс угсаа, хүйсээр, 2010 он.....	54
Хүснэгт 5.7. Анхны гэрлэлтийн дундаж нас, боловсролын төвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он.....	54
Хүснэгт 5.8. Анхны гэрлэлтийн дундаж нас, боловсролын төвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	55
Хүснэгт 5.9. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн идэвхийн байдал, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он	56
Хүснэгт 5.10. Анхны гэрлэлтийн дундаж нас эдийн засгийн идэвхийн байдал, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	57
Хүснэгт 5.11. Анхны гэрлэлтийн дундаж нас, ажил мэргэжил, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он....	58
Хүснэгт 5.12. Анхны гэрлэлтийн дундаж нас ажил мэргэжил, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он....	59
Хүснэгт 5.13. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он	60
Хүснэгт 5.14. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	61
Хүснэгт 6.1. 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй, цуцалсан, тусгаарласан, бэлбэсэн хүн амын хувийн жингээр ангилсан ерөнхий бүдүүвч, 2010 он.....	66
Хүснэгт 6.2. Нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнгийн нэгдсэн хүснэгт, 2010 он	70
Хүснэгт 6.3. 20-24, 25-29, 40-44 насны огт гэр бүл болоогүй, 40-44 насны цуцалсан/тусгаарласан, 60, түүнээс дээш насны бэлбэсэн хүн амын нийт хүн амд эзлэх хувь, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он	71
Хүснэгт 6.4. 20-24, 25-29, 40-44 насны огт гэр бүл болоогүй, 40-44 насны цуцалсан/тусгаарласан, 60, түүнээс дээш насны бэлбэсэн хүний нийт хүн амд эзлэх хувь, хүйс, үндэс угсаагаар, 2010 он	79
Хүснэгт 6.5. Арван тав, түүнээс дээш настай суурин хүн амын гэр бүлийн байдал, боловсролын байдал, хот, хөдөө, дүнд эзлэх хувиар, 2010 он.....	81
Хүснэгт 6.6. Арван тав, түүнээс дээш настай суурин хүн амын тоо, боловсролын байдал, гэрлэлтийн байдал, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010 он.....	82
Хүснэгт 6.7. Арван тав, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, боловсролын байдал, гэр бүлийн байдал, дүнд эзлэх хувиар, 2010 он	83

Хүснэгт 6.8. Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, боловсролын байдал, гэр бүлийн байдлаар	83
Хүснэгт 7.1. Гэрлэсэн хосуудын боловсролын төвшин, эхнэрийн насны бүлгээр, 2010 он	85
Хүснэгт 7.2. Гэрлэсэн хосын ажил эрхлэлт, эхнэрийн насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2010 он.....	87
Хүснэгт 7.3. Гэрлэсэн хосын тоо, өрхийн тэргүүлэгч болон эхнэрийн үндэс угсаа, эхнэрийн насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2010 он.....	88
Хүснэгт 7.4. 20-49 насны гэрлэсэн эмэгтэйн болон нөхрийн шашин шүтлэг, дүнд эзлэх хувиар, 2010 он.....	90
Хүснэгт 7.5. 20-49 насны гэрлэсэн эмэгтэйн болон нөхрийн шашин шүтлэгийн холбоо, дүнд эзлэх хувиар, 2010 он.....	90
Хүснэгт 7.6. 20-49 насны гэрлэсэн хөгжлийн бэрхшээлтэй хосууд, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010 он.....	91
Хүснэгт 7.7. 20-49 насны гэрлэсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн болон нөхрийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, холбоо, эзлэх хувиар, 2010 он	92

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 2.1. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН	11
ЗУРАГ 2.2. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, БАЙРШИЛ, ХУВИАР, 2010 ОН	12
ЗУРАГ 2.3. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, АМ БҮЛ, ХУВИАР, 2010 ОН	12
ЗУРАГ 2.4. ҮНДСЭН БА ХАМТ СУУДАГ ӨРХИЙН НИЙТ ӨРХӨД ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМГААР	14
ЗУРАГ 2.5. ГАНЦ БИЕ ӨРХИЙН 35-49 НАСНЫ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОО, БОЛОВСРОЛЫН БАЙДЛААР, 2010 ОН	17
ЗУРАГ 2.6. ОЛОН АМ БҮЛТЭЙ ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН	17
ЗУРАГ 2.7. ОЛОН АМ БҮЛТЭЙ ӨРХИЙН ТОО, ТЭРГҮҮЛЭГЧИЙН БОЛОВСРОЛЫН БАЙДЛААР, 2010 ОН	19
ЗУРАГ 3.1. ӨРХИЙН ТОО	30
ЗУРАГ 6.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, НАС, ХУВИАР, 2010 ОН ...	62
ЗУРАГ 6.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2000, 2010 ОН	63
ЗУРАГ 6.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010 ОН	65
ЗУРАГ 6.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ НИЙТ ХҮН АМД ОГТ ГЭР БҮЛ БОЛООГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН	67
ЗУРАГ 6.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ НИЙТ ХҮН АМД САЛСАН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН	68
ЗУРАГ 6.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БЭЛБЭСЭН ХҮН АМ, ХҮЙСЭЭР, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010 ОН	69
ЗУРАГ 6.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ НИЙТ ХҮН АМД ОГТ ГЭР БҮЛ БОЛООГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ҮНДЭС УГСААГААР, 2010 ОН	73
ЗУРАГ 6.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ОГТ ГЭР БҮЛ БОЛООГҮЙ ХҮН АМ, ХҮЙСЭЭР, ХАРЬАЛАЛ, ҮНДЭС УГСААГААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010 ОН	74
ЗУРАГ 6.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ НИЙТ ХҮН АМД ГЭР БҮЛ ЦУЦАЛСАН БОЛОН ТУСГААРЛАСАН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ҮНДЭС УГСААГААР, 2010 ОН	75
ЗУРАГ 6.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ГЭР БҮЛ ЦУЦАЛСАН БОЛОН ТУСГААРЛАСАН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ҮНДЭС УГСАА, ХҮЙСЭЭР, 2010 ОН	76
ЗУРАГ 6.11. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ НИЙТ ХҮН АМД БЭЛБЭСЭН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ҮНДЭС УГСААГААР, 2010 ОН	77
ЗУРАГ 6.12. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД БЭЛБЭСЭН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ҮНДЭС УГСАА, ХҮЙСЭЭР, 2010 ОН	78
ЗУРАГ 7.1. 20-34 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ИЖИЛ ҮНДЭСТ УГСААТАНТАЙ ГЭР БҮЛ БОЛСОН ХУВИЙГ ХОЁР ТООЛЛОГООР ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	89

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Өрхийн тоо, өрхөд тоологдсон хүний тоо, өрхийн хэлбэрээр, 2010 он	100
Хүснэгт 2. Өрхийн тоо, аймаг, нийслэл, ам бүлийн тоогоор, 2010 он.....	101
Хүснэгт 3. Өрхөд тоологдсон хүн амын тоо, хот, хөдөө, ам бүлийн тоо, өрхийн хэлбэрээр, 2010 он.....	102
Хүснэгт 4. Өрхийн тоо, ам бүлийн тоо болон өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар, 2010 он	103
Хүснэгт 5. Өрхийн тоо, ам бүлийн тоо болон сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй хүний тоогоор, 2010 он.....	106
Хүснэгт 6. Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, гэрлэлтийн байдал, насны бүлгээр	107
Хүснэгт 7. Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, гэр бүлийн байдал, насны бүлгээр, 2010 он.....	108
Хүснэгт 8. Арван тав ба түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, аймаг, нийслэлээр, 2010 он.....	110
Хүснэгт 9. Арван тав ба түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, үндэс угсаагаар, 2010 он.....	113
Хүснэгт 10. Арван тав ба түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, боловсролын төвшингөөр, 2010 он	116
Хүснэгт 11. Хоёр хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүн, нөхөн үржихүйн насны хүн амын тоо, боловсролын түвшин, гэрлэлтийн байдлаар	120
Хүснэгт 12. Анхны гэрлэлтийн дундаж нас, үндэс угсаа, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	121
Хүснэгт 13. Анхны гэрлэлтийн дундаж нас, боловсролын төвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	121
Хүснэгт 14. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн идэвхийн байдал, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	122
Хүснэгт 15. Анхны гэрлэлтийн дундаж нас, ажил мэргэжил, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он...	122
Хүснэгт 16. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	123
Хүснэгт 17. Анхны гэрлэлтийн дундаж нас, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он	124

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБ-ын ХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
НҮБ-ын СХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн хэлтэс
ХАТСТ	Хүн амын тооллого, судалгааны товчоо
МБПХГ	Мэдээлэл боловсруулалт, программ хангамжийн газар
АГДН	Анхны гэрлэлтийн дундаж нас
ГЕК	Гэрлэлтийн ерөнхий коэффициент

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ҮЗҮҮЛЭЛТ, ТООЦСОН АРГАЧЛАЛ

1.1. Судалгааны зорилго

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үндэслэн хийж байгаа сэдэвчилсэн судалгаануудын нэг нь “Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт” гэсэн энэхүү судалгаа юм. Энэхүү сэдэвчилсэн судалгаагаар Монгол Улсын өрхийн тоо, бүтэц, ам бүлийн тоо, түүнд гарсан өөрчлөлт, хүн амын гэрлэлтийн өнөө үеийн төрх байдал, сүүлийн жилүүдэд гарсан өөрчлөлт, тэдгээрт нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлохыг зорьсон юм.

Өрх, гэр бүл нь хүний хөгжил, төлөвшлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, зан заншил, уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй мөн. Ийм учраас манай оронд өрх, гэр бүлийн асуудлыг төрийн хэмжээнд ихээхэн анхаарч, гэр бүлийг төрөөс хамгаалах, түүний хөгжлийн таатай орчин нөхцлийг бүрдүүлэх талаар хууль эрх зүй, бодлогын цөөнгүй баримт бичгүүд батлагдан мөрдөгдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 11 -д “...Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заажээ.

1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан “Гэр бүлийн тухай” Монгол Улсын хуулинд “Гэрлэлт гэдэг нь харилцан эрх тэгш эрхүүргийн үндсэн дээр эрэгтэй, эмэгтэй үжүүс тодорхой ёслол, үйл ажиллагааны дүнд сайн дурын бат холбоо тогтоож хуулиар батлуулах явдал юм” гэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-д гэр бүлийн амьдралын төвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжихэд энэхүү бодлогын эрхэм зорилго оршино гэж тодорхойлжээ.

Ийм учраас төр засгаас өрх гэр бүлийн хөгжил, сайн сайхныг дээшлүүлэх талаар өмнө дэвшүүлсэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх, цаашид шинэ зорилт дэвшүүлэх, өмнөх бодлого, хөтөлбөрөө шинэчлэхэд шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

“Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого” –ын баримт бичгийн 4үгдэр бүлгийн 3 -д гэр бүлийн холбогдолтой бүхий л асуудлаар мэдээллийн тогтолцоог бүрдүүлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү сэдэвчилсэн судалгааны бас нэг зорилго оршино.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр Монгол Улсын суурин хүн амын 96.5 хувь нь 713.8 мянган өрхөд тоолуулжээ.

Өрхийн тоо, тү үий бү эц, өрхийн ам бү лйн тоо нь хүн ам зү й гол үзүүлэлтүүдийн нэг бөгөөд дэлхий нийтээрээ хүн амын тооллогоор цуглуулдаг чухал мэдээлэл болно. Манай орны хувьд өмнөх тооллогоор өрхийн тоо, түүний бүтэц, өрхийн ам бүлийн тооны талаарх мэдээллийг байнга цуглуулж ирсэн тул түүнд гарсан өөрчлөлтүүдийг судлах боломжтой мэдээлэл бүрдсэн. Монгол Улсын өрхийн тоо, бүтэц, өрхийн ам бүлийн тоо, түүнд гарсан өөрчлөлтүүдийг судлах, түүнд нөлөөлсөн зарим хүчин зүйлийг илрүүлэх нь энэхүү сэдэвчилсэн судалгааны бас нэг чухал зорилго болно.

Гэрлэлтийн байдал ньүнж ам зүйн нэг гол үзүүлэлт төдийгүй нийгмийн харилцааг зохицуулахад чухал ач холбогдолтой байдаг учир манай улсын удаа дараагийн үн амын тооллогоор гэрлэлтийн талаар холбогдох мэдээллийг байнга цуглуулж ирсэн тул үн амын гэрлэлтийн байдлын түүхэн өөрчлөлтийг судлах боломжтой юм. Үн ам, орон сууцны сүүлийн 2 тооллогод гэрлэлтийн асуудлыг МБ -ын аргачлалтай нийцлэн өмнөх тооллогуудынхаас арай өргөжүүлэн оруулснаар зах зээлийн нөхцөлд гэр бүл, түүний гишүүдийн харилцааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээгөлөвлөж, хэрэгжүүлэхэд тус дэм болохуйц бодлогын чанартай зарим саналүгдөлт дэвшүүлэхэд судалгааны бас нэг зорилт оршиж байна.

Түүнчлэн хүн ам, орон сууцны сүүлийн 2 тооллогоор олон улсын нийтлэг жишиг аргачлалтай нийцүүлэн хүн амын гэрлэлтийн байдлыг арван тав, түүнээс дээш насны үн амаас асуусан нь судалгааны х амрах үрээг өргөжүүл ж, нарийвчилсан мэдээллээр хэрэглэгчдийг хангахад судалгааны бас нэг зорилго оршино.

Хэрэглэгчдэд толилуулж байгаа “Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт” гэсэн энэхүү сэдэвчилсэн судалгаанд Монгол Улсын өрхийн тоо, бүтэц, өрхийн ам бүлийн тоо, түүнд гарсан өөрчлөлтүүдийг судлах, түүнд нөлөөлсөн зарим хүчин зүйлийг илрүүлэх, хүн амын гэрлэлтийн байдлыг нас, хүйс, байршил, анхны гэрлэлтийн дундаж нас, үүний өөрчлөлт, түүнд нөлөөлсөн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүдийг тодорхойлохыг зорилоо. Эн хосуудын боловсрол, ажил эрхлэлтийн байдлыг зэрэгүүлэн гаргасан бөгөөд энэ нь гэр бүл, түүний гишүүдийн нийгэмд гүйцэтгэх үүргийн нийтлэг болон ялгаатай талуудыг гаргахад чиглэгдсэн юм.

Гэр бүл цуцлалт болон тусгаарлалт нь гэр бүлийн харилцааны төд ийгүй нийгмийн харилцааны эмзэг асуудлуудын нэгбөөд эдгээрийн хүн ам зүйн болон эдийн засгийн гол голүзүүлэлтүүдийг судалгаанд оруулснаараа дээрх үзэгдлүүдийн талаар үнэлгээ хийх цаашид шинэчлэн судлахад тодорхой хувь нэмэр болох нь лавтайүний зэрэ гцээгээр тооллогынүеэр огт гэр бүл болоогүй байсан боловч хожуу ч гэсэн гэрлэх магадлалтай хүн ам, салсан, тусгаарласан болон дахин гэрлэх магадлал багатай ахимаг насныхныг эдийн засаг, нийгмийн зарим үзүүлэлт, байршлаар тодорхойлж судалгаанд тусгасан.

Бэлбэсрэх нь нэг талаас байгалийн үзэгдэл боловч нөгөө талаас улс орны эрүүл мэндийн хөгжил, хүн амын нас баралтын чиг хандлагыг илэрхийлэх нэг гол үзүүлэлт юм. Судалгаанд бэлбэсэн хүн амыг нас, хүйс, байршил, угсаа үндсийн ялгаатай байдлаар нэлээд дэлгэрэнгүй үзүүлэхийг зорьсон.

Гэрлэлтийн байдал нь хүн амын төрөлтийн чиг хандлагыг илэрхийлэх үндсэн нөхцлүүдийн нэг билээ. Хүн ам, орон сууцны 2000 болон 2010 оны улсын тооллогоор гэр бүлийн байдлын талаар цуглуулсан мэдээлэл өөрчлөх тооллогуудын дүнтэй харьцуулах боломжтой учраас гэр бүлийн байдлын өөрчлөлтийн динамикийг уг судалгаанд оруулав. Ялангуяа хүн ам зүйн нэг гол үзүүлэлт болох анхны гэрлэлтийн дундаж насыг сүүлийн хэд хэдэн тооллогын онуудаар, мөн үндэс угсаа, байршил, боловсрол, эдийн засгийн идэвх, ажил мэргэжлээр тооцож гаргав.

1.2. Ойлголт, тодорхойлолт, үзүүлэлт тооцсон аргачлал

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод хэрэглэсэн ойлголт тодорхойлолтуудыг “Нэгдсэн үд” гэсэн 2010 оны тооллогын үр дүнгийн тайланд тодорхой тусгасан хэдий боловч энэхүү судалгааны мэдээллийг хэрэглэгчдэд илүү ойлгомжтой болгох үүднээс энэ сэдэвтэй холбоотой гол ойлголт, тодорхойлолтуудыг энд нэлээд дэлгэрүүлэн авч үзэв.

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан газар, үүний Статистикийн хэлтсээс хоёр дахь удаагаа засаж сайжруулан 2009 онд гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогод холбогдох зарчим, зөвлөмжүүд” гэсэн баримт бичигт хүн ам, орон сууцны тооллогоор цуглуулах мэдээллийг ач холбогдлоор нь дараах 3 зэрэглэлд ангилсан байна. Үүнд:

1. Үндсэн асуултууд
2. Үндсэн чөлөөт асуултууд
3. Нэмэлт асуултууд

Дээрх аргачлалд өрх, гэр бүлийн байдал, гэрлэлтийн талаар хүн ам, орон сууцны тооллогоор дараах асуултуудыг асууж, мэдээлэл цуглуулахыг НҮБ-ын гишүүн орнууддаа зөвлөмж болгосон. Үүнд:

Өрх, гэр бүлийн байдлаар:

1. Өрхийн тэргүүлэгчтэй хамаарах хамаарал - Үндсэн асуулт
2. Өрх, гэр бүлийн бүтэц - Үндсэн чөлөөт асуулт

Гэр бүлийн байдлаар:

1. Гэр бүлийн байдал - Үндсэн асуулт

Энэхүү аргачлалын 2.144 дүгээр зүйлд гэр бүлийн байдлыг наад зах нь дараах 5 хэлбэрээр тодорхойлохыг зөвлөмж болгожээ.

- а. Ганц бие, огт гэрлэж байгаагүй
- б. Гэрлэсэн
- в. Бэлбэсэн, дахин гэрлээгүй
- г. Салсан, дахин гэрлээгүй
- д. Тусдаа амьдардаг гэр бүлийн хүмүүс

Үүний зэрэгцээ зарим улс оронд б-хэсэгт хамаарах хүмүүсээс албан ёсоор гэр бүл боловч гэр бүлийн ёсоор амьдардаггүй хүмүүсийг ялган харуулдаг гэжээ.

Судалгаа болон тооллогод хэрэглэсэн гол ойлголт, тодорхойлолтууд:

Өрх. Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрлийн болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.

Өрх нь **гэр бүл** гэдэг ойлголтоос ялгаатай. Нэгөрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно. 2010 оны тооллогоор үед тухайн өрх, айлд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд орохгүй садан төрлийн гэр бүл, ураг төрөл, хамаатан садны ямар ч холбоогүй хүмүүс амьдарч байвал тэднийг тухайн өрхөд тоолсон.

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан газар, үүний Статистикийн хэлтсээс хоёр дахь удаагаа засаж сайжруулан 2009 онд гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогод холбогдох зарчим, зөвлөмжүүд” гэсэн аргачлалд “өрхийн аж ахуй” (Household) гэдэг ойлголт нь ахуйн хэвшилд тулгуурласан ойлголт бөгөөд хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ гэж тодорхойлжээ. Энд өрхийн аж ахуй нь 2 хэлбэртэй байна. Эхнийх нь зөвхөн нэг хүнээс бүтсэн бусад хүмүүстэй холбоогүй өрхийн аж ахуй байж болно. Хоёрдахь нь хоёр буюу түүнээс дээш хүмүүсээс бүрдсэн өрхийн аж ахуй бөгөөд тэдгээр нь хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг. Өрхийг бүрдүүлсэн хүмүүс нь төрөл садангийн холбоотой болон холбоогүй, эсвэл тэдгээрийн холимог байж болно гэж тодорхойлжээ.

Эндээс харахад 2010 оны тооллогод хэрэглэсэн өрхийн ойлголт нь олон улсын нийтлэг ойлголтын хоёр дахь хэлбэрээр тодорхойлогдсон ойлголттой ижил байна. 2010 оны тооллогод хэрэглэсэн өрхийн ойлголтыг 2000 оны тооллогод мөн адил хэрэглэсэн байна.

Үндсэн өрх. Үндсэн өрх гэж сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг (ордер), орон сууц өлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.

Хамт суудаг өрх. Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хэлнэ.

Өрх үүсгээгүй хүмүүс. Нийтээрээ буюу хэсэгүйдгээрээ амьдарч байгаа, хоорондоо ураг, өрөл, хамаатан садны ям ар нэг холбоогүй хүмүүсийн өрх үүсгээгүй хүмүүс гэж үзнэ.

Сүүлийн 2 тооллогод өрхүүдийг дотор нь дараах 4 хэлбэрт ангилсан. Үүнд:

1. Ганц бие өрх
2. Ам бүлээрээ өрх
3. Нийлмэл өрх
4. Холимог өрх

Өрхийн эдгээр хэлбэрүүдийн тодорхойлолтыг 2010 оны тооллогын “Нэгдсэн дүн”-д тусгаагүй тул 2010 оны тооллогод тусгаснаар энд оруулав.

Ганц бие өрхийн тодорхойлолт 2 тооллогын заавар, дүнгийн тайланд аль алинд нь тусгаагүй байна. Гэхдээ хэн бүхэнд ойлгомжтой гэж үзлээ.

Ам бүлээрээ байгаа өрх. Ам бүлээрээ байгаа өрх дангаараа амьдрахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эхнэр, нөхөр, хүүхдийн (хүүхдүүдийн) хамт, мөн эцэг эсвэл эх нь хүүхдийн (хүүхдүүдийн) хамт өрх үүсгэн амьдрахыг хэлнэ.

Нийлмэл ам бүлтэй өрх. Нийлмэл өрхөд дараах бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд:

- а. Нэг ам бүл бусад хамаатан садантайгаа хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх
- б. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл дангаараа хамтран өрх үүсгэн амьдарч байгаа
- в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгэнтэй нь хамааралтай хүнтэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа
- г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай боловч нэг ам бүлийн биш хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа зэрэг өрх орно.

Холимог өрх. Холимог өрхөд дараах бүтэцтэй өрх хамраарна. Үүнд:

- а. Нэг ам бүл бусад хамаатан садан эсвэл хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх
- б. Нэг ам бүл, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх
- в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан садан, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа
- г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл эдгээр ам бүлийн алинд ч хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа
- д. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралгүй ам бүл бусад хүмүүстэй эсвэл хүмүүсгүйгээр амьдарч байгаа
- е. Хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон хүмүүс бусад хамааралгүй хүмүүстэй өрх үүсгэн амьдарч байгаа
- ё. Хоорондоо хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа өрх орно.

Өрхийн тэргүүлэгч. Өрхийн гишүүд өрхийн тэргүүлэгчээ өөрсдөө тогтооно. Өрхийн тэргүүлэгч нь тодорхойгүй тохиолдолд өрхийн тэргүүлэгчээр хэнийг сонгохыг өрхийн гишүүдийн сайн дурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгчид 16-аас дээш настай, ажигдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог, ам бүлийн аль нэг гишүүнийг тодорхойлж болно.

Хүн ам, орон сууцны 2000 болон 2010 оны улсын тооллогод үн амын гэр бүлийн байдлыг олон улсын жишигтэй нийцүүлэн өргөжүүлснийг дээр тэмдэглэсэн билээ. Үүнээс өмнө явуулсан тооллогуудад гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн эсэхийг харгалзахгүйгээр тооллогод хамрагдсан хүн гэр бүлтэй гэж хариулсан тохиолдолд “Гэр бүлтэй” гэж үзэж байсан бол сүүлийн 2 тооллогод энэ үзүүлэлтийг батлуусан гэр бүлтэй, батлуулаагүй гэр бүлтэй гэж 2 салгаж хариулт авсан юм. Мөн гэр бүлээ хууль ёсоор (Шүүхийн болон захиргааны шийдвэрээр) цуцлуулсан, эсвэл албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүмүүсийг цуцалсан болон тусгаарласан гэж тус тусад нь салгаж тодорхойлсон. Харин өмнөх тооллогуудад эдгээр үзүүлэлтийг хамтад нь тодорхойлж байв. 2000 болон 2010 оны тооллогуудын бас нэг онцлог бол гэрлэлтийн байдлыг арван тав, үүнээс дээш настай бүх хүнээс асуусан. Өмнөх тооллогуудад арван найм, түүнээс дээш настай хүнээс асууж байсан боловч үүнээс доош настай хүн гэр бүлтэй бол тооллогын хуудсанд тэмдэглэж байсан болно.

Гэр бүлийн байдал. Гэр бүлийн тухай Монгол Улсын хууль болон уламжлалт ёсны дагуу тухайн үний тооллогын үе дэх гэр бүлийн байдлыг хэлнэ. “Гэр бүлийн тухай” Монгол Улсын хуулиар манай оронд 18 нас үрсэн иргэд гэрлэх эрхтэй боловч гэр бүлийн байдлын тухай асуултыг НҮБ -ын зөвлөмжийн дагуу сүүлийн 2 тооллогоор 15 болон түүнээс дээш настай хүн бүрээс асуусныг дээр дурдсан. Энэ асуултын хариулт дотроо 6 төрөл байхаар тодорхойлсон. Үүнд:

Огт гэр бүл болоогүй. Арван тав, түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулсан.

Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй. Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад үртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг "Батлуулсан гэр бүлтэй" буюу **гэр бүлтэй** гэж, хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгаүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг "Батлуулаагүй гэр бүлтэй" буюу **хамтран амьдрагч** гэж тус тус авч үзсэн.

Тусгаарласан. Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүмүүсийг тусгаарласан гэж үзнэ.

Цуцалсан. Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацааг харгалзахгүйгээр цуцалсан гэж үзсэн.

Бэлбэсэн. Эхнэр, өрхийн аль нэг нь нас барснаас хойш их хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй бол бэлбэсэн гэж үзсэн болно.

- Нийслэл - Улаанбаатар хотын 9 дүүрэгт оршин суугаа бүх хүн ам,
- Аймгийн төв - 21 аймгийн төвийн сумдад оршин суугаа бүх хүн ам,
- Тосгон* - Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогод зориулж ҮСГ-ын газраас гаргасан тосгоны жагсаалтад бичигдсэн суурин газарт оршин суугаа бүх хүн ам үүнд хамрагдана.

- Сумын төв - Аймгийн төв, тосгонд ороогүй бусад сумын төвд оршин суугаа бүх хүн ам,
- Хөдөө - Хөдөө эсвэл тосгоны жагсаалтанд ороогүй хөдөөгийн жижиг суурин газарт оршин суугаа бүх хүн ам үүнд хамаарна.

“Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт” гэсэн энэхүү судалгаа нд оруулсан доорх үзүүлэлтүүдийг тооцсон арга зүйг энд дэлгэрэнгүй тусгалаа.

Гэрлэлтийн тусгай коэффициент (ГТК) нь 15 ба үүнээс дээш насны 1000 хүн ам тутамд ногдох анхны болон дахин гэрлэлтийн тоог илэрхийлдэг. Гэхдээ энэхүү судалгаанд өмнөх тооллогуудын дүнтэй зэрэгцүүлэх шаардлагаар гэрлэлтийн тусгай коэффициентийг 18 ба үүнээс дээш насны 1000 хүн ам тутамд ногдох байдлаар дараах томъёогоор тооцсон болно.

$$\text{ГТК} = \frac{\text{Нийт гэрлэлтийн тоо}}{18 \text{ ба түүнээс дээш насны хүн амын тоо}} \times 1000$$

ГТК нь гэрлэлттэй холбогдохгүй хүн амын насыг хасаж тооцдогоороо ГЕК -оос илүү нарийвчилсан үзүүлэлт юм.

Энэ үзүүлэлтийн агуулгыг хамгийн энгийнээр хялбарчилж ойлговол арван тав, түүнээс дээш 50 хүртэлх настай огт гэр бүл болж байгаагүй хүмүүсийн анх гэр бүл болтлоо ганцаараа амьдарсан дундаж хугацаа буюу дундаж нас юм. Жишээлбэл, 2010 оны хүн амын тооллогын дүнгээс тооцоход эрэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 26.2, эмэгтэйчүүдийнх 24.2 (Бүлэг 5) байгаа нь манай эрэгтэйчүүд дунджаар 26 насандаа гэр бүл болдог бол эмэгтэйчүүд 24 наснаас хойш буюу дунджаар 24 насандаа анх нөхөрт гардаг гэж ойлгоно.

[illegible]

Анхны гэрлэлтийн дундаж насыг $\bar{x}$ ийн ялгавартай байдлаар тооцдог бөгөөд энэ нь эрэгтэй, эмэгтэйхүүсийн анхны гэрлэлтийн дундаж нас нь ямагт ялгаатай байдагтай холбоотой.

Бүлэг 5-д анхны гэрлэлтийн дундаж насыг олон улсын нийтлэг доорх аргачлалаар тооцсон.

Анхны гэрлэлтийн дундаж насыг (АГДН) тооцох аргачлал нэлээд өвөгтэй хэд хэдэн үе шаттай тооцооны үр дүнгээр гардаг. Түүнийг 50 хүртэлх насны ганц бие гэрлээгүй хүмүүсийн насны харьцаанаас үндэслэн тооцдог. Үүнд:

I үе шат. Ганцаар амьдарсан x жилийг **A** гэж үзээд дараах томьёогоор тооцно.

$$A = 15 + \sum_{a=15-19}^{45-49} S_a \cdot 5$$

Энд: S_a - гэсэн тэмдэглэгээ нь “a” насны бүлэгт огт гэрлээгүй хүн амын эзлэх хувь

II үе шат. 50 настай, ганцаарулдсэн хүний хувийн жинг **B** гэж тэмдэглэвэл дараах байдлаар тооцно.

$$B = (S_{45-49} + S_{50-54})/2$$

Энд хэрвээ 50-54 насны ганцаар амьдардаг хүний хувийн жин байхгүй тохиолдолд $B = S_{45-49}$ гэж авна.

III үе шат. 50 настайдаа гэрлэсэн хүмүүсийн хувийн жинг **C** гэж тэмдэглэвэл дараах байдлаар тооцно.

$$C = 1 - B$$

IV үе шат. Амьдралдаа гэрлээгүй хүмүүсийн хувийн жинг үндэслэн ийм x жилийн тоог **D** гэж тэмдэглээд дараах байдлаар тооцно.

$$D = 50 \cdot B$$

V үе шат. Эцэст нь анхны гэрлэлтийн дундаж насыг (АГДН) дараах томьёогоор тооцно.

АГДН = $(A - D) / C$ буюу

$$\text{АГДН} = \frac{15 + \sum_{a=15-19}^{45-49} S_a \cdot 5 - 50 \cdot \left(\frac{S_{45-49} - S_{50-54}}{2} \right)}{1 - \left(\frac{S_{45-49} - S_{50-54}}{2} \right)}$$

гэж тооцдог.

1.3. Судалгааны бүтэц, зохион байгуулалт

“Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт” гэсэн энэхүү сэдэвчилсэн судалгаа нь 8 бүлэгтэй бөгөөд судалгааны гол гол үзүүлэлтүүдийг хэрэглэгчдэд дэлгэрэнгүй байдлаар танилцуулахад зориулсан хавсралт хүснэгтүүдээс бүрдэж байна.

Нэгдүгээр бүлэгт судалгааны гол зорилго, тооллого болон энэхүү сэдэвчилсэн судалгаанд ашигласан гол ойлголт, тодорхойлолтууд, судалгаанд ашигласан гол үзүүлэлтийг тооцсон арга зүй, судалгааны бүтэц, бүлгүүдийн товч агуулгыг тусгав.

Хоёрдугаар бүлэгт өрхийн тоо, ам бүлийн тоо, өрхийн бүтцийн өнөөгийн байдал, сүүлийн тооллогуудын хооронд эдгээр үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтүүд, өрхийн ам бүлийн нийт болон дундаж тоо хот, хөдөө, үндэс угсаа, боловсролын төвшингөөс хамаараад ялгаатай байгаа байдал, ганц бие, олон ам бүлтэй, дан эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийг тусгайлан авч үзэж, гарсан өөрчлөлтүүдийг тусгав. Мөн сүүлийн 2010 оны тооллогод шинээр оруулсан хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй болон гадаадад амьдарч байгаа өрхүүдийн талаарх мэдээллийг нэгтгэн орууллаа.

Гуравдугаар бүлэгт өрхийн тоо, ам бүлийн тоонд нөлөөлсөн зарим хүчин зүйлсийн нөлөөллийг авч үзсэн болно. Энд хүн амын тоо, түүний насны бүтэц өрхийн тоонд хэрхэн нөлөөлснийг, эхнэр, нөхрийн боловсролын төвшин өрхийн ам бүлийн тоонд хэрхэн нөлөөлснийг, үндэс угсаатнуудын өрхийн ам бүлийн тооны ялгаатай байдал, өрхийн хөдөлмөр эрхэлдэггүй, ажилгүй гишүүдийн тоо ба ам бүлийн тооны хоорондын хамаарал, төрөөс ш инээр төрсөн хүүхэд, гэр бүлд олгосон мөнгө гэр бүлийн тоо болон гэрлэлтийн тоонд хэрхэн нөлөөлснийг харуулав.

Дөрөвдүгээр бүлэгт хүн амын гэрлэлтийн ерөнхий төлөв байдал, тооллогуудын хооронд гарсан өөрчлөлтийг 1979, 1989, 2000 оны тооллогын дүнгээр насны бүлэг, хүйс, байршлаар харуулсан. Үүний зэрэгцээ огт гэрлээгүй хүн амын тоо, түүнд гарсан өөрчлөлт, гэр бүлтэй хүн ам, батлуулаагүй гэр бүлүүд, гэр бүлээ цуцлуулсан, тусгаарласан, бэлбэсэн хүн амын тооны тооллого хооронд гарсан өөрчлөлтүүдийг харуулж, дүгнэлт гаргасан.

Тавдугаар бүлэгт анхны гэрлэлтийн дундаж насыг 1979, 1989, 2000 оны тооллогын дүнгээр улс, аймаг, нийслэл, хот, хөдөө гөөр тооцож, үүний өөрчлөлтөд нөлөөлсөн зарим хүчин зүйлсийг оруулав. Мөн анхны гэрлэлтийн дундаж насыг 2000 болон 2010 оны тооллогын үндээр үндэс угсаа, боловсролын төвшингөөр ялгаатай байгааг тогтоож, хүн амын эдийн засгийн идэвх, зарим голлох ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдаар тооцож, холбогдох дүгнэлтийг гаргасан. Түүнчлэн дэлхийн зарим орнуудын хүн амын анхны гэрлэлтийн дундаж насыг хүйсээр харуулав.

Зургаадугаар бүлэгт хүн амын гэрлэлтэнд өргөөр нөлөөлж байгаа зарим үзүүлэлтүүдийг хот, хөдөө, аймаг, нийслэлээр тодорхойлон гаргасан бөгөөд

үүнд хожуу гэрлэлт, гэр бүл цуцлалт, тусгаарлалт, бэлбэсрэлтийн талаар авч үзэв. Тооллогын үеэр огт гэрлээгүй байсан боловч цаашид гэрлэх боломжтой буюу хожуу гэрлэх магадлалтай хүн амын талаар болон салсан, тусгаарласан хүмүүсээс дахин гэрлэх магадлал багатай ахимаг насныхан, бэлбэсэн хүн амын талаарх мэдээллийг байршил, үндэс угсаагаар нь ангилан гаргаж судалснаас гадна дээрхүзүүлэлтэд хамаарах хүн амыг боловсрол, эдийн засгийн идэвх, зарим голлох ажил мэргэжил, эдийн засгийн ажиллагааны салбараар ангилж гаргав.

Долоодугаар бүлэгт гэр бүлийн хосуудыг нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээр зэрэгцүүлэн судалж, тооллогын үеийн үндэс угсаа, боловсрол, ажил мэргэжлээр нь ангилж, ямар боловсрол, ажил мэргэжлүүд х хоорондоо гэр бүл болон амьдарч байгааг гаргасан ба үүний зэрэгцээ гэр бүлийн хосуудын үндэс угсааны байдлыг зэрэгцүүлэн үзүүлж, зарим санал дүгнэлт өгсөн. Энэ бүлэгт гэр бүлийн хосуудыг шүтдэг шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн хосуудын талаарх мэдээллийг анх удаа шинээр оруулсан болно.

Наймдугаар бүлэгт сэдэвчилсэн судалгааны үр дүнгээр гарсан ерөнхий дүгнэлтүүд, бодлогын чанартай зөвлөмжүүдийг оруулав. Сүүлийн 4 тооллогын дүнд хийсэн харьцуулалт, шинжилгээнд тулгуурлан Монгол Улсын өрхийн тоо, бүтэц, өрхийн ам бүлийн нийт тоо болон дундаж тоонд гарсан өөрчлөлтүүдийг нэгтгэн дүгнэв. Үүний зэрэгцээ өрхийн тоо, ам бүлийн тоонд нөлөөлсөн зарим хүчин зүйлийг судалж, тэдгээрийн нөлөөллийн талаар дүгнэлт оруулав.

Хүн амын гэрлэлтийн байдлын талаар сүүлийн 4 тооллогын дүнд хийсэн шинжилгээнд тулгуурлан Монгол Улсын хүн амын гэрлэлтийн өнөөгийн байдал, гэрлэлтийн дундаж нас, тэдгээрт гарсан өөрчлөлтүүд, гэрлэлтийн ялгаатай байдлууд, үүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх санал үднэлтүүдийг оруулав.

Бүлгийн төгсгөлд энэхүү сэдэвчилсэн судалгаанд үндэслэн бодлогын чанартай зөвлөмжүүдийг бэлтгэж оруулав.

Мөн сэдэвчилсэн судалгаанд орсон гол гол үзүүлэлтүүдийг аймаг, нийслэлээр гаргаж хавсаргав.

БҮЛЭГ 4. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, БҮТЭЦ

2.1. Өрхийн тоо, хэлбэр

2010 оны тооллогоор Монгол Улсад нийт 713 780 тоологдсон нь 2000 оныхоос 31.9 хувиар их байна. Тоолсон нийлмэл өрхийн 62 хувийг ам бүлээрээ амьдарч байгаа өрх эзэлж б байна. Нийт өрхөд нийлмэл өрх 25 хувь, ганц бие өрх 11 хувь, харин холимог өрх 2 хувийг эзэлж байв.

Зураг 2.1. Өрхийн тоо, хэлбэрээр, 2010 он



2000 оныхтой харьцуулахад хот өрх 61.9 хувиар өсч, хөдөөгийн өрх 4.3 хувиар буурчээ. Энэ нөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой. Хөдөөд шинээр гэр бүл бологсод гэр барьж өрх тусгаарлан амьдардаг учир хоттой харьцуулахад хөдөөд ам бүлээрээ буюу эцэг, эх хүүхэд /хүүхдүүд/-тэйгээ амьдардаг өрхийн хувь их байна. Эн шалтгаанаар хөдөөд ганц бие өрх хотоос их байгаа юм.


Хүснэгт 2.1. Өрхийн тоо, хэлбэрээр, 2010 он

	Өрхийн хэлбэр									
	Бүгд									
	Өрх	Хүн ам	Ганц бие		Ам бүлээрээ		Нийлмэл ам бүл		Холимог ам бүл	
	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам
Бүгд	713 780	2 553 753	75 917	75 917	445 048	1 594 314	177 898	815 639	14 917	67 883
Хот	479 503	1 734 761	47 246	47 246	275 599	960 251	145 232	674 653	11 426	52 611
Хөдөө	234 277	818 992	28 671	28 671	169 449	634 063	32 666	140 986	3 491	15 272

Өмнөх тооллогоор нийлмэл буюу эцэг эх, ах дүүс, садан төрлөөрөө хамт амьдарч байгаа өрхийн тоо хотод хөдөөгөөс 2 дахин их байсан бол 2010 оны тооллогын дүнгээр 4.4 дахин их болсон байна. Нийлмэл өрхийн нийт өрхөд эзлэх хувь хотод хөдөөгөөс 2 илүү дахин их байна. Энэ нь орон нутгаас хот


газар суралцахаар болон бусад шалтгаанаар ирсэнүүс хамаатан саднаа бараадаж амьдардаг, хот, суурин газарт айр бусдаа орон сууцад суух боломж хязгаарлагдмал байдаг зэргээр тайлбарлагдана.

Зураг 2.2. Өрхийн тоо, хэлбэр, байршил, хувиар, 2010 он



Өрхөд ногдох хүн амын дундаж тоог өрхийн хэлбэрээр авч үзвэл ам бүлээрээ амьдардаг хөдөөгийн өрх дунджаар 3.74 буюу хотынхоос /3.48/ ялимгүй илүү байгаа нь хөдөөгийн айл арай олон хүүхэдтэй байдгийг харуулж байна. Харин нийлмэл болон холимог өрхийн хувьд хотынх нь дунджаар арай илүү олон хүнтэй байв.

Зураг 2.3. Өрхийн тоо, хэлбэр, ам бүл, хувиар, 2010 он



Улсын хэмжээнд 0-15 насны үүхэдгүй өрх нийт өрхийн 37.4 хувийг эзэлж байгаа бол Өв, Булган аймаг болон нийслэлд энэ хэмжээ хамгийн өндөр

байна. Эдгээр өрхөд огт хүүхэдгүй залуу голдуу гэр бүл болон хүүхэд нь 15-аас дээш настай өрх багтаж байгаа болно. Баян-Өлгий аймагт энэ үзүүлэлт бусад аймгаас нэлээд доогуур буюу 22.3 хувь байгаа нь энэ аймаг 2008 онд төрөлтийн хамгийн өндөр үзүүлэлттэй байснаар тайлбарлагдана.


Хүснэгт 2.2. Арван тав хүртэлх насны хүүхэдгүй өрхийн тоо ба хувь

Аймаг, нийслэл	Өрхийн тоо - Бүгд	0-15 насны хүүхэдгүй өрх	
		Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь
Бүгд	713 780	267 090	37.4
Архангай	24 551	9 190	37.4
Баян-Өлгий	19 225	4 290	22.3
Баянхонгор	21 695	7 797	35.9
Булган	15 807	6 295	39.8
Говь-Алтай	14 562	5 142	35.3
Дорноговь	16 543	6 268	37.9
Дорнод	18 895	6 908	36.6
Дундговь	10 895	3 936	36.1
Завхан	18 574	6 788	36.5
Өвөрхангай	28 051	9 565	34.1
Өмнөговь	14 939	5 734	38.4
Сүхбаатар	14 145	4 924	34.8
Сэлэнгэ	26 889	9 843	36.6
Төв	24 687	10 319	41.8
Увс	18 641	5 893	31.6
Ховд	18 944	5 724	30.2
Хөвсгөл	33 007	12 064	36.5
Хэнтий	19 147	7 195	37.6
Дархан-Уул	24 227	8 871	36.6
Улаанбаатар	302 242	120 176	39.8
Орхон	24 273	8 732	36.0
Говьсүмбэр	3 841	1 436	37.4

2.2. Үндсэн ба хамт суудаг өрх

Нийт 713.8 мянган өрхийн 688.0 мянга нь /96.4 хувь/ үндсэн өрх байгаагийн 459.6 мянга нь хотын, 228.4 мянга нь өдөөгийн өрх байна. 25.8 мянган хамт суудаг өрхийн 19.9 мянга нь хотод, 5.8 мянга нь өдөөд байна. Үндсэн өрхтэй харьцуулахад хамт суудаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь Дорнод, Дархан, Сэлэнгэд харьцангуй илүү байгааг дараах зургаас харж болно.

Зураг 2.4. Үндсэн ба хамт суудаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь, аймгаар



2.3. Ам бүлийн тоо

Улсын хэмжээнд өрхөд тоолсон хүн амын тоо 2553.8 мянга, өрхийн тоо 713.8 мянга байна. Нэг өрхөд дунджаар 3.6 хүн ногдож байна. Улсын хэмжээнд 3-4 хүнтэй өрхийн эзлэх хувь нийт өрхийн бараг тал хувийг буюу 47.1 хувийг эзэлж байна.

Нийт хүн амын 67.9 хувийг хотын хүн ам эзэлж байна. Хотын нэг өрхөд дунджаар 3.61 хүн ногдож байгаа нь улсын дунджаас ялимгүй их байна. Энэ нь хотод суугчдын тоо хөдөөгийнхөөс 2.12 дахин, өрхийн тоо нь 2.05 дахин олон буюу хүн амын тооны харьцаа өрхийн тооны харьцаанаас илүү байгаатай холбоотой юм. Хотод 3-4 хүнтэй өрх 47.9 хувийг эзлэж байна.

Нийт хүн амын 32.1 хувийг хөдөөгийн хүн ам эзэлж, хөдөөгийн нэг өрхөд дунджаар 3.5 хүн ногдож байна. Хөдөөд 3-4 хүнтэй өрх 46.1 хувийг эзэлж байна.

Өрхийн тэргүүний үндэс угсаагаар нийт өрхийн 82.1 хувийг Халх тэргүүлэгчтэй өрх, хотод 57.5 хувь, хөдөөд 24.6 хувь нь оршин сууж байна. Тооцоогоор нэг Халх тэргүүлэгчтэй өрхөд дунджаар 3.54 хүн ногдож байна гэсэн үг юм.

Казак тэргүүлэгчтэй өрх нийт өрхийн 3.2 хувь буюу 22.5 мянга байна. Казак тэргүүлэгчтэй өрхөд дунджаар 4.4 хүн ногдож байгаа бөгөөд улсын дунджаас харьцангуй олон байна. Хотын Казак тэргүүлэгчтэй өрхөд 4.2 хүн ногдож байгаа нь улсын хэмжээний дундаж зүүлэлтээс мөн олон байна. Хөдөөгийн Казак тэргүүлэгчтэй өрхийн 5.5 хувь, 12.8 мянган Казак тэргүүлэгчтэй өрх байгаа бөгөөд нэг Казак тэргүүлэгчтэй өрхөд 4.5 хүн ногдож байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Улсын хэмжээнд Дөрвөд, Баяд, Урианхай, Захчин, Дарьганга, Буриадчууд нийт хүн амын 1-3 орчим хувийг үлдүүлж байхад харин Дархад, Хотгойд, Өөлд, Торгууд, Хотон, Мянгад, Барга, Үзэмчин, Тувагууд хүн амын 0.11-0.84 хувийг эзэлж байна. Нийт хүн амын 0.05 хурт хувийг эзэлж буй бусад монгол угсаатнуудын нэг өрхөд ногдох ам бүлийн тоо улсын дунджийн орчим байна.

2.4. Ганц бие өрх

2010 оны тооллогын дүнгээр ганц бие өрх 75.9 мянга байгаагаас 65-аас дээш болон 20-29 насны хүн ам 42.4 хувийг эзэлж байна. 20-24 насны ганц бие хүн ам хот, хөдөөгийн байдлаар ялгавартай байна. Энэ насны ажилгүй иргэд хотод 25-29 насны ганц бие хүн амаас 2 дахин их байгаа бол хөдөөд харин эсрэгээрээ бага байлаа. Тухайн насныханд хотод сурч боловсрох боломж илүү байдгаас энэ зөрүү их байна.

Хүснэгт 2.3 -аас харахад, ганц бие өрхийн тэргүүлэгчид 20-54 насандаа ажил их эрхэлдэг байна. Тэдний ажил эрхлэлт хөдөөд 50-54 наснаас буурч байгаа бол хотод арай хожуу буюу 55-59 наснаас эхлэн буурч байлаа.

Хүснэгт 2.3. Арван тав, түүнээс дээш насны ганц бие өрхийн тоо, тэргүүлэгчийн нас, ажил эрхлэлтийн байдлаар, 2010 он

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил эрхэлдэггүй	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил эрхэлдэггүй	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил эрхэлдэггүй
Бүгд	75 876	32 237	43 639	47 209	20 567	26 642	28 667	11 670	16 997
15-19	2 335	364	1 971	1 948	182	1 766	387	182	205
20-24	7 690	4 433	3 257	5 322	2 635	2 687	2 368	1 798	570
25-29	7 449	5 332	2 117	4 892	3 502	1 390	2 557	1 830	727
30-34	6 347	4 306	2 041	4 184	2 869	1 315	2 163	1 437	726
35-39	5 930	3 718	2 212	4 007	2 518	1 489	1 923	1 200	723
40-44	6 235	3 734	2 501	4 101	2 474	1 627	2 134	1 260	874
45-49	6 960	4 114	2 846	4 578	2 688	1 890	2 382	1 426	956
50-54	6 295	3 342	2 953	4 026	2 122	1 904	2 269	1 220	1 049
55-59	5 049	1 620	3 429	3 074	967	2 107	1 975	653	1 322
60-64	4 522	614	3 908	2 611	344	2 267	1 911	270	1 641
65,+	17 064	660	16 404	8 466	266	8 200	8 598	394	8 204

Ганц биеэрхийн тэргүүлэгчдийг боловсролын байдлаар үзвэл, бүрэн дунд боловсролтой хүмүүс их байгаа бөгөөд үүний дараа дээд, бага болон суурь боловсролтой хүмүүс орж байна.


Хүснэгт 2.4. Арван тав, түүнээс дээш насны ганц бие өрхийн тоо, тэргүүлэгчийн нас, боловсролын байдлаар, 2010 он

Насны бүлэг	Бүгд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техник болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр	Доктор
Бүгд	75 876	7 466	13 291	11 527	19 429	2 061	5 487	14 583	1 781	251
15-19	2 335	69	125	582	1 428	67	32	32	0	0
20-24	7 690	314	489	727	3 416	161	224	2 299	60	0
25-29	7 449	541	731	923	1 830	95	132	2 889	304	4
30-34	6 347	339	727	1 191	1 780	76	139	1 749	330	16
35-39	5 930	224	279	1 319	2 141	214	347	1 173	215	18
40-44	6 235	344	326	1 274	2 158	293	616	990	211	23
45-49	6 960	475	512	1 272	1 936	337	836	1 314	245	33
50-54	6 295	347	707	1 240	1 441	279	795	1 222	214	50
55-59	5 049	313	1 026	877	1 025	178	636	869	102	23
60-64	4 522	340	1 231	644	762	111	620	725	60	29
65,+	17 064	4 160	7 138	1 478	1 512	250	1 110	1 321	40	55

Бага боловсролтой хүмүүс 55-аас дээш насанд ганц бие байх нь их байдаг бол дээд боловсролтой хүмүүс энэ насандаа ганцаар өрх толгойлох нь харьцангуй бага байгаа нь нас баралтын төвшин, дахин гэр бүл болох магадлал боловсролын төвшингөөр ялгаатай байдагтай холбоотой. Дээд боловсролтой хүмүүс 25-29 насандаа ганц бие байх нь их байна.

Залуу насныхны дараа гэрлэж өрх үүсгэх магадлалтай 35 -49 настай хүмүүсийг шинжилвэл, бүрэн дунд боловсролтой хүмүүс ганц биеэр өрх толгойлох нь хамгийн их, дараа нь дээд болон суурь боловсролтой хүмүүс орж байна. Аль ч насны бүлэгт суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүсээс бусад 45 -49 насны хүмүүс ганц бие өрхийн тэргүүн байх нь их байв.


Зураг 2.5. Ганц бие өрхийн 35-49 насны тэргүүлэгчдийн тоо, боловсролын байдлаар, 2010 он



2.5. Олон ам бүлтэй өрх

2010 онд олон ам бүлтэй өрх буюу 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх 13 мянга тоологдсон нь нийт өрхийн 1.8 хувийг эзэлж байна.

Зураг 2.6. Олон ам бүлтэй өрхийн тоо, хот, хөдөө, хувиар, 2010 он




Олон ам бүлтэй өрхийн 80 хувь нь хотод, 20 хувь нь хөдөөд байна.

Хүснэгт 2.5. Олон ам бүлтэй өрхийн тоо, аймаг, нийслэл, хувиар, 2010 он

Аймаг, нийслэл	Өрхийн тоо - Бүгд	Олон ам бүлтэй өрх	
		Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь
Алба	713 780	12 996	1.8
Àððàí ààé	24 551	118	0.5
Áàýí -à èèé	19 225	694	3.6
Áàýí òí í ã ð	21 695	177	0.8
Áóèàí àéì àã	15 807	84	0.5
Äî àü-Àèðàé	14 562	109	0.8
Äî òí í ã àü	16 543	191	1.2
Äî òí í ä	18 895	363	1.9
Äóí äã àü	10 895	122	1.1
Çààðàí	18 574	116	0.6
à ã ððàí ààé	28 051	270	1.0
à ì í ã àü	14 939	139	0.9
Ñçðàààðð	14 145	147	1.0
Ñýýýí äý	26 889	349	1.3
Ò à	24 687	174	0.7
Óàñ	18 641	364	2.0
Õ àä	18 944	422	2.2
Õ àñã è	33 007	293	0.9
Õýí òèé	19 147	196	1.0
Äàððàí -Óéè	24 227	377	1.6
Óèààí áààðð	302 242	7 885	2.6
Î ðòí í	24 273	353	1.5
Äî àüñçì áýð	3 841	53	1.4

Олон ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгууд болон нийслэлд улсын дунджаас дээгүүр, Баян -Өлгий аймагт бүр 2 дахин их байв. Олон ам бүлтэй өрхийн дунд үндсэн өрх зонхилж байсан юм. Хамт суудаг өрх хотод хөдөөгөөс харьцангуй өндөр байгааг дараах хүснэгтээс харж болно.

Зураг 2.7. Олон ам бүлтэй өрхийн тоо, тэргүүлэгчийн боловсролын байдлаар, 2010 он



Олон ам бүлтэй хотын өрхүүдийн дотор бүрэн дунд боловсролтой өрхийн тэргүүлэгчтэй өрх хамгийн олон байгаа бол хөдөөд бага болон суурь боловсролтой өрх олон байна.

2.6. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх

Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 153.6 мянга тоологдсоноос 75 хувь нь хотод, 25 хувь нь өдөөд байна. Эдгээр өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин улсын хэмжээгээр 21.5 хувь, Улаанбаатар хот, Дархан, Дорнод, Өмнөговь аймгууд энэ үзүүлэлтээс өндөр хувьтай байлаа. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд 2 ам бүлтэй өрх илүү олон байсан бол Улаанбаатар хот, Дархан, Орхон, Дорнод аймгуудад 3 ам бүлтэй өрх олон, бусад аймгуудад ганц бие өрх голлож байна. Энэ нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн дунд 1-2 хүүхэдтэй ба ганц бие эмэгтэйчүүд их байна гэсэн үг юм. Эмэгтэй тэргүүлэгчтэй ганц бие өрхийн олонх нь тэтгэврийн насныхан байгаа юм.

Нийт эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд хөгжлийн бэрхшээлтэй гишүүдтэй өрх 13.8 хувийг эзэлж байна. Харин Хөвсгөл, Сүхбаатар, Хэнтий аймгуудад энэ үзүүлэлт 20 буюу түүнээс дээш хувьтай байгаа нь анхаарвал зохих асуудлын нэг юм.

Хүснэгт 2.6. Эмэгтэй тэргүүлэгчтэй, хөгжлийн бэрхшээлтэй гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, хувиар, 2010 он

	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх				Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдтэй өрхийн бүгдэд эзлэх хувь
	Бүгд	Хот	Хөдөө	Нийт өрхөд эзлэх хувь	
Бүгд	153 556	115 233	38 323	21.5	13.8
Архангай	4 143	1 273	2 870	16.9	15.8
Баян-Өлгий	2 113	915	1 198	11.0	17.8
Баянхонгор	4 460	2 032	2 428	20.6	16.5
Булган аймаг	2 308	798	1 510	14.6	13.7
Говь-Алтай	2 499	941	1 558	17.2	17.1
Дорноговь	3 485	2 058	1 427	21.1	13.9
Дорнод	4 309	2 786	1 523	22.8	18.4
Дундговь	1 966	821	1 145	18.0	16.1
Завхан	3 280	1 004	2 276	17.7	14.8
Өвөрхангай	4 674	2 140	2 534	16.7	15.4
Өмнөговь	3 341	1 452	1 889	22.4	14.4
Сүхбаатар	1 997	674	1 323	14.1	20.3
Сэлэнгэ	5 374	2 924	2 450	20.0	16.5
Төв	4 372	921	3 451	17.7	13.7
Увс	2 966	1 309	1 657	15.9	18.5
Ховд	3 092	1 412	1 680	16.3	16.9
Хөвсгөл	7 082	2 752	4 330	21.5	21.1
Хэнтий	4 072	2 121	1 951	21.3	19.7
Дархан-Уул	5 584	4 826	758	23.0	13.3
Улаанбаатар	76 688	76 688	0	25.4	11.3
Орхон	4 910	4 742	168	20.2	13.0
Говьсүмбэр	841	644	197	21.9	12.2

Өрх толгойлсон эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийг тэргүүлэгчийнх нь эдийн засгийн идэвхээр ангилжүзвэл эдийн засгийн идэвхтэй нийт эмэгтэй тэргүүлэгч 49.3 хувь байгаагийн дотор энэ үзүүлэлт хот хөдөөд төдийлөн ялгаагүй байна. Эмэгтэй тэргүүлэгчдийн дотор 50.7 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн амд хамаарч, тэтгэврийн насны эмэгтэйд зонхилж, гэрийн ажилтай эмэгтэйчүүдийнх удаалж байлаа.

**Хүснэгт 2.7. Өрх толгойлсон эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо,
тэргүүлэгчийнх нь эдийн засгийн идэвх, хот, хөдөөгөөр, 2010 он**

	Бүгд		Хот		Хөдөө	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	69 158	100	50 439	100	18 719	100
Эдийн засгийн идэвхтэй хүн ам - Бүгд	34 066	49.3	24 723	49.0	9 343	49.9
Ажил эрхэлдэг	29 864	43.2	21 847	43.3	8 017	42.8
Ажил хайж байгаа	4 202		2 876		1 326	
Эдийн засгийн идэвхгүй хүн ам - Бүгд	35 092	50.7	25 716	51.0	9 376	50.1
Тохирох ажил олдохгүй байгаа	4 350		3 186		1 164	
Сургуульд сурдаг	367		337		30	
Тэтгэвэрт	21 693		15 653		6 040	
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	2 857		2 065		792	
Гэрийн ажилтай	4 473		3 367		1 106	
Ажиллах сонирхолгүй	86		65		21	
Бусад	1 266		1 043		223	

БҮЛЭГ 5. ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТООНД НӨЛӨӨЛСӨН ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛС

Өмнөх бүлэгт өрхийн тоо, хэлбэр, түүний бүтцэд гарсан өөрчлөлтүүдийн талаар дэлгэрэнгүй авч үзсэн. Харин энэхүү бүлэгт өрхийн тоо, ам бүлийн тоонд нөлөөлсөн зарим хүчин зүйлсийн талаар хөндлөө.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа суурин хүн амын 95.6 хувь нь өрхөд, 3.5 хувь нь өрхөд хамааралгүйгээр тоологджээ. Өрхөд хамаарахгүй хүмүүст цэрэг, хоригдол, оюутнууд, албан болон албан бусаар ашигт малтмал олборлогчид, орон гэрүй иргэд зонхилж байна.

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн төвшин, хүмүүсийн боловсрол, үндэс угсаа, үндэстний соёл, зан заншил, ажил эрхлэлтийн байдал, хот, суурин газар уруу чиглэсэн шилжих хөдөлгөөн, уул уурхай зэрэг эрчимтэй хөгжиж эхэлсэн шинэ салбаруудыг дагасан шилжих хөдөлгөөн, төрөөс явуулсан нийгмийн халамжийн болон бусад бодлогын дүнд өрхийн ам бүлийн тоо, бүтцэд өөрчлөлт орсоор иржээ.

3.1. Хүн амын тоо, насны бүтэц болон өрхийн тооны хамаарал

Өрхийн тоо нь нэг талаасаа насанд хүрсэн хүн амын тооноос, нөгөө талаасаа гэр бүлийн байдлаас шууд хамааралтай билээ.

Хүснэгт 3.1. Хүн ам, өрхийн тоо, түүний өсөлт

	Суурин хүн амын тоо, мянга	Өрхийн тоо, мянга	Нэг өрхөд ногдох хүн амын тоо
1963	1017.1	235.2	4.3
1969	1197.6	252.3	4.7
1979	1595.0	311.0	5.1
1989	2044.0	427.8	4.8
2000	2373.5	541.1	4.4
2010	2647.5	713.8	3.7
2010/1963	2.6 дах	3.03 дах	

Хүснэгт 3.1–ээс харахад 1963-2010 оны хооронд 44 жилд хүн амын тоо 2.6 дахин нэмэгдсэн байхад өрхийн тоо 3 дахин буюу илүү хурдан өсчээ. Өмнөх тооллогуудтай зэрэгцэхүйц байдлыг хадгалах зорилгоор суурин хүн амын тоонд гадаадад байгаа монголчуудыг оруулав. Үүний зэрэгцээ нийт хүн амын тоонд өрхөд тоологдоогүй хүмүүс орсон байгаа тул дээрх хүснэгтийн нэг өрхөд ногдох хүн амын тоо өрхийн дундаж ам бүлийн тооноос өндөр өөр үзүүлэлт болно.

Бүлэг 5-д анхны гэрлэлтийн дундаж нас өмнөх тооллогынхоос бага зэрэг нэмэгдсэнийг дурдсан. Энэ тохиодолд залуучуудын үйлгэрлэх нь хойшлогдож байхад өрхийн тоо хүн амын тооноос хурдан нэмэгдсэн нь анхаарал татаж байна.

Дээрх хүснэгтээс харахад сүүлчийн 2 тооллогын дүнгээр нэг өрхөд ногдох хүн амын тоо буурсан байна.

Хүн амын насны бүтэц өрхийн тоонд хэрхэн нөлөөлснийг илрүүлэх зорилгоор сүүлийн 5 тооллогоор 15-аас дээш насны хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3.2. Хүн амын насны бүтэц

	Нийт хүн ам		0-14 насны хүүхэд		15-аас дээш насны хүн ам	
	Мянга	Дүн	Мянга	Дүнд эзлэх хувь	Мянга	Дүнд эзлэх хувь
1963	1 017.1	100	396.8	39.0	620.3	61.0
1969	1 197.6	100	532.4	44.4	665.2	55.6
1979	1 595.0	100	706.2	44.3	888.8	55.7
1989	2 044.0	100	855.7	41.9	1 188.3	58.1
2000	2 373.5	100	849.1	35.8	1 524.4	64.2
2010	2 647.5	100	741.6	28.0	1 905.9	72.0
2010/1963	2.6		1.87		3.1	

Хүснэгт 3.2-оос харахад үүлийн 3 тооллогоор нийт хүн амд 0 -14 насны хүүхүүдийн эзлэх хувь буурч, харин 15-аас дээш насны хүн амын эзлэх хувь нэмэгджээ. Эндээс гэрлэх боломжтой насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь нэмэгдсэн нь өрхийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн байж болзошгүй байна. Мөн 1963-2010 оны хооронд 0-14 насны хүүхдийн тоо 1.8 дахин өссөн бол 15 -аас дээш насны хүн амын тоо 3.1 дахин нэмэгджээ. Өрхийн тоо хүн амынхаа тооноос хурдан нэмэгдсэн нь 2008 оны сонгуулиар амласны дагуу шинэ гэр бүлд 500 мянган өгрөгийн урамшуулал олгож байсантай зарим талаар холбоотойгоор залуу гэр бүлийн тоо өссөнийг энэ бүлгийн төгсгөлд харуулсан.

3.2. Боловсролын төвшин өрхийн ам бүлийн тоонд нөлөөлсөн байдал

Судалгааны энэ хэсэгт хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр эхнэр, нөхрийн боловсролын төвшин өрхийн ам бүлийн тоонд нөлөөлж байгаа эсэхийг тодруулах зорилт тавьсан.

Хүснэгт 3.3. Өрхийн тоо, эхнэрийн боловсролын төвшин ба өрхийн ам бүлийн тоогоор, хувиар, 2010 он

Эхнэрийн боловсролын түвшин	Өрхийн тоо	Ам бүлийн тоо						
		2	3	4	5	6	7	8 ба түүнээс дээш
Бүгд	100	11.2	25.1	30.6	18.8	8.9	3.2	2.1
Боловсролгүй	100	17.1	25.1	27.7	16.5	8.1	3.5	1.9
Бага	100	17.6	22.9	26.6	17.6	9.5	3.5	2.3
Бүрэн бус дунд	100	9.8	20.0	29.5	22.2	11.6	4.4	2.5
Бүрэн дунд	100	8.8	23.7	31.5	20.3	9.7	3.5	2.4
Техник мэргэжлийн	100	10.7	23.2	29.1	20.0	10.5	4.0	2.6
Тусгай мэргэжлийн дунд	100	15.3	24.7	27.6	17.9	8.7	3.4	2.4
Дээд	100	11.2	31.4	33.0	15.6	5.8	1.9	1.2

Хүснэгт 3.3-аас харахад эхнэрийн боловсролыг өмнөх өндөр байх тусам тухайн өрхийн ам бүлийн тоо цөөн байх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, эхнэр нь дээд боловсролтой 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь дөнгөж 1.2 байхад эхнэр нь багаас тусгай мэргэжлийн дунд хүртэлх боловсролтой 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн эзлэх хувь 2.3–2.5 хувь байна. Эсрэгээрээ эхнэр нь дээд боловсролтой 3 ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 31.4 хувь байхад эхнэр нь бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой өрхийн нийт өрхөд эзлэх хувь маш бага 8.8-9.8 хувь байна.

Дээд боловсролтой эхнэртэй нийт өрхийн 64 хувь нь 3 -4 хүүхэдтэй байхад эхнэр нь бага болон бүрэн бус дунд боловсролтой нийт өрхийн 49.5 хувь нь 3-4 хүүхэдтэй байна.

Хүснэгт 3.4. Өрхийн тоо, нөхрийн боловсролын төвшин ба өрхийн ам бүлийн тоо, хувиар, 2010 он

Нөхрийн боловсролын түвшин	Өрхийн тоо	Ам бүлийн тоо						
		2	3	4	5	6	7	8 ба түүнээс дээш
Бүгд	100	13.1	23.7	25.6	17.3	11.6	4.4	4.3
Боловсролгүй	100	11.8	18.2	28.2	19.1	11.8	6.4	4.5
Бага	100	16.7	25.8	22.2	14.4	9.8	6.2	4.9
Бүрэн бус дунд	100	8.9	19.2	28.4	19.6	13.6	4.9	5.5
Бүрэн дунд	100	11.6	23.4	25.5	18.1	12.3	4.5	4.6
Техник мэргэжлийн	100	12.3	22.5	22.5	21.9	14.4	3.2	3.2
Тусгай мэргэжлийн дунд	100	12.9	27.5	25.1	14.9	11.2	4.7	3.7
Дээд	100	18.1	26.7	25.1	14.7	9.2	3.2	2.9

Дээрх чиг хандлага өрхийн боловсролтой холбоотой мөн ажиглагдаж байна. Тухайлбал, нөхөр нь дээд боловсролтой 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2.9 байхад нөхөр нь багаас тусгай мэргэжлийн дунд хүртэлх боловсролтой 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн эзлэх хувь 3.2-5.5 хувь байна.

Хоёр ам бүлтэй өрхийн эзлэх хувь нөхөр нь дээд боловсролтой өрхийн хувьд хамгийн өндөр байна.

3.3. Үндэс угсаа, өрхийн ам бүлийн тооны ялгаатай байдал

Монгол Улсын өрхийн ам бүлийн тоо үндэс угсааны соёл, зан заншил, түүхэн уламжлалын онцлогоос шалтгаалан ялгаатай байгаа нь дорноддээс харагдаж байна. Монгол Улсад байнга оршин сууж байгаа гадаадын харьяат өрхүүдийн 61.2 хувь нь 1-2 ам бүлтэй байхад монгол өрхүүдийн 27 хувь нь л 1-2 ам бүлтэй байна.

Монгол Улсын зарим үндэс угсаатны өрхийн ам бүлийн тоо улсын дунджаас дээгүүр, олон ам бүлтэй байна. Тухайлбал, Монгол Улсын дунджаар нийт өрхийн 26 хувь нь 5 болон түүнээс дээш ам бүлтэй байхад казак өрхүүдийн 45.7 хувь, хотон өрхийн 40.9 хувь, захчин, тува өрхийн 33.2 -33.6 хувь нь 5 болон түүнээс дээш ам бүлтэй байна.

Хүснэгт 3.5. Өрхийн тоо, тэргүүлэгчийн үндэс угсаа, ам бүлийн тоо, хувиар, 2010 он

Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа	Бүгд	Өрхийн ам бүлийн тоогоор									
		1	2	3	4	5	6	7	8	9	10
Бүгд	713 780	10.6	16.1	23.2	24.1	14.6	7.0	2.6	1.1	0.4	0.3
Халх	586 611	10.8	16.3	23.7	24.3	14.2	6.5	2.3	1.0	0.4	0.3
Казак	22 498	3.9	10.1	17.9	22.4	19.8	14.5	7.4	2.8	0.8	0.4
Дөрвөд	19 496	8.6	14.8	21.0	23.8	16.8	9.3	3.6	1.3	0.4	0.4
Буриад	13 533	13.3	18.3	22.3	21.4	13.5	6.9	2.4	1.1	0.4	0.3
Баяд	15 288	8.9	14.8	21.3	22.8	17.3	9.4	3.7	1.2	0.4	0.3
Дарьганга	8 088	8.5	16.5	25.0	25.7	15.4	6.0	1.9	0.7	0.2	0.1
Урианхай	7 447	10.2	15.4	22.2	22.8	15.9	8.6	3.0	1.1	0.5	0.2
Захчин	8 760	9.5	13.5	21.1	22.4	17.4	9.8	3.9	1.6	0.5	0.4
Дархад	6 012	12.3	15.1	22.3	23.2	15.2	7.6	2.5	1.0	0.4	0.3
Торгууд	3 972	9.8	13.9	22.2	25.0	16.9	7.6	2.8	1.2	0.4	0.2
Өөлд	4 730	12.0	16.3	22.5	24.3	14.5	6.7	2.2	1.1	0.3	0.2
Хотон	2 671	8.5	11.5	18.3	20.7	14.8	13.8	6.8	3.6	1.4	0.6
Мянгад	1 789	8.6	14.3	20.2	23.1	18.3	9.1	3.4	1.8	0.7	0.3
Барга	917	11.6	15.4	23.7	23.6	13.5	7.0	2.8	1.2	1.0	0.3
Үзэмчин	775	10.3	15.5	23.4	23.4	17.3	6.5	2.3	1.0	0.0	0.4
Харчин	55	16.4	10.9	32.7	23.6	7.3	3.6	3.6	0.0	1.8	0.0
Цахар	47	36.2	10.6	21.3	12.8	10.6	6.4	2.1	0.0	0.0	0.0
Хотогойд	4 715	11.4	17.1	23.4	25.8	14.1	5.6	1.7	0.5	0.2	0.1
Элжигэн	361	10.5	15.2	22.4	25.2	16.9	6.1	1.9	1.4	0.3	0.0
Цаатан	90	11.1	14.4	22.2	28.9	11.1	3.3	5.6	2.2	0.0	1.1
Сартуул	405	9.9	18.3	22.7	25.2	14.3	6.2	2.2	0.7	0.2	0.2
Тува	1 348	7.6	15.6	20.4	23.3	16.3	9.3	4.7	1.7	0.8	0.3
Хорчин	36	11.1	25.0	13.9	19.4	22.2	5.6	2.8	0.0	0.0	0.0
Узбек (Чантуу)	71	8.5	8.5	26.8	26.8	14.1	8.5	4.2	2.8	0.0	0.0
Халимаг	11	9.1	9.1	18.2	18.2	18.2	18.2	0.0	9.1	0.0	0.0
Түмэд	3	0.0	33.3	33.3	0.0	33.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
Сөнөд	5	20.0	0.0	40.0	0.0	40.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хамниган	167	18.0	22.2	22.8	15.0	12.0	7.8	1.8	0.0	0.6	0.0
Хошууд	28	17.9	7.1	10.7	14.3	32.1	17.9	0.0	0.0	0.0	0.0
Монголын харьяат бусад ястан	119	13.4	17.6	22.7	21.0	12.6	5.9	4.2	1.7	0.0	0.8
Орос (Монголын харьяат)	29	10.3	27.6	27.6	10.3	13.8	3.4	6.9	0.0	0.0	0.0
Хятад (Монголын харьяат)	50	14.0	14.0	24.0	28.0	10.0	4.0	4.0	2.0	0.0	0.0
Бусад гадаад (Монголын харьяат)	102	12.7	20.6	16.7	28.4	10.8	4.9	2.9	2.9	0.0	0.0
Гадаадын харьяат	3 507	34.3	26.9	16.3	13.9	5.0	2.1	0.8	0.4	0.1	0.2
Харьяалалгүй	44	40.9	4.5	20.5	11.4	15.9	6.8	0.0	0.0	0.0	0.0

Харин харчин, сахар, хотгойд өрхүүдийн 16.4-22.3 хувь нь 5 болон түүнээс дээш ам бүлтэй байгаа нь улсын дунджаас нэлээн доогуур, харьцангуй цөөхүүлээ амьдардаг байна. Нэг ам бүлтэй өрх сахар өрхүүдийн дотор 36.2 хувь байгаа нь улсын дунджаас (10.6%) 3 дахин өндөр байна. Гэтэл казак өрхүүдийн дотор нэг ам бүлтэй өрх дөнгөж 3.9 хувь байгаа юм.

Долоо ба түүнээс дээш ам бүлтэй өрхүүдийн хувьд байдал дээрхтэй төстэй байна. Тухайлбал, Монгол Улсын дунджаар нийт өрхийн 4.4 хувь нь 7 болон түүнээс дээш ам бүлтэй байхад казак өрхүүдийн 11.4 хувь, хотон өрхийн 12.3 хувь, мөн захчин, тува өрхийн 6.3-7.5 хувь нь 7 болон түүнээс дээш ам бүлтэй байна.

3.4. Өрхийн хөдөлмөр эрхэлдэггүй, ажилгүй гишүүдийн тоо ба өрхийн ам бүлийн тооны хамаарал

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 713.8 мянган өрх тоологдсоны 519.3 мянга буюу нийт өрхийн 72.8 хувь нь хөдөлмөр эрхлээгүй наад зах нь нэг гишүүнтэй байжээ. Гэхдээ энэ нь бүгд ажилгүйчүүд гэсэн үг биш бөгөөд энд эдийн засгийн идэвхгүй хүн ам, үүний дотор оюутан сурагчид, хөдөлмөрийн чадваргүй, гэрийн ажилтай, өндөр настан, өвчтөн асардаг хүмүүс орсон болно.

Хүснэгт 3.6-аас харахад өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн тоо нэмэгддэг зүй тогтол харагдаж байна. Улсын дунджаар нийт өрхийн 72.8 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй наад зах нь нэг гишүүнтэй байгааг бид дээр дурдсан. Гэтэл энэхүү хувь ам бүлийн тоо нэг байхад 57.5 хувь байсан бол 2 үүнтэй болоход дунджаар 67.9 хувь, 3 гишүүнтэй болоход дунджаар 69.9 хувь гэх мэтээр тасралтгүй өсч байна.

Хүснэгт 3.6. Өрхийн тоо, ам бүлийн тоо болон сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй гишүүдийн тоогоор, 2010 он

Өрхийн ам бүлийн гишүүний тоо	Өрхийн тоо-Бүгд	Хөдөлмөр эрхэлдэггүй гишүүнтэй өрх		Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй гишүүний тоогоор				
		Тоо	Бүгдэд эзлэх хувь	1	2	3	4	5 +
Бүгд	713 780	519 339	72.8	245 188	170 844	68 463	24 712	10 162
1	75 917	43 639	57.5	43 639				
2	114 642	77 861	67.9	41 398	36 463			
3	165 873	115 898	69.9	60 080	41 157	14 661		
4	171 733	124 240	72.3	56 272	43 861	18 688	5 419	
5	103 933	83 742	80.6	29 142	29 015	16 957	6 993	1 635
6	50 085	44 119	88.1	10 722	13 707	10 793	6 243	2 654
7	18 601	17 270	92.8	2 831	4 466	4 541	3 260	2 172
8	7 693	7 368	95.8	824	1 528	1 799	1 596	1 621
9	2 941	2 865	97.4	216	417	642	689	901
10	1 338	1 324	99.0	50	165	233	318	558
11	529	521	98.5	10	41	94	108	268
12	259	258	99.6	4	17	42	45	150
13	109	107	98.2		3	7	20	77
14	74	74	100		2	4	5	63
15,+	53	53	100		1	2	10	40

Өрхийн ам бүлийн тоо 7 түүнээс дээш болоод ирэхэд хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 90-ээс дээш гарч байна. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам өрхийн хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн тоо нэмэгдэх магадлал өндөр байна.

Хөдөлмөр эрхэлдэггүй гишүүнтэй нийт 519.3 мянган өрхийн 47.2 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй нэг гишүүнтэй, 32.9 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй хоёр гишүүнтэй, 13.2 хувь нь ийм 3 гишүүнтэй байна.

Хүснэгт 3.7. Өрхийн тоо, ам бүлийн тоо болон сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй хүний тоогоор, хувиар, 2010 он

Ам бүлийн тоо	Өрхийн тоо		Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй хүний тоогоор									
	Бүгд	Хувь	1	2	3	4	5	6	7	8	9	10,+
Бүгд	713 780	100	34.4	23.9	9.6	3.5	1.0	0.3	0.1	0.0	0.0	0.0
1	75 917	100	57.5									
2	114 642	100	36.1	31.8								
3	165 873	100	36.2	24.8	8.8							
4	171 733	100	32.8	25.5	10.9	3.2						
5	103 933	100	28.0	27.9	16.3	6.7	1.6					
6	50 085	100	21.4	27.4	21.5	12.5	4.4	0.9				
7	18 601	100	15.2	24.0	24.4	17.5	8.6	2.6	0.5			
8	7 693	100	10.7	19.9	23.4	20.7	13.4	5.7	1.7	0.3		
9	2 941	100	7.3	14.2	21.8	23.4	16.9	8.6	3.8	1.1	0.2	
10	1 338	100	3.7	12.3	17.4	23.8	19.3	11.9	6.9	2.7	0.6	0.4
11	529	100	1.9	7.8	17.8	20.4	23.1	13.2	8.7	4.2	0.9	0.6
12	259	100	1.5	6.6	16.2	17.4	18.5	14.7	13.1	5.8	4.6	1.2
13	109	100	0.0	2.8	6.4	18.3	18.3	18.3	18.3	9.2	4.6	1.8
14	74	100	0.0	2.7	5.4	6.8	13.5	25.7	21.6	13.5	6.8	4.1
15	23	100	0.0	0.0	8.7	17.4	17.4	8.7	13.0	13.0	8.7	13.0
16+	30	100	0.0	3.3	0.0	20.0	20.0	6.7	16.7	6.7	13.3	13.3


Хүснэгт 3.7–гоос харахад 2010 онд тоологдсон нийт 713.8 мянгажрхийн 34.4 хувь нь тооллогын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй 1 гишүүнтэй, 23.9 хувь нь ийм 2 гишүүнтэй, 9.6 хувь нь өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй 3 гишүүнтэй байжээ. Ер нь манай оронд ажилгүйдэл айл өрхүүдийн дунд газар авсныг харуулж байна.

3.5. Шинээр төрсөн хүүхэд, гэр бүлд олгосон мөнгөний нөлөөлөл

2008 оны Улсын Их Хурлын сонгуульд тэр үеийн МАХН, одоогийн МАН өрсөлдөхдөө шинээр гэр бүл бологсдод 500 мянган төгрөгийн тэтгэмжийг төрөөс олгоно гэж амласан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 11 сарын 21–ний 35 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны өтөлбөр т “Шинээр гэр бүл бологсод, нийт болон шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж, тэтгэмжийг үргэлжлүүлэн олгоно” гэж заасан байна. Энэ дагуу 2011 оныг хүртэл шинээр гэр бүл бологсдод дээрх хэмжээний тэтгэлгийг олгосоор иржээ. Энэхүү тэтгэмж нь өрхийн тооны өсөлтөд мэдэгдэхүйц нөлөөлснийг доорх хүснэгт, зургаас харж болно.

Зураг 3.1. Өрхийн тоо



Зураг болон хүснэгтээс харахад 2008 оноос өрхийн тоо эрс нэмэгдэж, өмнөх жилүүдэд нь 14-21 мянгаар нэмэгдэж байсан өрхийн тоо 2008 онд даруй 32.1 мянгаар, 2009 онд 38.7 мянгаар өсчээ. Энэхүү тэтгэмжийг авахаар залуучууд өмнөх жилүүдтэй харьцуулбал олноороо гэр бүл болсон нь харагдаж байна. Харин уг тэтгэмжийг 2010 оноос зогсоосны дараа өрхийн тооны цэвэр өсөлт эргээд буурчээ.

2010 онд өрхийн тоог хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор бус, статистикийн эмхтгэлд тухайн үед нийтлэгдсэн тоогоор авлаа.

Хүснэгт 3.8. Өрхийн тоо, түүний өсөлт

Он	Өрхийн тоо, мянга	Цэвэр өсөлт, мянга
2004	596.4	
2005	611.0	14.6
2006	632.5	21.5
2007	645.7	13.2
2008	677.8	32.1
2009	716.5	38.7
2010	742.3	25.8

Эх үүсвэр: ҮСХ, Статистикийн эмхтгэл 2007, 2010 он

Шинэ гэр бүлийн тэтгэмжийг авахаар залуучууд өмнөх жилүүдтэй харьцуулбал олноороо гэр бүл болсон гэсэн дүгнэлтийг нотлохын тулд гэр бүл болох, гэр бүл цуцлалтын тооны өөрчлөлтийг авч үзэв.

Хүснэгт 3.9. Гэрлэлт, цуцлалтын тоо, түүний өөрчлөлт

Он	Гэрлэлтийн тоо	Цуцлалтын тоо	Жил бүрийн цэвэр өсөлт, бууралтын хэмжээ	
			гэрлэлт	цуцлалт
2003	13 514	688		
2003	14 572	884	1 058	196
2004	11 242	1 098	- 3 330	214
2005	14 993	1 622	3 751	524
2006	48 996	1 448	34 003	- 174
2007	40 965	1 757	- 8 031	309
2008	32 982	1 901	- 7 983	144
2009	34 071	2 399	1 089	498
2010	9 349	3 054	- 24 722	655

Эх үүсвэр: ҮСХ, Статистикийн эмхтгэл 2005, 2007, 2010 он

Хүснэгтээс харахад гэрлэлтийн тоо 2006 оноос эхлээд эрс нэмэгдэж, харин 2010 оноос эргээд буурчээ. 2006-2007 он хоорондын гэр бүл бололтын тооны өсөлт нь яг энэ үеэс шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламж өгч эхэлсэн, дээр нь 2008 оноос шинээр гэр бүл бологсдод тэтгэмж олгож, харин 2010 оноос энэ тусламж, тэтгэмжүүдийг олгохоо байсны улмаас гэр бүл бололтын тоо эрс буурсан байна. Харин гэр бүл цуцлалтын тоо 2009-2010 онд нэмэгдсэн нь 2006 оноос эрсөссөн гэрлэлтийн тооны улмаас гэр бүл цуцлалтын тоо дагаад нэмэгдсэний зэрэгцээ 2008 оноос зарим залуучуудын тэтгэмж авах зорилготой “тохиролцооны гэр бүлээ” эргээд цуцалсан байж болох талтай юм.

БҮЛЭГ 6. ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

4.1. Гэр бүлийн ерөнхий төлөв байдал


Хүн ам зүйн шинжлэх ухаанд гэр бүл болох нь салах, Бэлбэсрэх, тусгаарлах, дахин гэр бүл болох гэсэн ухагдахууныг цогцоор илэрхийлдэг ойлголт юм. Эдгээр үзүүлэлт гэрлэлт гэсэн ойлголтыг тал бүрээс нь тодорхойлон гаргадаг. Монгол Улсын 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан “Гэр бүлийн тухай” хуульд *“Гэрлэлт гэдэг нь харилцан эрх тэгш эрхүүргийн үндсэн дээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс тодорхой ёслол, үйл ажиллагааны дүнд сайн дурын бат холбоо тогтоож хуулиар батлуулах явдал юм”* гэсэн байна. Гэр бүл болох нь хүмүүс гэр бүлээ албан ёсоор бүртгүүлэх явдлаар илэрнэ.

Манай улсын хувьд гэр бүл болох чиг хандлага ямар байсныг авч үзвэл дайн самуун үймэ энтэй байсан 1930-аад онд монголчуудын гэр бүл болох төвшин доогуур байсан. Гэрлэлтийн талаар тодорхой тоймтой тоо баримт байхгүй ч тухайн үед болж байсан үйл явдал нь гэр бүл болох төвшин бага байхын үндэс болж байв. Тухайлбал 1935-1944 онд хүн амын тоо 738.2-759.1 мянга байсан. Жил бүр дунджаар 80000 орчим эрчүүдийг цэргийн албанд татаж байсан бол насанд хүрсэн нийт эрчүүдийн 40 орчим хувь нь сүм хийдэд эхнэр авалгүй шавилан сууж байв. Түүнчлэн тухайн үед нөхөрт гарах насанд хүрсэн эмэгтэй хүн амын 30-40 орчим хувь нь нөхөргүй байсан байна. Энэхүү байдал нь хүн амын төрөлт болон өсөлтөнд үлэмж сөрөг нөлөө үзүүлж байсан нь ойлгомжтой. 1960-аад оноос эхлэн төрөөс хүн ам, нийгэм эдийн засгийн талаар тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд гэр бүлгүй хүн амын тоо багасаж, үйсийн харьцаа тодорхой хэмжээгээр тогтворжих хандлага ажиглагдаж эхэлсэн байна.

1979 оны тооллогоор арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 65.4 хувь нь гэр бүлтэй байсан бол 1989 онд 65.8 хувь, 2000 онд 57.8 хувь, 2010 онд 60.1 хувь болжээ.

Гэр бүлийн тусгай коэффициент нь улс орны хүн амын гэр бүлийн байдлыг тодорхойлох чухал үзүүлэлт юм. 2000 онд арван найм, түүнээс дээш насны (хуулийн дагуу гэрлэх нас 18) 1000 хүн тутамд 9 гэр бүл болох ногдож байсан бол буурсаар 2010 онд 1000 хүн тутамд ердөө 3 ногдож байна.

Зураг 4.1. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, хувиар, 2000, 2010 он



(*) – батлуулаагүй гэр бүлтэй хүмүүс орсон

(**) – гэр бүлээ тусгаарласан хүмүүс орсон

Сүүлчийн 10 жилд гэр бүлтэй хүмүүсийн тоо өмнөх үеэс өссөн, гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн ам өссөн, батлуулсан хүн ам буурсан байна. Огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь сүүлчийн 10 жилд буурсан байна.

Гэр бүлийн байдал нь амьдралын хугацаа, насжих явцтай нягт холбоотой байдаг тул насүйжийн ялгавартай байдлаар судлах хэрэгтэй. Дараах хүснэгтэд арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг насны бүлэг, хүйсээр нь авч үзэхэд огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь эхний хоёр насны ялангуяа 15-19 насны бүлэгт хамгийн өндөр байна. Тэр тусмаа эрэгтэйчүүдийн дийлэнх нь гэрлээгүй байна. Энэ нь Монгол Улсын гэр бүлийн тухай хуульд гэр бүл болох насыг 18 насаар заасан бөгөөд 15-19 насны бүлгийн ихэнх хэсэг нь 18 хүртэлх насанд багтаж байгаа тай холбоотой. Цаашилбал 20-24, 25-29 насны бүлэгт ялгаатай байдал нь их болсон байна.

Хүснэгт 4.1. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он

Насны бүлэг	Бүгд		Гэр бүлийн байдал			
	Тоо	Хувь	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан/ Батлуулаагүй гэр бүлтэй	Цуцалсан/ Тусгаарласан	Бэлбэсэн
2000						
Эрэгтэй - Бүгд	749 890	100	36.6	58.5	2.1	2.8
15-19	133 327	100	98.7	1.3	-	-
20-24	118 023	100	70.7	28.8	0.5	-
25-29	107 962	100	31.2	66.7	1.9	0.2
30-34	92 473	100	13.5	82.6	3.4	0.5
35-39	84 846	100	7.3	87.8	4.0	0.9
40-44	62 619	100	4.1	90.3	3.9	1.7
45-49	40 562	100	3.4	90.0	3.6	3.0
50-54	27 707	100	2.8	89.2	3.0	5.0
55-59	27 379	100	3.0	85.4	2.6	9.0
60+	54 992	100	2.8	70.8	2.0	24.4
Эмэгтэй - Бүгд	774 482	100	29.7	57.1	3.3	9.9
15-19	130 031	100	94.4	5.5	0.1	-
20-24	117 728	100	51.7	46.8	1.3	0.2
25-29	108 690	100	20.9	74.7	3.5	0.9
30-34	95 399	100	10.0	81.8	6.0	2.2
35-39	87 760	100	6.6	82.9	6.5	4.0
40-44	64 601	100	4.9	81.3	6.3	7.5
45-49	42 326	100	4.0	77.6	5.1	13.3
50-54	30 128	100	3.3	71.7	3.7	21.3
55-59	28 516	100	3.5	62	2.6	31.9
60+	69 303	100	3.2	33.1	1.0	62.7
2010						
Эрэгтэй - Бүгд	937 271	100	34.4	60.7	2.7	2.2
15-19	130 56	100	98.8	1.3	-	-
20-24	147 472	100	71.7	27.8	0.5	-
25-29	124 49	100	32.9	65.3	1.6	0.1
30-34	111 976	100	17.7	79.0	3.0	0.3
35-39	100 819	100	11.4	83.6	4.4	0.5
40-44	88 273	100	7.5	85.8	5.5	1.2
45-49	77 475	100	5.5	86.7	5.6	2.2
50-54	58 009	100	3.6	87.5	4.8	4.1
55-59	33 384	100	3.2	86.5	4.0	6.3
60+	64 813	100	2.4	76.4	2.0	19.2
Эмэгтэй - Бүгд	968 698	100	28.2	59.6	3.5	8.7
15-19	127 085	100	96.4	3.5	-	-
20-24	144 711	100	57.6	41.3	0.9	0.1
25-29	123 493	100	23.1	73.8	2.6	0.5
30-34	110 546	100	12.6	81.8	4.3	1.3
35-39	101 564	100	8.4	83.1	5.7	2.8
40-44	90 994	100	6.3	80.9	7.0	5.8
45-49	81 281	100	5.4	77.5	7.0	10.2
50-54	64 073	100	4.3	73.3	5.7	16.6
55-59	38 605	100	3.6	65.8	4.2	26.3
60+	86 346	100	2.9	42.6	1.6	52.9

Гэр бүл болсон болон хамт амьдардаг 20-24 насны залуучуудын тухайн насныханд эзлэх хувийг авч үзэхэд 2000 онд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 18.0 хувь, 2010 онд 13.5 хувиар тус тус өндөр байснаа 25 -29 буюу түүнээс дээш их насны бүлэгт хүйсийн ялгаатай байдал багасаж буй нь ажиглагдаж байна. Үүнийг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуу насандаа нөхөрт гардагтай холбон тайлбарлаж болох юм.

15-19 насны огт гэр бүл болоогүй хүн амыг хүйсээр авч үзэхэд бусад насны бүлгээс харьцангуй бага зөрөөтэй, тухайлбал 2000 онд 4.3, 2010 онд 2.4 хувиар (жил ирэх тутам багассан байна) их байна. Харин энэ эрөө 20 -24, 25-29 насны бүлэгт улам нэмэгдэж байна.

2010 оны тооллогоор өмнөх тооллогын дүнтэй адилаар гэр бүлээ цуцалсан, тусгаарласан хүмүүсийн эзлэх хувь өсч, бэлбэсэн хүн амын тоо буурсаар байгаа юм. Гэр бүлээ цуцалсан, тусгаарласан арван тав, түүнээс дээш насны хүн ам 2010 оны тооллогоор 2000 оноос 0.4 хувиар өссөн байна. Харин хүйсийн ялгаатай байдлаар харахад аль ч тооллогоор гэр бүлээ цуцалсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс өндөр байгаа нь гэр бүлээ цуцалсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол дахин гэрлэх магадлал өндөр байдагтай холбоотой юм.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын Бэлбэсрэх төвшинг авч үзэхэд жар, түүнээс дээш насны бүлэгт бэлбэсэн хүмүүсийн эзлэх хувь, ялангуяа эмэгтэйчүүдийнх хамгийн өндөр байна. Тухайлбал, 2000 онд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 38.3, 2010 онд 33.7 хувиар илүү байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс урт насалдагтай холбоотой юм.

Хүснэгт 4.2. Арван тав, түүнээс дээш насны гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн амын тоо, насны бүлэг, хот, хөдөө, хувиар, 2010 он

Насны бүлэг	Хот				Хөдөө			
	Батлуулсан гэр бүлтэй		Батлуулаагүй гэр бүлтэй		Батлуулсан гэр бүлтэй		Батлуулаагүй гэр бүлтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгд	646 343	100	128 362	100	341 232	100	30 301	100
15-19	1 523	0.2	2 994	2.3	901	0.3	709	2.3
20-24	52 241	8.1	20 703	16.1	23 772	7.0	4 115	13.6
25-29	96 792	15.0	20 057	15.6	51 484	15.1	4 120	13.6
30-34	97 876	15.1	19 931	15.5	56 788	16.6	4 316	14.2
35-39	89 787	13.9	21 254	16.6	52 907	15.5	4 813	15.9
40-44	80 432	12.4	17 872	13.9	46 379	13.6	4 764	15.7
45-49	75 858	11.7	12 246	9.5	38 614	11.3	3 452	11.4
50-54	59 533	9.2	6 618	5.2	29 734	8.7	1 906	6.3
55-59	34 247	5.3	3 007	2.3	16 166	4.7	888	2.9
60+	58 054	9.0	3 680	2.9	24 487	7.2	1 218	4.0

2010 оны тооллогоор гэр бүлтэй болон хамт амьдардаг хүн амын 86 хувь нь батлуулсан, 14 хувь нь батлуулдаг гэр бүлтэй байна. Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүн ам хотод хөдөөнөөс илүү байна. Насны бүлгийн хувьд батлуулсан гэр бүлтэй хүмүүс 25 -44 насандаа, батлуулаагүй гэр бүлтэй хүмүүс арай эрт 20-39 насандаа хамгийн их гэр бүл болох буюу хамтран амьдардаг байна. Батлуулаагүй гэр бүлтэй хүн ам хөдөөд хотоос бага байгаа нь хөдөөд үндэсний ёс заншлаа хотынхоос илүү хадгалдгаар тайлбарлаж болох юм.

Хүснэгт 4.3. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, насны бүлэг, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он

Насны бүлэг	Бүгд		Гэр бүлийн байдал			
	Тоо	Хувь	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан/ Батлуулаагүй гэр бүлтэй	Цуцалсан/ Тусгаарласан	Бэлбэсэн
2000						
Хот - Бүгд	898 676	100	34.0	56.6	3.4	6.1
15-19	154 244	100	97.3	2.7	0.0	0.0
20-24	135 694	100	65.5	33.5	0.9	0.1
25-29	125 644	100	29.7	66.6	3.2	0.5
30-34	113 537	100	12.7	80.1	5.8	1.4
35-39	108 347	100	6.6	84.4	6.5	2.5
40-44	79 563	100	4.1	84.8	6.4	4.7
45-49	50 873	100	3.1	83.2	5.5	8.2
50-54	35 016	100	2.1	80.1	4.4	13.5
55-59	30 397	100	2.2	73.8	3.4	20.7
60+	65 361	100	1.9	49.5	1.6	47.0
Хөдөө - Бүгд	625 696	100	31.9	59.5	1.8	6.8
15-19	109 114	100	95.5	4.4	0.1	0.0
20-24	100 057	100	55.4	43.6	0.8	0.2
25-29	91 008	100	21.0	76.4	2.1	0.6
30-34	74 335	100	10.2	85.4	3.1	1.3
35-39	64 259	100	7.4	86.8	3.3	2.5
40-44	47 657	100	5.4	87.2	2.9	4.5
45-49	32 015	100	4.7	84.4	2.5	8.4
50-54	22 819	100	4.5	80.0	1.9	13.6
55-59	25 498	100	4.4	73.1	1.7	20.8
60+	58 934	100	4.2	50.2	1.2	44.4
2010						
Хот - Бүгд	1 331 679	100	33.0	58.1	3.6	5.2
15-19	188 334	100	97.6	2.4	0.0	0.0
20-24	221 784	100	66.4	32.9	0.6	0.1
25-29	171 685	100	29.3	68.1	2.4	0.3
30-34	149 461	100	16.1	78.8	4.3	0.8
35-39	136 034	100	10.6	81.6	6.0	1.7
40-44	120 105	100	7.1	81.9	7.6	3.5
45-49	108 736	100	5.1	81.1	7.6	6.3
50-54	83 084	100	3.4	79.7	6.5	10.5
55-59	49 342	100	2.8	75.5	4.9	16.8
60+	103 114	100	1.8	59.9	2.0	36.3
Хөдөө - Бүгд	574 290	100	27.2	64.7	2.0	6.1
15-19	69 311	100	97.6	2.3	0.0	0.0
20-24	70 399	100	59.6	39.6	0.6	0.1
25-29	76 298	100	25.0	72.9	1.7	0.4
30-34	73 061	100	13.1	83.6	2.4	0.9
35-39	66 349	100	8.4	87.0	2.9	1.7
40-44	59 162	100	6.6	86.5	3.5	3.4
45-49	50 020	100	6.1	84.1	3.5	6.3
50-54	38 998	100	5.1	81.1	3.0	10.9
55-59	22 647	100	4.8	75.3	2.3	17.7
60+	48 045	100	4.5	53.5	1.3	40.6

Гэрлэлтийн байдал нь байршлаараа ялгаатай эсэхийг онцын ялгаа байгаагүй. Хүснэгт 4.1-ийн ерөнхий төвшинтэй ижил байв.

Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд гэр бүлтэй хүний эзлэх хувийн жин байршил, хүйсээр нэлээд ялгаатай байна. 2010 онд арван тав, түүнээс дээш насны хүн амд гэр бүлтэй хүний эзлэх хувийн жин хөдөөд хотынхоос 6.6 хувиар их байна. Хотын арван тав, түүнээс дээш настай нийт хүн амд гэр бүлтэй хүний эзлэх хувийн жин 2010 онд 2000 оноос нэмэгдсэн байна. Гэр бүлтэй хүн амын эзлэх хувийн жин байршлаар нэлээд ялгаатай байгаа нь хүснэгтээс харагдаж байна. Гэр бүлээ цуцалсан буюу тусгаарласан, бэлбэсэн хүн амын байдал байршлаар бараг ялгаагүй байна.

4.2. Огт гэр бүл болоогүй хүн амд гарсан өөрчлөлт

Судалгааны гол үзүүлэлтийн нэг бол анхны гэрлэлтийн дундаж нас юм. Энэ үзүүлэлтийг тодорхойлсноор тухайн улсын хүн амын гэр бүлийн ерөнхий төлөв байдлыг дүгнэх боломжтой болдог. Анхны гэрлэлтийн дундаж насыг тухайн насны бүлгийн хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй хүн амд үндэслэн тооцдог.

Арван тав, түүнээс дээш насны хүн амд огт гэр бүл болоогүй хүн ам 1979 онд 23 хувь, 1989 онд 25.3 хувь, 2000 онд 33.1 хувь болж өссөөр байсан бол 2010 онд өмнөх үеэс 1.8 хувиар буурсан байна. Энэ нь 2007-2008 онд төрөөс залуу гэр бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд залуучууд гэр бүл болох нь нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

1979 оны тооллогоор арван тав, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн 27.7 хувь нь огт гэрлээгүй байсан бол энэ тоо өсч явсаар 2010 онд 34.4 хувьтай болсон байна (Хүснэгт 4.1).

1979 оны тооллогоор арван тав, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 18.5 хувь нь огт гэрлээгүй байсан бол өссөөр 2010 онд 28.2 хувьд хүрсэн байна. Ийнхүү огт гэрлээгүй эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо жилээс жилд өссөөр байгаа хэдий ч огт гэрлээгүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийхээс өндөр байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардгийг харуулж байна. Тиймээс ч эмэгтэйчүүдийн анхны гэр бүл болох дундаж нас эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага байдаг байна.

Хүснэгт 4.4. Арван тав, түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он


Насны бүлэг	Эрэгтэй		Эмэгтэй	
	2000	2010	2000	2010
Бүгд	100	100	100	100
15-19	47.9	40.0	53.2	44.8
20-24	30.4	32.8	26.4	30.5
25-29	12.3	12.7	9.8	10.4
30-34	4.5	6.1	4.1	5.1
35-39	2.3	3.6	2.5	3.1
40-44	0.9	2.1	1.4	2.1
45-49	0.5	1.3	0.7	1.6
50-54	0.3	0.6	0.4	1.0
55-59	0.3	0.3	0.4	0.5
60 +	0.6	0.5	1.0	0.8

Огт гэр бүл болоогүй эрэгтэй, эмэгтэйчүүдийн 70-аас багагүй хувь нь эхний хоёр насны бүлэг буюу 15-24 насны бүлэгт хамрагдаж байна.

Огт гэр бүл бол оогүй эрэгтэйчүүдийн дотор 15-19 насны бүлгийнхний эзлэх хувийн жинөндөр байгаа нь 15 -19 насны бүлгийн эрэгтэйчүүд хожуу гэрлэх хандлагатай болсныг харуулж байна.

Сүүлчийн 4 тооллогын дүнгээр харахад огт гэр болоогүй эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь 15-24 насныхан байгаа нь бүлгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил орой гэр бүл болох хандлагатай байгааг харж болох юм.

Зураг 4.2. Арван тав, түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй хүн амын тоо, байршил, хүйс, насны бүлгээр, 2010 он



Зураг 4.2 -оос дүгнэхэд арван тав, түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй хүн амын 74 хувь нь хотод байна. Энэ нь нэг талаараа хотод оюутан суралцагсад сурахаар шилжин ирдэг, үж амын төвлөрөл ихтэй зэрэг тэй холбоотой юм. Хөдөө, хотын аль алинд нь огт гэрлээгүй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа гэрлэдэг гэсэн дээрх үр дүнг батлан харуулж байна. Огт гэрлээгүй хүн амыг байршлаар, хүйсээр, насаар ангилан үзэхэд ангилал ялгаагүй 15-24 насныхан давамгайлж байгаа нь залуучууд 24 үртэлх насандаа гэр бүлтэй болох нь багасч байгааг харуулав. Залуучууд гэр бүлтэй болохоосоо өмнө боловсрол эзэмших, ажил эрхлэх, тогтмол орлоготой болохыг эрхэмлэх болсонтой холбон тайлбарлаж болох юм.

Огт гэр бүл болоогүй хүн амын ажил эрхлэх байдлыг авч үзвэл 2010 оны тооллогоор арван тав, түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй, эдийн засгийн идэвхтэй хүн амын 75.8 хувь ажил эрхэлдэг, 24.2 хувь ажил хайж байна. Ажил эрхэлдэг хүн амын 65.3 хувь хотын 34.7 хувь хөдөөнийх бол ажил хайж байгаа хүн амын 68.2 хувь хотын, 31.8 хувь хөдөөнийх байна.

Хүснэгт 4.5. Арван тав, түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй хүн амын эдийн засгийн идэвх, насны бүлэг, хот, хөдөө, хүйс, хувиар, 2010 он

Насны бүлэг	Ажил эрхэлдэг				Ажил хайж байгаа			
	Хот		Хөдөө		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100	100	100	100	100	100	100	100
15-19	10.8	6.2	24.4	16.5	17.3	16.5	22.5	24.2
20-24	43.5	39.5	39.4	34.4	42.2	47.2	44.0	46.8
25-29	24.8	26.4	18.7	18.6	18.3	19.3	18.3	15.1
30-34	10.6	12.6	8.4	9.7	10.5	8.4	7.9	7.0
35-39	5.5	7.3	4.3	6.5	6.5	4.4	4.1	3.6
40-44	2.7	4.1	2.4	5.6	3.2	2.5	1.8	1.8
45-49	1.6	2.7	1.6	5.3	1.6	1.2	1.0	1.2
50-54	0.6	1.3	0.8	3.5	0.4	0.4	0.4	0.5

Огт гэр бүл болоогүй ажил эрхэлдэг хүн амын хувьд хотод эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль алинд нь 20-29 насныхан зонхилж байхад, хөдөөд 15-29 насныхан зонхилж байна. Ажил хайж байгаа хүн амын хувьд хот , хөдөөд дээрх насны бүлэг дээр 15-19 насныхан нэмэгдэж байгаа нь огт гэр бүл болоогүй хүн амын хувьд 15-29 насныхан ажил идэвхтэй хайж байгааг харуулж байна.

4.3. Гэр бүлтэй хүн ам

Гэр бүл гэдэг бол нийгмийн байнгын анхаарал халамжид байх ёстой үнэт зүйл, нийгмийн тогтвортой байдлыг хангагч хамтын хүмүүсийн нийгэм оршин тогтнох нийтлэг хэлбэр юм. Эхнэр, нөхрийн харилцаа нь хоёр үний хувийн хэрэг мэт боловч нийгмийн ач холбогдол бүхий чухал асуудал юм. Нийгэм, эдийн засгийн байдал хувьсаж өөрчлөгдөхөд өхийн хэрээр өрх гэр бүрэлдэх явц, гэр бүлийн нийгмийн харилцаа өөрчлөгдөж ирсэн түүхтэй.

Арван тав, түүнээс дээш насны нийт хүн ам д гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн ам 1979 онд 65.3 хувь, 1989 онд 65.8 хувь, 2000 онд 57.8 хувь, 2010 онд 60.7 хувь байна. 2000 оны тооллогоор гэрлэсэн болон хамт амьдардаг хүн амын тоо өмнөх үеэс 8 хувиар буурсан нь гэр бүл болох уламжлалт сэтгэлгээнд өөрчлөлт орж залуучууд гэр бүл болохоосоо өмнө боловсрол эзэмших, ажил эрхлэх, тогтмол орлоготой болохыг үндэсн эрх эмлэх болсонтой холбоотой байсан бол 2010 оны тооллогоор гэрлэсэн болон хамт амьдардаг хүн амын тоо өмнөх үеэс нэмэгдсэн нь төрөөс залуу гэр бүлийг дэмжих бодлого авч хэрэгжүүлсэн зэргээс хамааралтай юм.

Хүснэгт 4.6. Арван тав, түүнээс дээш настай гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он


Насны бүлэг	Эрэгтэй		Эмэгтэй	
	2000	2010	2000	2010
Бүгд 15+	100	100	100	100
15-19	0.4	0.3	1.6	0.8
20-24	7.7	7.2	12.5	10.4
25-29	16.4	14.3	18.4	15.8
30-34	17.4	15.6	17.7	15.7
35-39	17.0	14.8	16.5	14.6
40-44	12.9	13.3	11.9	12.8
45-49	8.3	11.8	7.4	10.9
50-54	5.6	8.9	4.9	8.1
55-59	5.3	5.1	4.0	4.4
60 +	8.9	8.7	5.2	6.6

Сүүлчийн 2 тооллогоор 15-24 насны гэр бүл болсон болон хамт амьдардаг эрэгтэйчүүдийн хувийн жин бусад насны бүлэгтэй харьцуулахад он эмэгтэйчүүдийн энэ насны бүлэгтэй харьцуулахад доогуур хувьтай байна. 2000, 2010 оны тооллогод гэрлэсэн болон хамт амьдардаг эрэгтэйчүүдийн тоонд 25 - 49 насны эрэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд 20-44 насныхан зонхилж байна. Энэ нь эрэгтэйд эмэгтэйчүүдээс ихэнх тохиолдолд орой гэрлэх хандлагатай байдгийг харуулж бөгөөд б эмэгтэйчүүдийн хувьд 20 хүрээд, эрэгтэйчүүдийн хувьд 25 хүрээд гэр бүл болдог гэж болохоор байна.

2010 оны тооллогоор гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн амын байршлыг үзвэл 68 хувь нь хотод, 32 хувь нь хөдөөд амьдардаг байна. Гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн амын 86 хувь нь батлуулсан, 14 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй байна. Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүн ам хотод хөдөөнөөс илүү оршин сууж байна. Насны бүлгийн хувьд батлуулсан гэр бүлтэй хүмүүс 25-44 насандаа, батлуулаагүй гэр бүлтэй хүмүүс арай эрт 20-39 насандаа хамгийн их гэр бүл болох буюу хамтран амьдардаг байна.

2010 оны тооллогын дүнгээр арван тав, түүнээс дээш насны гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн амын ажил эрхлэлтээс үзэхэд талаас илүү хувь нь ажил эрхэлдэг бөгөөд ажил эрхлэлт эрэгтэйчүүдийн хувьд давамгайлж байна.

Зураг 4.3. Арван тав, түүнээс дээш насны гэр бүл болсон болон хамт амьдардаг хүн амын ажил эрхлэлтийн байдал, 2010 он



Гэр бүл болсон болон хамт амьдардаг эрэгтэй, эмэгтэйчүүдийн 25-49 насны бүлгийнхэн түлхүү ажил эрхэлж байна. Ажил эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн хувьд 20-39 насныхан зонхилж байгаа бол эрэгтэйчүүдийн хувьд 25-49 насныхан байна.

4.4. Гэр бүлээ цуцалсан, тусгаарласан хүн ам

Гэр бүл салах гэдгийг хуулийн талаас нь тодорхойлбол эрх зүйн зүүднээс баталгаажсан гэр бүлийн харилцаа хууль эрх зүйн үндэслэлтэйгээр төгсгөл болох үзэгдэл юм.

Гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын хувийн жин 1979 онд 1.85 хувь, 1989 онд 1.6 хувь, 2000 онд 2.7 хувь, 2010 онд 3.1 хувь болж хандлагатай байна. Сүүлчийн 4 тооллогын дүнгээр гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын 57-оос илүү хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол дахин гэрлэх магадлал бага байдагтай холбоотой юм.


Хүснэгт 4.7. Арван тав, түүнээс дээш насны гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он

Насны бүлэг	Эрэгтэй		Эмэгтэй	
	2000	2010	2000	2010
Бүгд 15+	100	100	100	100
15-19	0.0	0.0	0.5	0.0
20-24	3.8	2.9	6.0	3.9
25-29	13.0	7.9	14.8	9.5
30-34	20.0	13.4	22.3	14.1
35-39	21.6	17.7	22.2	17.1
40-44	15.5	19.3	15.9	18.8
45-49	9.3	17.3	8.4	16.8
50-54	5.3	11.1	4.3	10.8
55-59	4.5	5.3	2.9	4.8
60 +	7.0	5.1	2.7	4.2

25-54 насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн салах хувийн жин өндөр байна. 2010 онд өмнөх тооллоготой харьцуулахад 39 хүртэлх насны эрэгтэйчүүдийн салах нь багассан, 40-өөс дээш насны эрэгтэйчүүдийн салалт нэмэгдсэн, эмэгтэйчүүдийн хувьд 40-өөс дээш насныхны салалт нэмэгдсэн нь гэр үл салах нас хойшилж байгааг харуулна.

Энэ үзүүлэлтийг байршлаар үзвэл 2010 онд цуцалсан болон тусгаарласан хүн амын 80.4 хувь нь хотод, 19.6 хувь нь хөдөөд байв.

Зураг 4.4. Арван тав, түүнээс дээш насны гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын тоо, хот, хөдөө, насны бүлэг, хүйс, хувиар, 2010 он




2000 оны тооллогоор хотын эмэгтэйчүүдийн хувьд салах төвшин өндөр байсан бол 2010 оны тооллогоор дээрх үр дүн буурсан байна. Ерөнхийдөө 50-аас дээш насны үлэгт хотын болон хөдөөний эрэгтэйчүүдийн салах төвшин эмэгтэйчүүдийнхээс давамгайлж ирсэн байна. Гэр бүлээ цуцалсан болон

тусгаарласан хүн амын хувьд хотод хөдөөгөөс илүү байгаа ч хүйсээр болон насны бүлгээр хот хөдөөд ялгагдахуйц зөрүү ажиглагдахгүй байна.

Гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын ажил эрхлэлтийг үзвэл 2010 оны тооллогоор 53 хувь нь ажил эрхэлдэг, 47 хувь нь ажил эрхэлдэггүй байв. Ажил эрхэлж буй хүн амын 62 хувь эмэгтэйчүүд байна.

Зураг 4.5. Арван тав, түүнээс дээш насны гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын тоо, ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хүйс, хувиар, 2010 он



Зургаас харахад гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амд ажил эрхэлдэг эмэгтэйчүүд өндөр хувь эзэлж байна. Ерөнхийдөө салахад түлхүү өртсөн насны бүлэг нь 40-44 насныхан бөгөөд эрэгтэй, эмэгтэй, ажил эрхэлдэг, эрхэлдэггүй аль алинд нь энэ насныхан өндөр хувийг эзэлж байна.

4.5. Бэлбэсэн хүн ам

Бэлбэсрэлт нь тухайн орны нас хүйсийн бүтэц, дундаж наслалтын хэмжээнээс ихээхэн хамаардаг.


Арван тав, түүнээс дээш насны хүн амд бэлбэсэн хүн амын эзлэх хувь 1979 онд 9.6 хувь, 1989 онд 7.3 хувь, 2000 онд 6.4 хувь, 2010 онд 5.5 хувь болж өүүлчийн 30 жилд бэлбэсэн хүн амын тоо буурсаар байна.

Хүснэгт 4.8. Арван тав, түүнээс дээш насны бэлбэсэн хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он

Насны бүлэг	Эрэгтэй		Эмэгтэй	
	2000	2010	2000	2010
Бүгд 15+	100	100	100	100
15-19	0.0	0.0	0.0	0.0
20-24	0.0	0.0	0.3	0.2
25-29	1.0	0.6	1.3	0.7
30-34	2.2	1.6	2.8	1.7
35-39	3.6	2.4	4.6	3.4
40-44	5.1	5.1	6.4	6.3
45-49	5.8	8.3	7.4	9.9
50-54	6.6	11.5	8.4	12.7
55-59	11.7	10.2	11.9	12.1
60 +	63.9	60.3	57.0	53.0

Бэлбэсрэх нь 30 хүртэл насанд бараг ажиглагдахгүй харин нас ахих тутам аажмаар нэмэгдэж, ялангуяа 60-аас дээш насанд огцом өсөн байна. Хүснэгт 4.8-д хүйсийн ялгаатай байдлаар энэ чиг хандлага ижил байна. Сүүлчийн 10 жилээр авч үзэхэд бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо бэлбэсэн эрэгтэйчүүдийн тооноос илүү байгаа нь эрэгтэйчүүдийн дундаж нас эмэгтэйчүүдийнхээс бага байдагтай холбоотой юм.

Зураг 4.6. Арван тав, түүнээс дээш насны бэлбэсэн хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хувиар, 2010 он



Зургаас харахад хот хөдөө, эрэгтэй эмэгтэй хүйсийн аль алинд нь бэлбэсрэлт нь 30 хүртэл насанд бараг ажиглагдахгүй харин нас ахихад тодорхой хэмжээнд ялгаатай байна.

Бэлбэсрэлтийг хот, хөдөө хүйсийн ялгавартай байдлаар харахад 15 -54 насны бүлэгт хотын эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр байна. Хөдөөний эмэгтэйчүүдийн хувьд бэлбэсрэлтийн төвшингөөр хотын эмэгтэйчүүдээс бага байгаа ч хотын боловсролын эрэгтэйчүүдийн бэлбэсрэлтийн төвшингөөс илүү байгаа нь бэлбэсрэхэд хүйсийн ялгаа байгаа буюу эмэгтэйчүүдийн бэлбэсрэлтийн төвшин өндөр байгааг харуулж байна. Байршлаар харахад эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль алинд нь бэлбэсрэлтийн төвшин хотод хөдөөнөөс илүү байгаа нь хотод агаарын бохирдол их, хэт төвлөрөлтэй, хорт зуршил ихтэй зэрэг шалтгаанаас үүдэн нас барах магадлал өндөр, мөн түүнчлэн осол гэмтлээс болж эндэх явдал илүү их байдагтай холбон тайлбарлаж болох юм.

Хүснэгт 4.9. Арван тав, түүнээс дээш насны бэлбэсэн хүн амын тоо, насны бүлэг, хүйс, ажил эрхлэлтийн байдал, хувиар, 2010 он

Насны бүлэг	Ажил эрхэлдэг				Ажил эрхэлдэггүй			
	Бэлбэсэн эрэгтэй		Бэлбэсэн эмэгтэй		Бэлбэсэн эрэгтэй		Бэлбэсэн эмэгтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгд	4 743	100	19 268	100	15 916	100	64 712	100
15-19	0	0.0	3	0.0	0	0.0	7	0.0
20-24	19	0.4	84	0.4	8	0.1	113	0.2
25-29	76	1.6	340	1.8	56	0.4	291	0.4
30-34	175	3.7	842	4.4	114	0.7	634	1.0
35-39	322	6.8	1 824	9.5	232	1.5	1 031	1.6
40-44	579	12.2	3 417	17.7	456	2.9	1 824	2.8
45-49	894	18.8	5 112	26.5	801	5.0	3 189	4.9
50-54	1 151	24.3	4 607	23.9	1 209	7.6	6 008	9.3
55-59	767	16.2	1 699	8.8	1 347	8.5	8 461	13.1
60-64	337	7.1	680	3.5	1 878	11.8	9 212	14.2
65+	423	8.9	660	3.4	9 815	61.7	33 942	52.5

Бэлбэсэн хүн амын ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 2010 оны тооллогоор 23 хувь ажил эрхэлдэг, 77 хувь ажил эрхэлдэггүй байв. Ажил эрхэлдэг бэлбэсэн хүн амын 80 хувь эмэгтэйчүүд бөгөөд ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн 77.6 хувь 35-54 насны бүлэгт харьяалагдаж байв. Ажил эрхэлдэггүй бэлбэсэн хүн амын 20 хувь эрэгтэйчүүд бөгөөд ажил эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн 89 хувь нь 50-аас дээш насныхан буюу дийлэнх нь тэтгэврийн насныхан байв. Ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн хувьд мөн адил тэтгэврийн насныхан дийлэнх хувийг эзэлж байв. Ийнхүү бэлбэсэн хүн амын хувьд ажил эрхлэлтийн төвшин доогуур хувьтай мэт боловч эдгээрхүүсийн талаас илүү хувийг нь 60 -аас дээш насныхан эзэлдэг гэдгийг харгалзан авч үзвэл ажил эрхлэлтийн төвшин доогуур биш байна.


БҮЛЭГ 7. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС (АГДН), ТҮҮНИЙ ЯЛГАВАРТАЙ БАЙДАЛ

Гэрлэлтийн судалгааны хамгийн гол зорилго нь анхны гэрлэлтийн дундаж нас бөгөөд тухайн улсын хүн ам төрснөөсөө хойш дунджаар хэдэн жилийн дараа анх гэр бүл болж байгааг харуулдаг. Гэрлэлтийн дундаж насыг эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувьд тус бүрд нь тооцдог.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр улсын дунджаар эмэгтэйчүүд 24.2 насандаа, эрэгтэйчүүд 26.2 насандаа анх гэр бүл болж байна.

Хүн ам, орон сууцны 1979–2010 оны хоорондох 4 тооллогын үзүүлэлтээс харахад манай оронд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насны ялгаа ойролцоогоор хоёр насны зөрүүтэй, эрэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд 4.3 насаар, эмэгтэйчүүдийнх 4.6 насаар нэмэгджээ. Манай улсынх амын анхны гэрлэлтийн дундаж нас сүүлийн 10 жилд, эрэгтэй, эмэгтэйчүүдэд адилхан хагас жилээр хойшилсон байна. Анхны гэрлэлтийн дундаж нас 1989, 2000 оны хооронд 2.4-2.6 жилээр нэмэгдсэн бол сүүлийн 10 жилд энэ зөрүү эрс багасчээ.

Зураг 5.1. Монгол Улсын хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас, хүйсээр, 1979, 1989, 2000, 2010 он



Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжилт хийсэн сүүлийн 20 жилийн эдийн засаг, нийгмийн амаргүй хүнд бэрх нөхцөл, өнөөгийн залуучууд нийгэмд эзлэх байр сууриа олох, өрсөлдөөнт нөхцөлд ажлын байр олж, өдөр өдөр эрхлэх, сайн сайхан амьдрахын тулд сурч боловсрох, гадаад улс орнуудад явж, өдөр өдөр эрх элж, мөнгө хуримтлуулах зэргээр амьралынхаа багц цаг хугацааг зарцуулах болсон зэрэг олон шалтгаанаар өмнөх үеийнхнээсээ хожим гэрлэх болсон гэж үзэж болно. 2010 оны байдлаар манай орны их, дээд сургуульд нийтдээ 216.9 мянган оюутан

залуус суралцаж байсан нь 20-24 насны нийт залуучуудын (оюутнууд хэдийгээр бүгд энэ насанд хамаарахгүй ч гэсэн) 70 хувь болж байна. Эндээс залуучуудын хувьд их, дээд сургуульд суралцаж, гэрлэлтээ хойшлуулах хэрэгцээ шаардлага байгаа нь тодорхой байна.

Нөгөө талаар манай оронд олон мянган залуучууд ажилчүүдийн эгнээнд байна. Хүн ам орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр ажилгүйдлийн төвшин 20-24 насны залуучуудын дунд 23.8 хувь байгаа нь улсын дунджаас (15.3) ихээхэн өндөр байгаа бөгөөд энэ насны ажиллах хүчнээс тооцоход нийтдээ 40 орчим мянган залуучууд ажил эрхлэж байна гэсэн үг юм. Амьдралд хөлөө олоогүй, ажил хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудын хувьд мөн гэрлэлтээ хойшлуулж байж болох талтай. Суралцаж байгаа болон ажилгүй залуучууд 20 - 24 насны нийт залуучуудын 83 хувь болж байна.

Гэрлэх нас нь улс орон бүрт харилцан адилгүй, улс орны уламжлал, ёс заншил, нийгэм, эдийн засгийн нөхцөлийн төвшин, залуучуудын боловсрол эзэмших хугацаа, бие даан амьдрах боломж, нөхцөл, мэдлэг, мэргэжил, хүйсийн харьцаа гэх мэт үз ам зүй, нийгэм, эдийн засгийн маш олон хэргээр хэргээр хамаардаг. Дэлхийн зарим орнуудын хүн амын анхны гэрлэлтийн дундаж насыг харуулсан хүснэгт 5.1 -ээс харахад өнхийдөө хөгжингүй орнуудын залуус нэлээд орой гэрлэдэг зүй тогтол ажиглагдаж байгаагийн дотор Европын өндөр хөгжилтэй орнуудын хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас харьцангуй хожуу байна.

Хүснэгт 5.1. Дэлхийн зарим орны хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас, хүйс, оноор

Улс, орнууд	Он	Эрэгтэй	Эмэгтэй
Хөгжингүй орнууд:			
АНУ	2010	28.0	26.1
Япон	2009	29.4	27.6
ХБНГУ	2008	33.0	30.0
Франц	2008	31.6	29.6
Их Британи	2005	30.7	28.5
Итали	2007	32.1	30.4
Шилжилтийн эдийн засагтай орнууд:			
ОХУ	2004	26.1	23.3
Вьетнам	2009	26.2	22.8
Узбекистан	2009	25.2	22.4
Киргиз	2008	26.8	24.1
БНХАУ	2009	33.8	29.1
Беларусь	2008	26.0	23.9

Эх үүсвэр: www.wikipedia. The free Encyclopedia.

Ихэнх орнуудын хувьд эрэгтэйч гэрлэлтийн дундаж нас эмэгтэйчүүдийнхээс дунджаар 2 жилээр хожуу байна. Харин энэ зөрүү ХБНГУ-д 3 жил, Хятадад 4.7 жил байгаа онцлогтой байна.

5.1. Анхны гэрлэлтийн дундаж нас, аймаг, нийслэл болон хот, хөдөөгийн байдлаар

Хөдөөгийн залуус хотынхоос арай эрт гэрлэдэг нь хүснэгт 5.2-оос тодорхой байна. Ялангуяа хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн гэрлэлтийн дундаж насны зөрүү нэлээд байна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр хотын эмэгтэйчүүд дунджаар 25 насандаа анх гэрлэж байхад хөдөөд 22 насандаа гэрлэж байна. Гэтэл эрэгтэйчүүдийн хувьд хот, хөдөөгийн ялгаа бараг байхгүй бүгд дунджаар 26 насандаа анх гэрлэж байна.

Хүснэгт 5.2. Анхны гэрлэлтийн дундаж нас, хот, хөдөөгөөр

	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
1979	21.9	19.6	22.1	19.5	21.6	18.3
1989	23.3	21.1	22.0	20.3	21.7	19.0
2000	25.7	23.7	26.1	24.6	25.2	22.3
2010	26.2	24.2	26.3	24.9	26.0	22.4

1979 оны үж ам, орон сууцны тооллогоос хойших хугацаанд хөдөөгийн эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 4.1 жилээр хойшлогдсон бол хотын эмэгтэйчүүдийнх бүр 5.4 жилээр хойшилсон байна.

Хүснэгт 5.3. Анхны гэрлэлтийн дундаж нас аймаг, нийслэл, хүйсээр, 1979, 1989, 2000, 2010 он

Аймаг, нийслэл	1979		1989		2000		2010	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Архангай	21.4	18.2	21.7	20.0	24.8	22.5	25.5	23.1
Баян-Өлгий	20.7	20.2	20.6	18.8	24.2	22.8	25.5	23.9
Баянхонгор	22.0	18.5	21.8	19.0	25.1	22.5	25.9	22.7
Булган	21.7	18.3	21.8	19.3	25.3	22.4	25.9	22.8
Говь-Алтай	22.5	19.9	22.6	19.6	26.1	22.9	26.8	23.2
Дорноговь	21.9	18.2	21.9	18.8	25.2	22.1	25.1	22.3
Дорнод	21.4	18.8	21.4	19.5	26.0	23.8	26.2	23.8
Дундговь	22.5	19.4	21.5	18.9	25.2	22.1	25.4	21.9
Завхан	22.3	18.6	22.1	19.6	25.6	23.0	26.5	22.9
Өвөрхангай	21.3	18.0	22.0	19.1	25.2	22.9	25.9	22.7
Өмнөговь	22.9	18.4	21.7	19.1	25.0	21.1	25.4	21.7
Сүхбаатар	21.7	18.4	21.6	19.0	26.3	23.0	26.1	22.7
Сэлэнгэ	21.9	18.2	21.8	19.3	25.7	23.0	26.0	23.2
Төв	21.6	18.1	21.5	18.9	25.6	22.7	26.4	22.9
Увс	20.9	17.9	21.5	19.0	25.1	22.5	26.0	23.2
Ховд	21.3	18.8	21.4	19.4	25.4	23.2	26.2	23.9
Хөвсгөл	21.7	18.2	22.0	19.1	26.1	22.7	26.1	22.7
Хэнтий	21.9	18.8	21.2	18.6	25.0	22.4	25.4	22.4
Дархан-Уул	21.8	19.4	21.6	20.2	25.8	24.2	26.1	24.2
Улаанбаатар	21.8	19.3	21.8	20.2	26.3	25.1	26.6	25.3
Орхон	20.3	17.7	21.1	19.4	25.3	23.7	25.7	24.0
Говьсүмбэр	-	-	-	-	25.4	23.3	25.6	22.8

2000 болон 2010 оны тооллогын дүнгээс харахад Улаанбаатар хот, Говь-Алтай аймгийн эрэгтэйчүүдийн АГДН улсын дунджаас үзвэл бусад аймаг, хотынхоос орой гэрлэж байжээ. Гэтэл хоёр тооллогын аль алинд нь говийн бүсгүйчүүд, тухайлбал, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн эмэгтэйчүүдийн АГДН сүүлийн 2 тооллогын дүнгээр улсын дунджаас доогуур, харьцангуй эрт нөхөрт гарсан байна.

Энэүү судалгаанд 1979 болон 1989 оны АГДН-ыг 2001 онд гаргасан “Хүн амын гэрлэлтийн байдал” сэдэвчилсэн судалгаанаас шууд авсан боловч сэдэвчилсэн судалгааны 1979 болон 1989 оны АГДН-ны тооцоо буруу байж болзошгүй байна. Учир нь 2001 оны сэдэвчилсэн судалгаанд улсын дунджаар эрэгтэйчүүдийн АГДН 1989 онд 23.3, эмэгтэйчүүдийнх 21.1 байгаа. Дээрх эх үүсвэрээс авсан хүснэгт 5.3-аас харахад 1989 оны хувьд эрэгтэйчүүдийн АГДН Завхан аймагт хамгийн өндөр буюу 22.1 байжээ. Бусад бүх аймаг, хотод үүнээс доогуур байна. Гэтэл улсын дундаж 1989 онд 23.3 байх ямар ч үндэсгүй юм. Эмэгтэйчүүдийн хувьд ч мөн адил 1989 онд Улаанбаатар хот, Дарханы эмэгтэйчүүдийн АГДН хамгийн их буюу 20.2 байжээ. Эндээс улсын дундаж 1989 онд 21.1 байх боломжгүй юм. 1994 онд хэвлэгдсэн “Монгол Улсын хүн ам”

эмхтгэлийн 181 дүгээр хуудсанд 1989 оны хүн амын АГДН эрэгтэйчүүдийн хувьд 14.23, эмэгтэйчүүдийнх 19.65 гэж хэвлэгджээ. Энэ номонд 1979 онд эрэгтэйчүүдийн АГДН 24.07, эмэгтэйчүүдийнх 18.53 гэж хэвлэгдсэн байна.

Хүснэгт 5.4. Анхны гэрлэлтийн дундаж насны бүлэглэлт, аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он

Анхны гэрлэлтийн дундаж насны бүлэг	Аймгуудын хүн амын АГДН, 2010 оны тооллогоор	
	Эрэгтэй	Эмэгтэй
22.1 - 23.0	-	Өмнөговь, Дундговь, Дорноговь, Хэнтий, Баянхонгор, Булган, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Говьсүмбэр, Өвөрхангай, Завхан
23.1 - 24.0	-	Архангай, Увс, Говь-Алтай, Сэлэнгэ, Дорнод, Ховд, Баян-Өлгий
24.1 - 25.0	-	Орхон, Дархан-Уул, Улаанбаатар
25.1 - 26.0	Дорноговь, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Архангай, Баян-Өлгий, Орхон, Говь-Сүмбэр, Баянхонгор, Булган, Өвөрхангай	-
26.1 - ээс дээш	Сэлэнгэ, Увс, Сүхбаатар, Хөвсгөл, Дархан-Уул, Ховд, Дорнод, Төв, Завхан, Улаанбаатар, Говь-Алтай	-

Хүснэгт 5.4-өөс харахад 2010 оны тооллогын дүнгээр Дорноговь, Өмнөговь, Дундговь, Хэнтий аймгийн эрэгтэйчүүдийн АГДН бусад аймгийнхаас доогуур, арай эрт гэрлэсэн байхад Ховд, Дорнод, Завхан, Улаанбаатар хот, Говь-Алтай аймгийн эрэгтэйчүүдийн АГДН бусад аймгийнхаас дээгүүр харьцангуй орой гэрлэсэн байна. Эмэгтэйчүүдийн хувьд 2010 оны тооллогоор Өмнөговь, Дундговь, Дорноговь, Хэнтий, Баянхонгор, Булган аймгийн эрэгтэйч харьцангуй эрт нөхөрт гарсан бол Дорнод, Ховд, Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул, Улаанбаатар хотын бүсгүйчүүд арай хожуу гэрлэсэн байна.

5.2. Анхны гэрлэлтийн дундаж нас, үндэс угсаагаар

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр нийт хүн амын дийлэнх буюу 82.4 хувийг халх, 3.9 хувийг казах, 2.7 хувийг дөрвөд, бусад ястан үндэстэн тухайлбал, баяд, буриад, дарьганга, захчин, урианхай 1.0-2.2 хувийг тус бүр эзэлж байна. Энэ хувийг харгалзан тооллогоор тодорхойлсон 30 гаруй үндэс угсаатанаар тооцох боломжтой тоон мэдээлэлтэй 14 үндэс угсаатан болон гадаадын харьяат хүн амын анхны гэрлэлтийн дундаж насыг тооцсон болно.

Хүснэгт 5.5. Анхны гэрлэлтийн дундаж нас, үндэс угсаа, хүйсээр, 2000, 2010 он

Үндэс угсаа	2000		2010	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Бүгд	25.7	23.7	26.2	24.2
Халх	25.7	23.6	26.1	24.2
Казах	24.3	23.0	25.8	24.4
Дөрвөд	25.8	23.9	26.5	24.8
Баяд	25.6	24.0	26.5	25.0
Буриад	26.3	24.6	27.0	24.9
Захчин	25.7	23.5	26.5	24.5
Дарьганга	25.6	24.0	26.9	24.2
Урианхай	26.5	24.4	27.1	24.8
Дархад	26.5	22.8	26.7	22.5
Өөлд	26.1	25.0	27.1	25.1
Хотгойд	25.4	22.7	26.0	23.0
Торгууд	26.6	24.7	27.6	26.2
Хотон	24.5	22.3	24.9	23.6
Мянгад	26.3	25.3	26.6	24.6
Гадаадын харьяат	26.8	25.8	26.9	28.9

Монголд амьдардаг гадаадын харьяатуудын анхны гэрлэлтийн дундаж нас монголчуудынхаас хойно байгаагийн дотор эмэгтэйчүүдийнх нь хамгийн өндөр 28.9 байгаа нь гадаадын харьяат эрэгтэйчүүдээс 2 насаар хойно байна.

Хүснэгт 5.6. Анхны гэрлэлтийн дундаж насны бүлэглэлт, үндэс угсаа, хүйсээр, 2010 он

Анхны гэрлэлтийн дундаж насны бүлэг	Үндэс угсаа	
	Эрэгтэй	Эмэгтэй
22.1 - 23.0	-	дархад, хотгойд
23.1 - 24.0	-	хотон
24.1 - 25.0	хотон	халх, дарьганга, казак, захчин, мянгад, дөрвөд, урианхай, буриад, баяд
25.1 - 26.0	казак, хотгойд	өөлд
26.1 - 27.0	халх, дөрвөд, баяд, захчин, мянгад, дархад, дарьганга, буриад	торгууд
27.1 - ээс дээш	өөлд, урианхай, торгууд	-

Хүснэгт 5.5-аас харахад дархад, хотогойд эмэгтэйчүүд дунджаар 23 хүрэлгүй анх гэрлэдэг бол торгууд бүсгүйчүүд хамгийн орой, дунджаар 26 хүрч байж гэрлэдэг байна. Гэтэл хотон эрчүүд бусдаас эрт дунджаар 25 хүрэлгүй гэрлэдэг бол торгууд эрчүүд хамгийн орой дунджаар 26.6 настай анх гэрлэдэг байна.

5.3. Анхны гэрлэлтийн дундаж нас, боловсролын төвшингөөр

Анхны гэрлэлтийн дундаж нас залуучуудын боловсролын түвшнөөс хэрхэн хамаарч байгааг энэ хэсэгт авч үзлээ. Хүн ам, орон сууцны 2000 болон 2010 оны тооллогуудын үр дүнг гаргахдаа боловсролын төвшинг арай өөр өөрөөр авсан тул 2 тооллогын АГДН-ны үзүүлэлтийг тооллого тус бүрээр харуулав.

Хүснэгт 5.7. Анхны гэрлэлтийн дундаж нас, боловсролын төвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он

Боловсролын төвшин	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	25.7	23.7	26.1	24.6	25.2	22.3
Бичиг үсэг мэддэггүй	30.2	31.2	31.4	33.1	29.9	30.4
Бага боловсрол эзэмшээгүй						
Бичиг үсэг мэддэг	27.1	27.0	28.2	28.8	26.7	26.4
Бага	26.0	24.5	28.0	26.5	25.5	23.9
Бүрэн бус дунд	25.6	23.0	26.3	23.9	25.0	22.2
Бүрэн дунд, техник мэргэжлийн	25.7	24.0	25.9	24.6	25.1	22.4
Дипломын дээд	25.3	24.9	24.5	24.5	24.4	22.8
Дээд	25.1	25.2	25.1	25.4	25.0	24.0

Сүүлийн 2 тооллогын дүнгээс харахад АГДН эрэгтэйчүүдийн хувьд боловсролын төвшин өндөр байх тутам бага, харин боловсролын төвшин бага байх тутам өндөр гарчээ. Өөрөөр хэлбэл, бага боловсролтой залуус өндөр

боловсролтой үе тэнгийнх нээсээ иүү орой гэрлэдэг байна. 2010 оны тооллогоор дээд боловсролтой эрэгтэйчүүд дунджаар 25.5 насандаа анх гэрлэж байсан бол боловсролгүй эрэгтэйчүүд 26.7 нас хүрч анх гэрлэсэн нь бараг 1.2 жилийн хойно байна. Энэ зөрүү 2000 онд бүр илүү 3-5 жил байсан байна.

Хүснэгт 5.8. Анхны гэрлэлтийн дундаж нас, боловсролын төвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он

Боловсролын түвшин	Анхны гэрлэлтийн дундаж нас					
	Бүгд		Хот		Хөдөө	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Бүгд	26.2	24.2	26.3	24.9	26.0	22.4
Боловсролгүй	26.7	24.8	27.6	27.9	26.5	23.5
Бага	26.0	22.7	27.2	24.8	25.6	21.9
Суурь	26.4	22.9	26.7	24.0	26.1	21.8
Бүрэн дунд	26.3	24.2	26.3	24.6	26.3	22.0
Техникийн болон	26.5	23.8	26.6	24.6	26.3	22.5
Тусгай мэргэжлийн дунд	25.8	23.9	25.9	24.2	25.4	22.9
Дээд	25.5	24.6	25.4	24.8	25.6	23.0

Өөрөөр хэлбэл, бага боловсролтой эрэгтэйчүүдийн гэрлэх магадлал дээд боловсролтой эрэгтэйчүүдийнхээс бага байна гэсэн үг юм. Хот, хөдөөгөөр авч үзвэл боловсролгүй залуучууд хотод бүр 27.6 хүрч байж анх гэрлэж байсан нь хөдөөгийн боловсролгүй залуусаас нэг жилийн хойно байна. Харин боловсролтой залуучуудын хувьд анхны гэрлэлтийн нас хөдөөд бараг ялгаагүй дунджаар 25.4-25.6 байна. Гэтэл эмэгтэйчүүдийн хувьд энэ байдал арай өөр байна. 2010 он ы тооллогоор дээд боловсролтой болон огт боловсролгүй эмэгтэйчүүдийн анхны гэрлэлт арай хожуу, дунджаар 24.6-24.8 насандаа байсан бол бага боловсролтой болон суурь боловсролтой эмэгтэйчүүдийнх арай эрт, дунджаар 22.7-22.9 насандаа гэрлэсэн байна. Энэ байдал мөн 2000 онд ч адил төстэй байжээ. Хот, хөдөөд байдал бүр ялгаатай, хөдөөгийн бага болон суурь боловсролтой эмэгтэйчүүд 2010 оны байдлаар 22 хүрэлгүй анх гэрлэж байсан нь боловсролын ижил төвшний хотын эмэгтэйчүүдээс бараг нэг жилээр өмнө байна.

5.4. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн идэвхийн байдлаар

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр Монгол Улсын арван тав, үүнээс дээш насны 1906 мянган хүний 56.4 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчинд багтаж байна. Харин үлдсэн 43.6 хувь буюу 830.2 мянган хүн нь эдийн засгийн идэвхгүй хүн ам юм.

Хүн ам эдийн засгийн хувьд идэвхтэй байх нь тэдгээрийн анхны гэрлэлтийн дундаж насанд ямар өлөөтэй байгааг сүүлийн 2 тооллогын дүнгээр судлаж үзэхэд ажил хийдэг эрэгтэй, эмэгтэйчүүд ажил эрхэлдэггүй залуучуудаас арай эрт гэрлэдэг ерөнхий зүй тогтол ажиглагдлаа.

Хүснэгт 5.9. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн идэвхийн байдал, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он

Эдийн засгийн идэвх	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Эдийн засгийн идэвхтэй	25.3	23.1	25.6	24.4	25.0	21.7
Ажил эрхэлдэг	25.1	22.8	25.2	24.5	24.9	21.5
Ажилгүйчүүд	26.2	23.9	26.3	24.0	25.9	23.7
Эдийн засгийн идэвхгүй	27.2	24.5	27.2	24.7	26.9	23.7
Тохирох ажил олдохгүй байгаа	26.2	24.3	26.3	24.5	25.8	23.5
Сургуульд сурдаг	27.5	26.5	28.7	27.3	-	-
Өвчтэй, тахир дутуугийн группт	30.6	29.5	30.0	28.8	31.6	30.6
Гэрийн ажилтай	25.6	20.3	25.5	19.9	25.8	20.6

Хоёр тооллогын дүнгээр ажил эрхэлдэг эрэгтэйчүүд 25.1-25.2 насандаа, ажил эрхэлдэг эмэгтэйчүүд 22.8-23.4 насандаа гэрлэдэг бол харин ажилгүй эрэгтэйчүүд 26.2 - 27.0 насандаа буюу ажил эрхэлдэг залуучуудаас 1-2 жилийн дараа, ажилгүй эмэгтэйчүүд дунджаар 23.9-24.0 насандаа буюу ажил эрхэлдэг эмэгтэйчүүдээс нэг жилийн дараа анх гэрлэж байна. Энэ нь ажилгүй залуучууд цалин, орлоготой ажил олсныхоо дараа гэрлэж болдогтой холбоотой байж болох юм. Хөдөөд ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас нь 2010 оны тооллогын дүнгээр хотын ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийнхээс 4 насаар эрт байна. Гэтэл ажил эрхэлдэг эрэгтэйчүүд хөдөөд хотынхоос бага ээрэг орой гэрлэж байна.

Хоёр тооллогын дүнгээр гарсан АГДН улсын нэгдсэн дүнтэй тохирохгүй. Учир нь эвхэн эдийн засгийн идэвхтэй болон идэвхгүй хүн амын дүнгээр түүнийг тооцсонтой холбоотой.

Хүснэгт 5.10. Анхны гэрлэлтийн дундаж нас эдийн засгийн идэвхийн байдал, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он

Эдийн засгийн идэвхийн байдал	Анхны гэрлэлтийн дундаж нас					
	Бүгд		Хот		Хөдөө	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Эдийн засгийн идэвхтэй	25.6	23.6	25.4	24.7	25.8	21.5
Ажил эрхэлдэг	25.2	23.4	25.0	24.8	25.5	20.8
Ажил хайж байгаа	27.0	24.0	26.9	24.1	27.1	23.4
Эдийн засгийн идэвхгүй	28.4	24.4	28.5	24.6	28.0	23.6
Сургуульд сурдаг	28.8	28.1	28.9	28.2	28.5	26.5
Тэтгэвэрт						
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	32.3	31.3	31.8	30.8	33.6	32.4
Гэрийн ажилтай	24.9	18.8	24.5	18.3	25.7	19.9
Тохирох ажил олдохгүй байгаа	26.9	24.4	26.9	24.5	26.9	23.9
Ажиллах сонирхолгүй	28.2	24.8	28.3	24.5	28.4	25.8
Бусад	27.4	22.0	27.2	21.8	27.9	22.6

Эдийн засгийн идэвхгүй хүн амын дийлэнх төрөл ерөнхийдөө хамгийн орой гэрлэж байна. Тухайлбал, өвчтэй, тахир дутуугийн группт байдаг эрэгтэйчүүд 31-32, эмэгтэйчүүд 30 -31 насандаа гэрлэж байгаа нь улсын дундажтай харьцуулахад бараг 6 жилээр орой гэрлэж байна. Харин сургуульд сурдаг эрэгтэйчүүд 2 тооллогынүндээр дунджаар 27.5 -28.8 нас, суралцдаг эмэгтэйчүүд 26.5-28.1 нас хүрч анх гэрлэж байгаа нь улсын дунджаас өмнө л харьцангуй хожуу байна.

Харин гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас хамгийн бага 19-20 байлаа. Энэ нь эмэгтэйчүүдийн гэр бүлийн үүрэг, уламжлалт ёс заншилтай холбоотой байж болно.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын АГДН хот, хөдөөгийн хувьд ч ялгаатай байна. Хөдөлмөр эрхлэх чадваргүй эрэгтэйчүүд 2010 онд хотод 31 хүрч анх гэрлэж байхад хөдөөд бүр дунджаар бараг 34 хүрч анх гэрлэсэн байна. Сургуульд сурдаг хотын эмэгтэйчүүд 2010 онд дунджаар 28 хүрч анх гэрлэсэн бол хөдөөгийнх дунджаар 26.5 настайдаа анх гэрлэсэн байна.

5.5. Анхны гэрлэлтийн дундаж нас, ажил мэргэжлээр

Судалгааны хэсэгт АГДН-ыг ажил мэргэжлийн ялгаатай байдлын өгөөг мөрдөж буй ажил мэргэжлийн ангиллын дагуу тооцож гаргав. Манай оронд хэдийгээр эмэгтэйчүүд боловсролын төвшингийн хувьд давамгайлж байгаа хэдий ч 2000 онд удирдах албан тушаалтан буюу менежер нарын өдгөж 30 хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан бол 2010 онд 43 хувь болж нэмэгдсэн байна. Харин 2000 онд мэргэжилтнүүдийн 65 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 2010 онд мөн л тэр хэмжээндээ үлджээ. Хөдөө аж ахуйн ажилчин буюу машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч гэсэн мэргэжлээр эрэгтэйчүүд давамгайлж байна. Хоёр тооллогын хооронд ажил мэргэжлийн ангилалд бага зэргийн өөрчлөлт орсон тул үр дүнг тооллого тус бүрээр харуулав.

Хүснэгт 5.11. Анхны гэрлэлтийн дундаж нас, ажил мэргэжил, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он

Ажил мэргэжил	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	25.1	22.8	25.2	24.5	24.9	21.5
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер	23.3	24.1	23.4	24.4	23.2	22.4
Мэргэжилтэн	24.7	24.4	24.8	24.9	24.0	22.4
Инженер, техникийн ажилтан	24.5	24.0	24.5	24.5	24.5	22.1
Туслах ажилтан /Клерк /	24.1	23.9	24.4	24.4	23.2	21.1
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	24.5	23.7	24.6	24.0	24.0	22.4
Хөдөө аж ахуй ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилчин	25.1	21.6	26.6	23.1	25.0	21.4
Үйлдвэрийн ба худалдааны ажилчин	25.2	24.9	25.3	25.1	24.6	22.9
Машин, тоног төхөөрөмжийн операторч,	24.4	24.4	24.5	24.4	24.2	24.3
Энгийн ажил мэргэжил	25.2	23.8	25.3	24.1	24.5	22.5

Хүснэгтүүдийн дүнгээр гарсан АГДН улсын дүнтэй тохирохгүй. Учир нь зөвхөн ажил эрхэлдэг, тодорхой мэргэжлээр ажилладаг хүмүүсийн дүнгээр түүнийг тооцсонтой холбоотой.

Хоёр тооллогын дүнгээр менежер эрэгтэйчүүд хамгаас эрт гэрлэсэн байна. Тэдэнд эрт гэрлэх боломжгүй байжээ. Гэтэл энгийн ажил мэргэжлийн эрэгтэйчүүд дунджаар бусад мэргэжлийнхнээс арай хожуу гэрлэжээ.

Хүснэгт 5.12. Анхны гэрлэлтийн дундаж нас ажил мэргэжил, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он

Ажил мэргэжил	Анхны гэрлэлтийн дундаж нас					
	Бүгд		Хот		Хөдөө	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Бүгд	25.2	23.4	25	24.8	25.5	20.8
Менежер	24.2	25.1	24.2	25.2	24.4	24.4
Мэргэжилтэн	25.2	25	25.2	25.4	25.2	23.4
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	25.2	24.9	25.2	25.1	25.5	23.8
Контор, үйлчилгээний ажилтан	24.9	25.2	24.8	25.4	25.3	23.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	24.5	24.2	24.4	24.3	25.6	23.4
Хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан	25.4	19.7	25.6	20.5	25.3	19.6
Үйлдвэрлэл, барилга гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	25.4	24.8	25.3	24.8	26.3	24.4
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	24.4	24.7	24.2	24.9	25.2	23.4
Энгийн ажил мэргэжил	25.9	24	25.8	24.4	26.1	22.9
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	25.6	22.4	25.5	23.5	25.5	19.5

Хоёр тооллогын дүнгээр хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан эмэгтэйчүүд дунджаар бусдаас харьцангуй эрт, 20 хүрэлгүй гэрлэсэн байна. Гэтэл 2010 оны тооллогынүдгээр менежер, контор, үйлчилгээний ажилтан эмэгтэйчүүд бусад ажил мэргэжлийнхнээс хожуу гэрлэсэн байна.

2010 оны тооллогын үдгээр хөдөөд зарим мэргэжлээр эрэгтэйчүүд нэлээд хожуу гэрлэсэн байна. Тухайлбалү йлдвэрлэл, барилга гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан хөдөөгийн эрэгтэйчүүд хамгаас орой гэрлэсэн байна. Хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ 5 насаар орой гэрлэдэг нь бусад ажил мэргэжлийнхнээс хүйсийн хувьд хамгийн их зөрүүтэй байна. Энэ нь хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын салбарын нийт ажиллагсдын 57.8 хувь нь эрэгтэйчүүд байдагтай холбоотой байж болно.

5.6. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Тайлангийн энэхүү хэсэгт АГДН-ыг эдийн засгийн үйл ажиллагааны сал бараар ялгаатай байгаа эсэхийг авч үзэв. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилал” -ын сүүлчийн хянаж шинэчилсэн 4 дэх хувилбарыг (ISIC, Rev.4) ашигласан тул 2000 оны тооллогод ашигласан 3 дахь хувилбараас салбарууд бага зэргийн зөрүүтэй байгаа болно. Хоёр тооллогын салбарын зөрүүтэй байдлаас АГДН-ыг тооллого тус бүрээр тус тусад нь харуулав.

Хүснэгт 5.13. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	25.1	22.8	25.2	24.5	24.9	21.5
Хөдөө аж ахуй, загас, ан агнуур, ойн аж ахуй, уул уурхайн олборлох үйлдвэр	25.1	21.6	25.8	23.0	25.0	21.5
Боловсруулах үйлдвэр	25.6	25.2	25.7	25.3	25.3	23.4
Цахилгаан, хий, үйлдвэрлэл, ус, хангамж	24.7	22.4	24.8	22.5	24.1	22.2
Барилга	25.6	24.0	25.7	24.0	24.9	24.0
Бөөний болон жиижгэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	24.2	23.6	24.2	23.7	24.3	22.8
Зочид буудал, зоогийн газар	25.8	24.9	26.0	25.0	24.4	24.0
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	24.2	23.7	24.3	23.8	23.7	22.9
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	25.1	24.2	25.2	24.3	23.7	23.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	25.2	23.4	25.3	24.5	25.0	20.0
Боловсролын салбарын үйл ажиллагаа	24.4	24.1	24.6	24.6	23.9	22.7
Эрүүл мэнд, нийгмийн халамж	24.3	24.1	24.9	24.6	23.4	22.3
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	25.3	24.6	25.4	24.8	24.5	22.0

Хоёр тооллогын дүнгээс харахад аль алинд нь зочид буудал, зоогийн газар (шинэ ангиллаар байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа) болон барилгын салбарт ажилладаг эрэгтэйчүүд дунджаар бусад салбарынхаас арай орой гэрлэсэн байна. Гэтэл хөдөө аж ахуйн салбарт ажилладаг эмэгтэйчүүд дунджаар бусад салбарын эмэгтэйчүүдээс эрт гэрлэсэн байна.

Харин эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 2010 оны АГДН-ны зөрүү дүнгээрээ 2 орчим жил байсан бол хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барих, ан агнуурын салбарт энэ зөрүү бүр 5.6 жил, бусад салбарынхнаас хамгийн их байна.

Хүснэгт 5.14. Анхны гэрлэлтийн дундаж нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Анхны гэрлэлтийн дундаж нас					
	Бүгд		Хот		Хөдөө	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Бүгд	25.2	23.4	25	24.8	25.5	20.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	25.4	19.8	25.6	20.8	25.3	19.7
Уул уурхай, олборлолт	25.8	24.9	25.3	25.3	26.6	24.2
Боловсруулах үйлдвэрлэл	24.8	24.9	24.8	25	25.3	23.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	24.6	24.4	24.5	25	25.1	22.6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	25.1	23.7	24.9	23.7	27.1	22.9
Барилга	25.9	25.3	25.8	25.2	26.6	25.5
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	24.4	24.3	24.3	24.3	24.9	24
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	24.1	24.4	23.9	24.6	25.2	23.3
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	26	25.5	26	25.5	25.4	25.1
Мэдээлэл, холбоо	25.8	26.1	25.8	26.2	25.9	24.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	24.5	24.9	24.6	25.3	24.5	22.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	24.2	22.8	24.2	22.8	-	-
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	25.3	26.2	25.3	26.4	25.3	24.6
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	25.7	26.3	25.6	26.6	26.7	25.6
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	25.1	24.4	24.9	25.1	25.4	22.3
Боловсрол	24.3	23.6	24.7	24.3	23.5	22
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	24.2	24.5	24.5	24.8	23.5	23.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	25.3	24.8	25.5	25.1	22.9	23.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	25.2	24.7	25.1	24.7	26.2	24.3
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн	23.6	27.7	23	27.6	-	29.3
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	23.9	27.6	23.9	27.7	24.3	26.4

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын ажиллагсдын хүйсийн харьцаа харилцан адилгүй байдаг нь залуучуудын АГДН-д нөлөөлдөг эсэхийг судалж үзэхэд 2010 оны тооллогын дүнгээр захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, цахилгаан, уур, ус, агааржуулалтын хангамж, барилга, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, уул уурхайн олборлох салбарт ажиллагсдын 71.5-80.2 хувь нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд энэ салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн АГДН улсын дунджаа өндөр байна. Харин боловсрол, хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа зэрэг салбарт ажиллагсдын 73.2-80.5 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд энд ажилладаг эрэгтэйчүүд харин эсрэгээр улсын дунджаас нэлээд эрт гэрлэсэн байна.


БҮЛЭГ 8. ХҮН АМЫН ГЭРЛЭЛТЭНД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БҮЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ бүлэгт хүн амын гэр бүлийн байдалд сөргөөр нөлөөлж болохуйц зарим үзүүлэлтийг хот, хөдөө, аймаг, нийслэлээр тодорхойлон гаргасан бөгөөд үүнд хожуу гэрлэх, гэр бүл цуцлах, тусгаарлах, бэлбэсрэх талаар голлон авч үзэв. Хүн ам зүйн эдгээр үзэгдлийг авч үзэхдээ нас, хүйс, үндэс угсаа, боловсролын төвшинтэй нь холбон судлав.

2010 оны тооллогын дүнгээс харахад Монгол Улсын нийт хүн амын 69.2 хувь (1905969 хүн) арван тав, түүнээс дээш насны хүн ам байна. Эдгээр хүмүүсийн 31.3 хувь нь огт гэр бүл болоогүй, 60.1 хувь нь гэр бүлтэй (батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан), 3.1 хувь нь салсан (гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан), 5.5 хувь нь бэлбэсэн байна.

Нөхөн үржихүйн насны хүн амын гэр бүлийн байдлын тархалтыг харвал огт гэр бүл болоогүй хүн ам нөхөн үржихүйн насны эхний бүлэгт буюу 15-19 насны хүн амын 97.6 хувь, 20-24 насны хүн амын 64.8 хувь, 25 -29 насны хүн амын 28 хувийг эзэлж байна. Дараагийн насны бүлгүүдэд хурдац нь аажмаар буурч 65-аас дээш насны хүн амын 2.7 хувийг эзэлж байна.

Зураг 6.1. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, нас, хувиар, 2010 он




Харин тусгаарласан болон гэрлэлтээ цуцалсанж ам 40 -44 насныханд 6.2 хувь, 45-49 насныханд 6.3 хувь буюу хамгийн их байна.Үүний дараагаар 35 -39 нас болон 50-54 насны бүлгийнхэн орж байна. Тусгаарласан болон гэр бүлээ цуцалсан хүн хамгийн бага насны бүлгийг авч үзвэл 20-24 насныханд 0.7 хувь,

65-аас дээш насныханд 1.4 хувь байна. Ерөнхийдөө 25-29 насны бүлгээс 60-64 насны бүлэгт тусгаарлах болон гэр бүл цуцлах нь нэлээд ажиглагдаж байна.

Хүн амын гэр бүлийн байдлыг өмнөх тооллогын дүнтэй зэрэгцүүлж үзвэл 2000 оны тооллогын үед арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй хүн амын хувийн жин 33.1 хувиас сүүлийн 2010 оны тооллогоор 31.3 хувь болж буурсан байна.

Зураг 6.2. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, насны бүлэг, хувиар, 2000, 2010 он



Анхны гэрлэлтийн дундаж нас хойшилсонтой холбоотойгоор 20-24 насны болон 25-29 насны нийт хүн амд батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүн амын эзлэх хувийн жин буурсан байна. Тусгаарласан болон гэр бүлээ цуцалсан хүний нийт хүн амд эзлэх хувийн жин сүүлчийн хоёр тооллогын дүнгээс өссөн (3.1 хувь) байна. Харин бэлбэсэн үжий нийт хүн амд эзлэх хувь сүүлийн хоёр тооллогын хооронд буурч 6.4-өөс 5.5 хувь болжээ. Уг үзүүлэлтийг насны бүлгээр авч үзвэл 2010 оны тооллогоор 60, түүнээс дээш насны хүнд бэлбэсэн хүн амын эзлэх хувь буурсан байна.

6.1. Хүн амын гэр бүлийн байдалд сөргөөр нөлөөлж буй зарим үзүүлэлтийн аймаг, нийслэл, хот, хөдөөгийн ялгаатай байдал


Гэр бүл болоход ёс заншил, соёл боловсрол, ажил эрхлэлт, мэргэжил, байршил, шилжин суурьших хөдөлгөөн нөлөөлдөг нь өмнө хийсэн судалгаагаар харагдсан билээ. Иймээс энэ бүлэгт хүн ам, орон сууцны 20 10 оны тооллогоос ямар нөлөөлөл гарч байгааг дахин авч үзсэн.

Гэр бүлийн байдлыг гэр бүл болоогүй, тусгаарласан болон цуцалсан, бэлбэсэн гэсэн ангиллаар дүнд эзлэх хувиас үзвэл Улаанбаатар хотод гэр бүл болоогүй хүн амын хувийн жин их буюу 34.8 хувь байна. Үүний дараа Ховд 31.9, Дархан-Уул 31.3 хувь байна. Үзүүлэлтээр хамгийн бага хувьтай нь Булган 24.6, Говьсүмбэр 25.7, Сэлэнгэ 25.8, Дундговь аймаг 26 хувь байна.

Гэр бүлээ тусгаарласан болон цуцалсан хүний нийт дүнд эзлэх хувиар их нь Орхон аймаг 4.3, Улаанбаатар хот, Дархан-Уул, Хэнтий 3.7, Говьсүмбэр 3.6 хувь байна. Уг үзүүлэлтээр хамгийн бага нь Баян-Өлгий 0.8, Увс 1.1, Ховд 1.3, Завхан аймаг 1.3 байна.

Бэлбэсэн хүний нийт дүнд эзлэх хувиар их нь Архангай 7, Баянхонгор 7, Увс 6.8, Хөвсгөл 6.6 хувь байна. Уг үзүүлэлтээр хамгийн бага нь Өмнөговь 4, Улаанбаатар 4.8, Дорноговь 4.9 хувь байна.

Зураг 6.3. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, аймаг, нийслэлээр, дүнд эзлэх хувиар, 2010 он



Нөхөн үржихүйн насны хүн амын гэр бүлийн байдлыг огт гэр бүл болоогүй, тусгаарласан болон цуцалсан, бэлбэсэн гэсэн ангиллаар дүнд эзлэх хувиар аймгуудаар шинжилгээ хийхэд дараах байдлаар бүлэг/кластер үүссэн.

Хүснэгт 6.1. 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй, цуцалсан, тусгаарласан, бэлбэсэн хүн амын хувийн жингээр ангилсан ерөнхий бүдүүвч, 2010 он


Кластер	Байршил
Кластер 1	Архангай
	Завхан
	Өвөрхангай
	Сүхбаатар
	Увс
Кластер 2	Хөвсгөл
	Баян-Өлгий
	Баянхонгор
	Говь-Алтай
	Дорнод
Кластер 3	Ховд
	Дархан-Уул
	Дорноговь
Кластер 4	Дундговь
	Өмнөговь
	Хэнтий
	Сэлэнгэ
	Төв
Кластер 5	Булган
	Орхон
	Говьсүмбэр
Кластер 6	Улаанбаатар
	Дархан-Уул

Нөхөн үржихүйн насны хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй, тусгаарласан болон цуцалсан, бэлбэсэнүнх амаар нэгдүгээр кластерт Архангай, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл зэрэг 6 аймаг, хоёрдугаар кластерт Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Ховд, Дархан зэрэг 6 аймаг, гуравдугаар кластерт Дорноговь, Дундговь, Өмнөговь зэрэг 3 аймаг, дөрөвдүгээр кластерт Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Орхон, Говьсүмбэр зэрэг 6 аймаг, тавдугаар кластерт Улаанбаатар хот орж байна. Өөрөөр хэлбэл, дээрх үзүүлэлтээр хамгийн бага хувьтай аймгууд нэгдүгээр кластерт, их хувьтай нь тавдугаар кластерт орсон юм. Эндээс өхөн үржихүйн насны гэр бүлгүй хүний нийт хүн амд эзлэх хувийн жин нь байршлаар ялгаатай байгааг харж болно.

Нөхөн үржихүйн насны огт гэр бүл болоогүй хүмүүсийг хүйсээр, аймаг, нийслэлээр үзвэл эрэгтэйчүүдийн хувьд өндөр хувьтай нь Улаанбаатар хот 37.4, Дархан-Уул 35.1, Дорнод аймаг 34.8 хувь байна. Харин бага хувьтай нь

Булган 29.2, Өмнөговь 29.4, Дундговь 30.2, Архангай болон Орхон аймаг 30.3 хувь байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд нөхөн үржихүйн насны эмэгтэй хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй хүний хувийн жингээр өндөртэй нь Улаанбаатар хот 32.5, Ховд 29.5, Говь-Алтай 29.3 хувь, хамгийн бага нь Сэлэнгэ 18.5, Булган болон Говьсүмбэр аймаг 19.6 хувь байна.

Зураг 6.4. Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он




Нөхөн үржихүйн насны гэр бүл салсан (цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан) хүн амыг хүйсээр, аймаг, нийслэлээр авч үзвэл эрэгтэйчүүдийн хувьд хамгийн өндөр нь Орхон, Хэнтий 3.6, Дундговь 3.4 хувь байна. Харин бага нь Баян-Өлгий 0.7, Увс 1, Ховд 1.1, Завхан аймаг 1.2 хувь байна.

Эмэгтэйчүүдийн хувьд нөхөн үржихүйн насны эмэгтэйд эзлэх салсан эмэгтэйн хувийн жин хамгийн өндөр нь Орхон 5, Улаанбаатар 4.3, Дархан -Уул 4.2, Говьсүмбэр аймаг 4.1 хувь байна. Баян-Өлгий 0.9, Увс 1.1, Завхан 1.4 хувь байгаа нь хамгийн бага хувь байна.

Эрэгтэйчүүдийн хувьд Булган, Дорноговь, Дорнод, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Улаанбаатар, Орхон, Говьсүмбэр гэсэн байршлаар нөхөн үржихүйн насны эрэгтэйд эзлэх салсан эрэгтэйн хувийн жин дунджаас дээгүүр байна. Харин эмэгтэйн хувьд Өмнөговь, Хэнтий, Дархан-Уул, Улаанбаатар, Орхон, Говьсүмбэр гэсэн байршлаар нөхөн үржихүйн насны салсан эмэгтэйн хувийн жин дунджаас дээгүүр байна.

Нөхөн үржихүйн насны бэлбэсэн хүн амыг хүйс, аймаг, нийслэлээр авч үзвэл эрэгтэйн хувьд хамгийн их нь Архангай, Баянхонгор 3.3, Баян-Өлгий аймаг 3.2 хувь байна. Харин хамгийн бага Өмнөговь 1.4, Улаанбаатар хот болон Дорноговь аймаг 1.8 хувь байна.


Зураг 6.5. Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд салсан хүн амын эзлэх хувь, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он



Эмэгтэйчүүдийн хувьд нөхөн үржихүйн насны эмэгтэй хүн амд эзлэх бэлбэсэн хувийн жингээр хамгийн өндөр хувь нь Баянхонгор болон Увс 10.7, Архангай 10.6, Өвөрхангай 10.5 хувь байна. Харин хамгийн баг а нь Улаанбаатар 7.4,

Өмнөговь 7.8 хувь байна. Уг үзүүлэлтээр дунджаас дээгүүр байгаа нь эрэгтэй хүйсийн хувьд Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр, эмэгтэй хүйсийн хувьд Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймаг байна.

Зураг 6.6. Арван тав, түүнээс дээш насны бэлбэсэн хүн ам, хүйсээр, аймаг, нийслэлээр, дүнд эзлэх хувиар, 2010 он



Нөхөн үржихүйн насны огт гэр бүл болоогүй, тусгаарласан, цуцалсан, бэлбэсэн хүн амыг байршлаар хүйсийн нөлөөлөл байгаа эсэхийг нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээгээр 5 хувь болон 10 хувийн ач холбогдлын төвшинтэйг шалгаж үзэхэд бэлбэсэн хүн амын хувьд хүйсийн нөлөөлөл байгаа (10 хувийн ач холбогдлын төвшинтэйгээр) үр дүн гарсан. Өөрөөр хэлбэл, аймаг, нийслэлээр бэлбэсэн хүн амын тоо хүйсийн хувьд ялгаатай байгааг дисперсийн шинжилгээгээр баталсан.

Хүснэгт 6.2. Нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнгийн нэгдсэн хүснэгт, 2010 он

д/д	Үзүүлэлт	Ач холбогдлын түвшин	F	P-value	F crit	Үр дүн	
1	Огт гэр бүл болоогүй	0.05	0.058	0.811	4.073	Тэг таамаглалыг няцаана.	Хүйсийн нөлөөгүй.
		0.10	0.058	0.811	2.829	Тэг таамаглалыг няцаана.	Хүйсийн нөлөөгүй.
2	Тусгаарласан	0.05	0.124	0.727	4.073	Тэг таамаглалыг няцаана.	Хүйсийн нөлөөгүй.
		0.10	0.124	0.727	2.829	Тэг таамаглалыг няцаана.	Хүйсийн нөлөөгүй.
3	Цуцалсан	0.05	0.160	0.691	4.073	Тэг таамаглалыг няцаана.	Хүйсийн нөлөөгүй.
		0.10	0.160	0.691	2.829	Тэг таамаглалыг няцаана.	Хүйсийн нөлөөгүй.
4	Бэлбэсэн	0.05	3.752	0.060	4.073	Тэг таамаглалыг няцаана.	Хүйсийн нөлөөгүй.
		0.10	3.752	0.060	2.829	Тэг таамаглалыг няцаах үндэслэлгүй.	Хүйсийн нөлөөтэй.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор ганц бие буюу огт гэр бүл болоогүй хүмүүсийг нас, хүйсээр судалж үзэхэд 20-24 болон 25-29 насны залуучуудаас эрэгтэйчүүд, 40-44 буюу ахимаг насныхнаас эрэгтэйчүүд их байгаа нь ажиглагдав. Харин гэр бүл цуцалсан болон тусгаарласан хүмүүсийн хувьд 40-44 насны эмэгтэйчүүд, бэлбэсэн хүмүүсийн хувьд 60-аас дээш насны эмэгтэйчүүд их байв.

Эдгээр үзүүлэлт үүдийг аймгаар авч үзэхэд цаашид гэр бүл болох магадлал өндөр огт гэр бүл болоогүй 20-24 насны Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Улаанбаатарын эрэгтэйчүүд, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Дархан-Уул, Улаанбаатарын эмэгтэйчүүд тухайн хүйсийн хувьд тооцсон дунджаас дээгүүр байна. Харин огт гэр бүл болоогүй 25-29 насны Говь-Алтай, Дорнод, Завхан, Төв, Улаанбаатарын эрэгтэйчүүд, Дорнод, Сүхбаатар, Улаанбаатарын эмэгтэйчүүд тухайн хүйсийн хувьд тооцсон дунджаас дээгүүр байна.

Хүснэгт 6.3. 20-24, 25-29, 40-44 насны огт гэр бүл болоогүй, 40-44 насны цуцалсан/тусгаарласан, 60, түүнээс дээш насны бэлбэсэн хүн амын нийт хүн амд эзлэх хувь, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он

Аймаг, нийслэл	20-24 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	25-29 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	40-44 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	40-44 насны тусгаарласан/ цуцалсан амын эзлэх хувь	60+ насны бэлбэсэн хүн амын эзлэх хувь
Эрэгтэй - Бүгд	70.6	32.6	7.4	0.0	21.3
Архангай	69.5	28.1	5.0	0.0	22.8
Баян-Өлгий	74.0	25.9	2.4	0.0	24.0
Баянхонгор	72.9	32.4	7.7	0.0	27.5
Булган	70.8	32.2	6.9	0.0	20.9
Говь-Алтай	78.4	37.9	5.4	0.0	20.8
Дорноговь	61.8	29.0	9.7	0.0	16.9
Дорнод	71.0	36.5	10.0	0.0	22.4
Дундговь	63.8	30.2	8.8	0.0	16.7
Завхан	75.9	36.0	5.2	0.0	19.9
Өвөрхангай	70.9	31.9	6.2	0.0	21.2
Өмнөговь	64.7	32.5	6.8	0.0	1.8
Сүхбаатар	57.7	19.8	8.3	0.0	46.7
Сэлэнгэ	57.1	32.6	6.0	0.0	35.4
Төв	72.6	33.2	8.0	0.0	19.8
Увс	73.8	29.8	4.4	0.0	26.8
Ховд	75.8	31.0	4.1	0.0	20.3
Хөвсгөл	71.5	32.6	7.2	0.0	23.7
Хэнтий	66.6	29.7	9.7	0.0	18.8
Дархан-Уул	70.5	32.0	6.7	0.0	20.0
Улаанбаатар	73.0	34.4	8.7	0.0	16.6
Орхон	67.1	28.1	5.2	0.0	23.5
Говьсүмбэр	62.2	26.9	8.1	0.0	18.0
Эмэгтэй - Бүгд	57.6	23.4	6.3	0.0	51.5
Архангай	48.4	15.6	5.5	0.0	56.6
Баян-Өлгий	63.3	13.8	1.4	0.0	56.3
Баянхонгор	47.9	21.0	7.5	0.0	60.4
Булган	43.7	15.6	5.5	0.0	50.3
Говь-Алтай	59.4	20.6	9.5	0.0	54.9
Дорноговь	39.7	16.1	5.7	0.0	54.2
Дорнод	48.0	24.1	8.2	0.0	57.7
Дундговь	35.7	16.6	7.2	0.0	43.9
Завхан	51.7	18.9	7.4	0.0	51.7
Өвөрхангай	45.0	19.4	7.0	0.0	56.3
Өмнөговь	38.1	17.4	7.7	0.0	47.3
Сүхбаатар	41.4	33.3	7.1	0.0	63.2
Сэлэнгэ	44.5	16.2	4.7	0.0	50.3
Төв	44.3	16.3	5.4	0.0	51.8
Увс	48.6	14.4	3.1	0.0	62.2
Ховд	61.8	19.1	5.0	0.0	52.1
Хөвсгөл	46.3	19.2	8.7	0.0	57.2
Хэнтий	38.3	16.4	5.5	0.0	54.9
Дархан-Уул	59.2	20.2	4.6	0.0	54.7
Улаанбаатар	64.4	28.4	6.8	0.0	47.0
Орхон	51.9	20.3	4.6	0.0	60.5
Говьсүмбэр	38.7	15.0	4.7	0.0	54.7

Олон улсын нийтлэг жишгээр 40-44 нас хүртлээ огт гэр бүл болоогүй хүмүүсийг цаашид гэр бүл болох магадлал багатай гэж үздэг. 40-44 насны эрэгтэй хүн амд огт гэр бүл б олоогүй хүмүүсийн эзлэх хувийн жин тооцсон дунджаас дээгүүр байгаа нь Баянхонгор, Дорноговь, Дорнод, Төв, Хэнтий, Улаанбаатар, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Хөвсгөл, Улаанбаатарт их байна.

Гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан 40-44 насны эмэгтэйчүүдийн мөн насны хүн амд эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс 1.6 пунктээр их, эрэгтэй хүйсийн хувьд Улаанбаатар, Орхон, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, эмэгтэй хүйсийн хувьд Улаанбаатар, Орхон, Дархан -Уул гэсэн байршлаар дунджаас дээгүүр байна.

60 түүнээс дээш настай бэлбэсэн хүн амын мөн насны нийт хүн амд эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс 2.4 дахин их байна.


6.2. Хүн амын гэр бүл болоход сөргөөр нөлөөлж буй зарим үзүүлэлт, үндэс угсаагаар

Улсын хэмжээгээр өхөн үржихүйн насны огт гэр бүл болоогүй хүний 82.2 хувийг Халхчууд, 3.6 хувийг Казакчууд, 2.8 хувийг Дөрвөд, 2.1 хувийг Баяд, 1.7 хувийг Буриад эзэлж байна. Уг бүтэц нь Монгол Улсын хүн амд тухайн угсаатны хүн амын эзлэх хувийн жинээс хамаарсан бүтэц юм.

Огт гэр бүл болоогүй хүн амыг харьяалал, үндэс угсаагаар, дүнд эзлэх хувиар үзвэл Цаатан 36.4 хувь, Узбек 34.7 хувь, Халимаг 34.4 хувь огт гэр бүл болоогүй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Харин уг үзүүлэлтээр хамгийн бага нь Хорчин 15.3 хувь байна.

Хамниган, Баяд, Дөрвөд, Үзэмчин, Мянгад, Урианхай, Казак, Захчин, Торгууд, Хотон, Тува, Дархад, Халимаг, Узбек, Монголын харьяат (Орос, Хятадаас бусад) гадаад, Цаатан гэсэнүндэс угсаа танд огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь улсын дунджаас дээгүүр байна.


Зураг 6.7. Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь, үндэс угсаагаар, 2010 он



Хүйсээр авч үзвэл Халимаг эрэгтэйчүүдийн 42.9 хувь, Узбек эрэгтэйчүүдийн 39 хувь нь огт гэрлб болоогүй байгаа нь хамгийн өндөр хувь бол Хорчин эрэгтэйчүүдийн 11.4 хувь болж хамгийн бага байна. Харин Сөнөд эмэгтэйчүүдийн 50 хувь гэр бүл болоогүй байгаа нь хамгийн өндөр бол Монгол улсын харьяат бусад үндэс угсаатан 7.5 хувь, Хорчин эмэгтэйчүүдийн 18.9 хувь нь огт гэр бүл болоогүй байгаа нь бага хувь болж байна.

Огт гэр бүл болоогүй хүн ам монгол улсын нөхөн үржихүйн насны хүн амын 31.3 хувийг эзэлж, эрэгтэй хүйсийн хувьд 34.4 хувь, эмэгтэй хүйсийн хувьд 28.2 хувь байна.

Зураг 6.8. Арван тав, түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй хүн ам, хүйсээр, харьяалал, үндэс угсаагаар, дүнд эзлэх хувиар, 2010 он




Гэр бүл цуцлах, тусгаарлахыг үндэс угсаагаар авч үзвэл өндөр хувь нь Түмэд 14.3, бага хувьтай нь Халимаг, Сөнөд 0, Казак 1, Цаатан 1 хувь тус тус байна.


Уг үзүүлэлтийг хүйсээр авч үзвэл эмэгтэй хүйсийн хувьд Түмэд 25, Хамниган 8.4, Цахар 8, эрэгтэй хүйсийн хувьд харьяалалгүй иргэд 8.1, Монголын харьяат бусад угсаатан 8, Харчин 4.7 хувь байгаа нь өндөр үзүүлэлт юм. Харин гэр бүл цуцлах, тусгаарлах асуудал эмэгтэй хүйсийн хувьд Халимаг, Сөнөд, Монголын харьяат (Орос, Хятадаас бусад) иргэн, харьяалалгүй иргэнд байхгүй, эрэгтэй хүйсийн хувьд Халимаг, Түмэд, Сөнөд угсаатанд байхгүй байна.

Зураг 6.9-өөс үзвэл гэр бүл цуцалсан болон тусгаарласан хүн ам нөхөн үржихүйн насны хүн амын 3.1 хувийг эзэлж байна. Хүйсээр авч үзвэл нөхөн үржихүйн насны эрэгтэйдийн 2.7 хувь, нөхөн үржихүйн насны эмэгтэйдийн 3.5 хувь гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан байна.

Зураг 6.9. Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд гэр бүл цуцалсан болон тусгаарласан хүн амын эзлэх хувь, үндэс угсаагаар, 2010 он



Зураг 6.10. Арван тав, түүнээс дээш насны хүн амд гэр бүл цуцалсан болон тусгаарласан хүн амын эзлэх хувь, үндэс угсаа, хүйсээр, 2010 он




Нөхөн үржихүйн насны хүн амд эзлэх бэлбэсэн хүнийг угсаагаар авч үзвэл хамгийн их нь Сөнөд 14.3 хувь, харин Халимаг, Түмэд угсаатанд байхгүй байна.


Уг үзүүлэлтийг хүйсээр авч үзвэл эмэгтэйн хувьд Сөнөд 50 хувь, эрэгтэйн хувьд Цахар 10.5, Харчин 9.4 хувь байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Харин уг үзүүлэлтээр хамгийн бага нь эмэгтэйн хувьд Халимаг, Түмэдэд байхгүй, Монголын харьяат гадаад (Орос, Хятадаас бусад) иргэн 3.2 хувь, эрэгтэй хүйсийн хувьд Халимаг, Хорчин, Түмэд, Сөнөд, Хошууд, Монголын харьяат гадаад (Орос, Хятадаас бусад) иргэн тус тус байхгүй байна.

Монгол улсын нөхөн үржихүйн насны хүн амд эзлэх бэлбэсэн хүн амын хувийн жин улсын дунджаар 5.5 хувь бөгөөд эрэгтэй хүйсийн хувьд 2.2, эмэгтэй хүйсийн хувьд 8.7 хувь байна. Энэ нь манай улсын хувьд эрэгтэйчүүдийн дундаж нас эмэгтэйчүүдийнхээс доогуур байдагтай холбоотой.

Зураг 6.11. Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд бэлбэсэн хүн амын эзлэх хувь, үндэс угсаагаар, 2010 он



Зураг 6.12. Арван тав, түүнээс дээш насны хүн амд бэлбэсэн хүн амын эзлэх хувь, үндэс угсаа, хүйсээр, 2010 он



Хүснэгт 6.4. 20-24, 25-29, 40-44 насны огт гэр бүл болоогүй, 40-44 насны цуцалсан/тусгаарласан, 60, түүнээс дээш насны бэлбэсэн хүний нийт хүн амд эзлэх хувь, хүйс, үндэс угсаагаар, 2010 он

Үндэс угсаа	Эрэгтэй					Эмэгтэй				
	20-24 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	25-29 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	40-44 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	40-44 насны цуцалсан/ тусгаарласан хүн амын эзлэх хувь	60+ насны бэлбэсэн хүн амын эзлэх хувь	20-24 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	25-29 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	40-44 насны огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь	40-44 насны цуцалсан/ тусгаарласан хүн амын эзлэх хувь	60+ насны бэлбэсэн хүн амын эзлэх хувь
Бүгд	36.2	16.5	3.7	2.7	8.2	28.6	11.5	3.2	3.5	29.4
Монгол Улсын харьяат	36.1	16.4	3.7	2.7	8.3	28.5	11.5	3.2	3.6	29.5
Халх	35.6	16.2	3.8	2.9	8.1	28.1	11.6	3.3	3.8	29.4
Казак	39.0	13.7	1.6	0.9	10.5	33.2	7.9	0.8	0.9	27.9
Дөрвөд	38.2	17.2	3.0	2.0	9.0	32.0	11.3	2.2	2.2	32.9
Буриад	39.9	20.5	4.8	4.1	7.4	28.9	13.0	4.4	4.7	30.1
Баяд	39.9	18.1	2.0	1.7	8.9	31.4	11.4	2.0	1.8	28.1
Дарьганга	39.7	21.4	4.2	1.5	6.8	26.4	10.4	3.6	1.6	34.6
Урианхай	40.4	19.3	3.6	2.7	10.1	31.7	12.9	3.7	3.1	31.0
Захчин	38.7	17.3	2.4	1.6	8.9	31.5	11.9	2.9	2.7	27.2
Дархад	36.9	17.9	4.3	2.0	10.9	27.0	10.9	5.9	3.2	31.7
Торгууд	41.2	21.2	4.3	1.9	7.9	37.8	16.2	2.0	2.2	25.8
Өөлд	39.4	19.2	2.9	2.9	8.2	32.2	12.5	2.6	3.9	29.9
Хотон	34.8	10.8	1.1	1.3	13.4	27.3	8.1	1.0	1.3	32.8
Мянгад	42.3	15.9	2.9	2.6	6.5	31.6	11.7	2.9	2.9	30.0
Барга	37.9	18.5	4.8	2.4	7.7	31.6	12.9	4.3	2.4	35.1
Үзэмчин	35.8	16.4	5.9	3.9	9.2	28.8	13.3	3.3	2.0	37.4
Харчин	31.3	14.3	6.7	0.0	31.6	31.3	21.4	0.0	0.0	15.8
Цахар	54.5	9.1	0.0	14.3	17.6	18.2	27.3	0.0	28.6	11.8
Хотогойд	38.1	16.9	4.1	2.8	9.1	23.2	9.3	3.4	2.8	29.9
Элжигэн	44.7	12.0	3.1	0.0	8.4	17.6	8.8	3.1	1.0	47.0
Цаатан	44.8	7.7	5.6	0.0	9.1	31.0	15.4	33.3	0.0	9.1
Сартуул	35.0	11.3	3.3	1.1	7.7	25.8	11.3	7.8	2.2	33.3
Тува	38.8	18.8	3.0	1.3	9.6	32.7	10.0	2.7	2.3	26.6
Хорчин	11.1	0.0	0.0	0.0	0.0	33.3	0.0	0.0	0.0	25.0
Узбек (Чантуу)	61.1	23.8	0.0	6.7	9.1	22.2	14.3	6.7	0.0	22.7
Халимаг	25.0	33.3	0.0	0.0	0.0	50.0	0.0	0.0	0.0	0.0
Түмэд	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Сөнөд	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	50.0	0.0	0.0	33.3
Хамниган	32.3	29.5	7.7	2.6	15.4	32.3	6.8	0.0	5.1	21.5
Хошууд	25.0	20.0	0.0	12.5	0.0	62.5	30.0	0.0	0.0	0.0
Монголын харьяат бусад угсаатан	52.4	19.5	0.0	0.0	17.1	21.4	14.6	0.0	21.7	40.0
Орос (Монголын харьяат)	20.0	14.3	12.5	0.0	0.0	30.0	14.3	0.0	12.5	50.0
Хятад (Монголын харьяат)	75.0	21.4	11.1	0.0	14.3	25.0	7.1	0.0	0.0	28.6
Бусад гадаад (Монголын харьяат)	42.9	20.0	8.3	0.0	9.8	25.0	5.0	4.2	0.0	36.6
Гадаадын харьяат	52.6	34.9	4.9	1.5	4.3	29.6	14.7	2.0	1.4	15.5
Харьяалалгүй	25.0	27.3	11.1	0.0	14.3	25.0	18.2	11.1	0.0	14.3

Дээрх хүснэгтээс харахад цаашид гэр бүл болох магадлал өндөртэй огт гэр бүл болоогүй 20-24 насны Түмэд, Сөнөд угсаатан эрэгтэйчүүд, Хошууд, Халимаг эмэгтэйчүүд, 25-29 насны гадаадын харьяат, Халимаг, Хамниган эрэгтэйчүүд, Сөнөд, Хошууд, Цахар эмэгтэйчүүд улсын дунджаас нэлээд дээгүүр хувийг эзэлж байна.

Цаашид гэр бүл болох магадлал багатай 40-44 насны Монголын харьяат Орос, Хятад, харьяалалгүй эрэгтэйчүүд, Цаатан болон харьяалалгүй эмэгтэйчүүд улсын дунджаас нэлээд дээгүүр хувийг эзэлж байна.

40-44 насны салсан¹ Цахар, Хошууд эрэгтэйчүүд, Цахар, Монголын харьяат бусад угсаатан, Монголын харьяат орос эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын дунджаас дээгүүр байна.

¹ Цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Харин 60, түүнээс дээш насны бэлбэсэн Харчин, Цахар, Монголын харьяат бусад угсаатан эрэгтэйчүүд, Монголын харьяат Орос, Элжигэн, Монголын харьяат бусад угсаатан эмэгтэйчүүд улсын дунджаас харьцангуй дээгүүр хувийг эзэлж байна.

6.3. Хүн амын гэр бүл болоход сөргөөр нөлөөлж буй зарим үзүүлэлт, боловсрол, бичиг үсгийн мэдлэгээр

Нөхөн үржихүйн насны хүн амын гэр бүл болох явдлыг боловсролын төвшин, байршил, хүйсээр хүснэгт 6.5-д үзүүлэв. Хүснэгтээс харахад боловсролгүй хүн амын 40.3 хувь огт гэр бүл болоогүй байхад боловсролтой хүн амын 30.9 хувь огт гэр бүл болоогүй байна. Уг үзүүлэлтийг хот, хөдөөгөөр үзвэл хотод боловсролгүй хүн амын 43.7 хувь, хөдөөд 38.7 хувь нь огт гэр бүл болоогүй байна.

Хүснэгт 6.5. Арван тав, түүнээс дээш настай суурин хүн амын гэр бүлийн байдал, боловсролын байдал, хот, хөдөө, дүнд эзлэх хувиар, 2010 он

Боловсролын төвшин	Гэр бүлийн байдал			
	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан/ Батлуулаагүй гэр бүлтэй	Цуцалсан/ Тусгаарласан	Бэлбэсэн
Бүгд	31.3	60.1	3.1	5.5
Боловсролгүй	40.3	43.2	2.1	14.4
Боловсролтой	30.9	60.9	3.1	5.1
Бага	30.0	54.0	1.9	14.1
Бүрэн бус дунд	40.1	53.3	2.6	4.0
Бүрэн дунд	35.9	58.0	3.0	3.1
Техникийн болон мэргэжлийн	21.9	68.4	4.2	5.5
Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	10.8	74.8	4.8	9.6
Дээд	21.7	71.0	3.9	3.4
Хот - Бүгд	33.0	58.2	3.6	5.2
Боловсролгүй	43.7	36.0	2.5	17.8
Боловсролтой	32.8	58.6	3.6	5.0
Бага	33.8	44.6	2.5	19.1
Бүрэн бус дунд	47.6	44.8	3.1	4.5
Бүрэн дунд	38.7	54.9	3.2	3.2
Техникийн болон мэргэжлийн	23.8	65.0	5.2	6.0
Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	11.5	73.3	5.4	9.8
Дээд	21.6	70.8	4.1	3.5
Хөдөө - Бүгд	27.1	64.7	2.1	6.1
Боловсролгүй	38.7	46.9	1.8	12.6
Боловсролтой	30.0	66.6	2.0	5.4
Бага	27.6	59.6	1.6	11.2
Бүрэн бус дунд	31.2	63.3	2.0	3.5
Бүрэн дунд	24.0	70.9	2.1	3.0
Техникийн болон мэргэжлийн	19.0	73.7	2.7	4.6
Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	8.3	80.1	2.8	8.8
Дээд	22.6	72.5	2.3	2.6

Боловсролтой хүн амаас хотод бүрэн бус дунд боловсролтой хүн амын 47.6 хувь огт гэр бүл болоогүй, хөдөөд бүрэн бус дунд боловсролтой хүн амын 31.2 хувь огт гэр бүл болоогүй нь хамгийн өндөр хувьтай байна. Харин тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд боловсролтой хүн амд огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь хотод 11.5, хөдөөд 8.3 байгаа нь бага байна. Дээрх хандлага нь хүйсийн хувьд ч ерөнхийдөө хадгалагдаж байна.

Харин боловсролгүй хүн амын 2.1 хувь, боловсролтой хүн амын 3.1 хувь нь гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан байна. Өөрөөр хэлбэл, боловсролтой хүний гэр бүлээсээ салах нь боловсролгүй хүнийхээс 1 пунктээр их байна. Гэр бүл цуцалсан болон тусгаарласан байдлыг хот, хөдөөгөөр болон хүйсээр үзвэл дээрх хандлага байна.

Боловсролгүй хүн амын 14.4 хувь, боловсролтой хүн амын 5.1 хувь нь бэлбэсэн, уг харьцаа хот, дүүргийн хувьд ерөнхийдөө хадгалагдаж байна. Харин хүйсийн хувьд боловсролгүй эмэгтэйчүүдийн 26.2 хувь нь бэлбэсэн нь боловсролтой болон боловсролгүй эрэгтэйчүүд, боловсролтой эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад 3.3-аас 12.5 дахин их байна.

Хүснэгт 6.6. Арван тав, түүнээс дээш настай суурин хүн амын тоо, боловсролын байдал, гэрлэлтийн байдал, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010 он

Боловсролын төвшин	Гэр бүлийн байдал			
	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан/ Батлуулаагүй гэр бүлтэй	Цуцалсан/ Тусгаарласан	Бэлбэсэн
Эрэгтэй - Бүгд	34.4	60.7	2.7	2.2
Боловсролгүй	47.6	45.9	2.2	4.3
Боловсролтой	33.8	61.4	2.7	2.1
Бага	35.0	57.7	2.1	5.2
Бүрэн бус дунд	41.0	54.5	2.7	1.8
Бүрэн дунд	38.4	57.8	2.6	1.2
Техникийн болон мэргэжлийн	25.2	68.7	3.8	2.3
Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	15.3	77.0	4.0	3.7
Дээд	21.2	74.2	2.7	1.9
Эмэгтэй - Бүгд	28.2	59.6	3.5	8.7
Боловсролгүй	31.8	40.2	1.8	26.2
Боловсролтой	28.1	60.4	3.5	8.0
Бага	24.1	49.8	1.8	24.3
Бүрэн бус дунд	38.8	51.7	2.5	7.0
Бүрэн дунд	33.4	58.2	3.3	5.1
Техникийн болон мэргэжлийн	18.1	68.0	4.8	9.1
Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	7.9	73.4	5.3	13.4
Дээд	22.1	68.8	4.7	4.4

Хүснэгт 6.6-аас харахад огт гэр бүл болоогүй хүн амын 41.3 хувь нь бүрэн дунд боловсролтой, 24.6 хувь нь суурь боловсролтой, 13.5 хувь нь дипломын болон бакалаврын боловсролтой байна.

Хүснэгт 6.7. Арван тав, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, боловсролын байдал, гэр бүлийн байдал, дүнд эзлэх хувиар, 2010 он

Боловсролын төвшин	Бүгд	Гэр бүлийн байдал					
		Огт гэр бүл болоогүй	Батлуулсан гэр бүлтэй	Батлуулаагүй гэр бүлтэй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлбэсэн
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Доктор	0.2	0.0	0.3	0.1	0.2	0.4	0.2
Магистр	1.7	0.8	2.2	1.9	1.9	3.1	0.9
Дипломын болон бакалаврын дээд	18.8	13.5	21.9	22.4	20.5	24.3	11.8
Тусгай мэргэжлийн дунд	6.5	2.2	8.2	6.7	9.2	10.6	11.2
Техник болон мэргэжлийн	3.2	2.2	3.7	3.2	4.4	4.3	3.1
Бүрэн дунд	36.0	41.3	33.6	41.3	35.2	33.9	20.9
Суурь	19.2	24.6	17.3	15.8	17.7	15.2	14.2
Бага	10.3	9.8	9.8	5.7	7.6	5.7	26.5
Боловсролгүй	4.3	5.5	3.1	2.9	3.3	2.4	11.2

Харин гэр бүл цуцалсан болон тусгаарласан хүн амын ойролцоогоор 1/3 нь бүрэн дунд боловсролтой буюу хамгийн их хувийг эзэлж байгаа бол доктор зэрэгтэй хүн амын хувьд 0.2-0.4 хувийг буюу бага хувийг эзэлж байна. Бэлбэсэн хүн амын 20.9 хувь бүрэн дунд боловсролтой, 20.5 хувь бага боловсролтой, 14.2 хувь суурь боловсролтой байна. Эндээс бэлбэсэн хүн амын 70 -аад хувь нь бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой нь харагдаж байна.

Хүснэгт 6.8. Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, боловсролын байдал, гэр бүлийн байдлаар

Боловсролын төвшин	Гэр бүлийн байдал					
	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан гэр бүлтэй	Батлуулаагүй гэр бүлтэй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлбэсэн
Доктор	218	2751	218	39	144	211
Магистр	4728	21379	2999	454	1105	900
Дипломын болон бакалаврын дээд	80215	215954	35500	4855	8588	12314
Тусгай мэргэжлийн дунд	13249	81469	10573	2177	3760	11769
Техник болон мэргэжлийн	13210	36172	5072	1049	1512	3293
Бүрэн дунд	246110	332072	65555	8329	11975	21894
Суурь	146806	170357	25003	4180	5385	14815
Бага	58602	96743	9070	1790	2024	27710
Боловсролгүй	32947	30678	4673	787	854	11733

Нөхөн үржихүйн насны хүн амын тоонд гэр бүлийн байдал болон боловсролын төвшин нөлөөтэй эсэхийг 5 хувийн ач холбогдлын төвшинтэйгээр хоёр хүчин зүйлийн дисперсийн шинжилгээгээр шинжилжүзэхэд сонгон авсан хүчин зүйл аль аль нь нөлөөтэй (боловсролын төвшин: $p\text{-value}=0.0600265$, гэр бүлийн байдал: $p\text{-value}=0.00004$) нь батлагдсан. Өөрөөр хэлбэл, нөхөн үржихүйн насны хүн амын тоо нь гэр бүлийн байдлаар болон боловсролын төвшингөөр ялгаатай буюу уг хоёр хүчин зүйлийн нөлөөтэй нь харагдаж байна.

БҮЛЭГ 9. ГЭР БҮЛ ХОСУУДЫГ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ЗЭРЭГЦҮҮЛСЭН БАЙДАЛ

7.1. Гэр бүлийн хосуудыг боловсролын төвшингөөр зэрэгцүүлсэн байдал

Орчин үеийн нийгмийн шинжлэх ухаанд боловсролын асуудлыг онцгойлон үзэх болсон. Учир нь боловсролын асуудлыг авч үзсэнээр нийгэм, эдийн засгийн асуудлууд болох эрх мэнд, гэмт хэрэг, шилжих хөдөлгөөн, төрөлт, нас баралт, ядуурал, ажил эрхлэлт гэх мэт олон асуудлуудыг багцаар нь шийдэх боломжтой болдог байна.

Хүснэгт 7.1-ээс харахад эмэгтэйчүүдийн боловсролын төвшин ерөнхийдөө өндөр болсны улмаас дийлэнх олонх нь (2/3-оос дээш хувь нь) өөрсөө доогуур боловсролтой өхөртэй байна. Тухайлбал, 20 -34 насны докторын зэрэгтэй эмэгтэйчүүдийн 87.5 хувь нь, магистрын зэрэгтэй эмэгтэйчүүдийн 76.8 хувь нь, техник мэргэжлийн боловсролтой эмэгтэйчүүдийн 72.4 хувь нь өөрсдөөсөө доогуур боловсролын төвшинтэй эрэгтэйтэй гэрлэсэн байна.

Мөн 35-49 насны эмэгтэйчүүдийн хувьд ч байдал адилхан байна. Залуу эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт докторт 2.4 пунктээр, магистрын болон техник мэргэжлийн хувьд тус бүр 9.2 пунктээр илүү байна. Эндээс дүгнэж үзвэл боловсролын өвшин нэмэгдэх тусам эмэгтэйчүүд өөрсдөөсөө доогуур боловсролын төвшинтэй эрэгтэйтэй гэрлэж байгаа нь 2000 оны тооллогын үр дүнтэй адил байна.

Хүснэгт 7.1. Гэрлэсэн хосуудын боловсролын төвшин, эхнэрийн насны бүлгээр, 2010 он

Өрхийн тэргүүлэгчийн боловсролын төвшин, эхнэрийн насны бүлгээр	Эхнэрийн боловсролын төвшин								
	Доктор	Магистр	Дипломын болон бакалаврын дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник мэргэжлийн	Бүтэцгүй	Суурь	Бага	Боловсролгүй
20-34									
Доктор	12.5	1.7	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Магистр	31.7	21.4	3.1	0.6	0.2	0.2	0.0	0.0	0.0
Дипломын болон бакалаврын дээд	47.1	52.6	49.2	17.9	7.1	8.5	1.1	0.5	0.4
Тусгай мэргэжлийн дунд	0.0	2.7	3.3	15.0	3.1	2.5	1.1	0.5	0.3
Техник мэргэжлийн	1.0	1.0	1.9	3.5	17.3	2.1	2.3	1.0	0.8
Бүрэн дунд	7.7	17.2	31.6	39.3	27.5	58.6	14.4	8.1	6.8
Суурь	0.0	2.6	7.5	15.8	25.0	16.8	52.3	22.5	18.3
Бага	0.0	0.6	2.6	6.2	14.1	8.5	21.0	53.9	28.4
Боловсролгүй	0.0	0.1	0.6	1.8	5.8	2.7	7.7	13.6	45.0
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	104	4 047	57 360	5 149	2 949	64 764	29 314	16 030	6 272
<i>Ижил боловсролын төвшинтэй эрэгтэйтэй гэрлэсэн эмэгтэйн хувь</i>	12.5	21.4	49.2	15.0	17.3	58.6	52.3	53.9	45.0
<i>Өрхийн тэргүүлэгч доогуур боловсролын төвшинтэй</i>	87.5	76.8	47.6	66.5	72.4	28.0	28.7	13.6	-
<i>Өрхийн тэргүүлэгч дээгүүр боловсролын төвшинтэй</i>	-	1.7	3.2	18.5	10.3	13.4	19.0	32.6	55.0
35-49									
Доктор	14.9	3.9	0.6	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0
Магистр	34.3	28.5	5.0	1.2	0.3	0.3	0.0	0.2	0.0
Дипломын болон бакалаврын дээд	37.3	39.5	43.7	15.6	5.6	5.5	1.1	1.1	0.6
Тусгай мэргэжлийн дунд	3.4	8.4	11.1	22.6	8.1	6.0	2.5	2.4	1.7
Техник мэргэжлийн	1.8	2.6	4.4	7.9	22.8	4.7	4.2	3.3	3.2
Бүрэн дунд	7.6	14.9	28.4	34.8	26.1	57.1	16.1	12.2	8.8
Суурь	0.5	1.7	6.0	14.8	27.6	20.5	57.3	25.0	25.8
Бага	0.2	0.4	0.8	2.5	7.3	4.7	13.7	47.2	24.3
Боловсролгүй	0.0	0.0	0.1	0.5	2.2	1.2	5.0	8.5	35.5
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	437	5 128	36 161	24 861	10 042	73 871	30 220	7 277	2 788
<i>Ижил боловсролын төвшинтэй эрэгтэйтэй гэрлэсэн эмэгтэйн хувь</i>	14.9	28.5	43.7	22.6	22.8	57.1	57.3	47.2	35.5
<i>Өрхийн тэргүүлэгч доогуур боловсролын төвшинтэй</i>	85.1	67.6	50.7	60.5	63.2	26.5	18.7	8.5	-
<i>Өрхийн тэргүүлэгч дээгүүр боловсролын төвшинтэй</i>	-	3.9	5.7	16.9	14.0	16.4	24.1	44.3	64.5

Өөртэйгөө ижил боловсролын төвшинтэй эрэгтэйтэй гэрлэсэн эмэгтэйчүүд 20-34 насанд бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд 58.6 хувь, бага боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд 53.9 хувь, суурь боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд 52.3 хувь байгаа нь хамгийн өндөр байна. Энэ үзүүлэлт 35-49 насныхны хувьд суурь боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд 57.3 хувь,

бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд 57.1 хувь, бага боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд 47.1 хувь байгаа нь боловсролын төвшин нэмэгдэх тусам өөртэйгөө ижил боловсролтой (ялангуяа магистр, докторын хувьд) нх тэй гэрлэх боломж бага байгааг харуулж байна.

Хотын гэрлэсэн хосуудын боловсролын төвшин хөдөөгийнхтэй харьцуулахад өндөр байдаг нь тодорхой юм. Гэхдээ докторын зэрэгтэй эмэгтэйчүүд 20-34 насанд нийт 104 байгаа ч бүгд хотод өөрөөр хэлбэл хөдөө докторын зэрэгтэй эмэгтэйчүүд байхгүй байна. Харин 34-49 насанд докторын зэрэгтэй нийт 437 эмэгтэй байгаа ч өдөөд ердөө 3 эмэгтэй байгаа нь энэ тал дээр анхаарлаа хандуулах цаг болсныг илтгэж байна.

Хүснэгт 7.1-ээс харахад хүйс нь боловсролын төвшинтэй хамааралтай байна. Тиймээс нийгэм, эдийн засгийн талаарх шинжилгээг (цалингийн, ажлын зэрэглэлийн, орлого зарлагын гэх мэт) хийхэд хүйс, боловсролын төвшингийн тус тусын нөлөөллийг тооцохоос гадна хүйс болон боловсролын төвшингийн хамтын нөлөөллийг зайлшгүй тооцох шаардлагатай байна.

7.2. Гэр бүлийн хосуудыг ажил мэргэжлээр зэрэгцүүлсэн байдал

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 20-49 насны гэр бүл хосуудыг ажил мэргэжлийн ангилал, хүйсийн ялгаатайгаар 11 бүлэгт хуваасан.

Гэр бүл хосуудын боловсролын асуудал нь хосуудын ажил мэргэжил, ажиллаж буй салбарыг тодорхойлох үндэс нь болж өгдөг. Тиймээс гэрлэсэн хосуудын ажил мэргэжлийг боловсролын төвшинтэй уялдаатайгаар харьцуулан авч үзэх замаар дүгнэлт гаргах боломжтой. Өмнөх хэсэгт эмэгтэйчүүд өөрсдөөсөө доогуур боловсролын төвшинтэй эрэгтэйтэй гэрлэсэн хувь өндөр байсан бол ажил мэргэжлийн ангиллаар авахад эсрэгээрээ менежер гэсэн бүлэгт багтах эрэгтэйчүүд өөрсдөөсөө албан тушаалын зэрэглэл багатай эмэгтэйчүүдтэй гэрлэсэн хувь өндөр байна. Тухайлбал, Хүснэгт 7.2-оос харахад менежерээс өөр ажил мэргэжил эрхэлдэг 20-34 насны эмэгтэйчүүд менежер эрэгтэйтэй гэрлэсэн хувь 64.3 хувь байгаа бол 35-49 насны эмэгтэйчүүдийн хувьд 54.8 хувь байна.

Хүснэгт 7.2. Гэрлэсэн хосын ажил эрхлэлт, эхнэрийн насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2010 он

Өрхийн тэргүүлэгчийн ажил мэргэжил, эхнэрийн насны бүлгээр	Эхнэрийн ажил мэргэжил										
	Менежер	Мэргэжилтэн	Техникч болон туслах дэд мэргэжилтэн	Контор,	Худалдаа,	Хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, ажилтан	Машин механизм, т операторч, угсрагч	Энгийн ажил мэргэжил	Зэвсэгт х офицер	Бусад
20-34											
Менежер	35.7	15.0	9.4	14.0	7.7	0.2	3.7	6.5	2.7	6.7	0.0
Мэргэжилтэн	21.6	30.6	13.6	20.7	7.7	0.2	5.3	6.6	5.2	7.5	6.7
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	5.7	5.6	12.9	6.1	3.1	0.0	2.3	1.8	2.8	2.7	6.7
Контор, үйлчилгээний ажилтан	2.3	2.4	2.3	5.7	1.3	0.0	0.7	0.7	1.0	1.1	6.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	10.6	11.3	12.1	12.7	33.4	0.0	9.8	7.6	11.7	8.6	13.3
Хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан	1.6	3.6	2.4	1.9	2.3	99.0	2.8	1.1	2.9	0.5	6.7
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	6.3	9.0	16.4	10.6	15.1	0.1	49.0	15.5	21.5	4.3	33.3
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	12.1	16.4	19.1	19.8	21.5	0.2	17.4	54.0	21.1	11.8	13.3
Энгийн ажил мэргэжил	2.0	3.7	6.8	4.1	6.0	0.2	7.1	5.0	29.0	1.9	13.3
Зэвсэгт хүчний зэрэг, цол бүхий офицер	2.1	2.4	5.0	4.4	1.9	0.0	1.9	1.3	2.1	55.1	0.0
Бусад	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
35-49											
Менежер	45.2	19.9	12.7	16.6	9.5	0.7	4.6	8.1	3.5	8.1	2.3
Мэргэжилтэн	15.1	22.3	11.0	12.6	6.1	0.4	5.4	6.1	4.5	6.7	12.5
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	4.3	4.7	10.2	4.6	2.4	0.1	2.3	2.2	2.4	1.1	0.0
Контор, үйлчилгээний ажилтан	1.7	2.1	1.9	4.7	1.2	0.1	0.8	1.2	1.7	0.8	1.1
Худалдаа, үйлчилгээний ажилтан	8.4	9.9	10.1	10.2	35.8	0.1	8.4	6.1	10.3	6.7	19.3
Хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан	2.1	3.5	3.2	2.4	2.1	97.4	2.2	1.7	3.2	2.2	2.3
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	5.8	10.0	16.0	12.5	12.6	0.2	48.2	16.0	20.3	9.7	33.0
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	12.9	20.3	23.9	25.1	22.2	0.5	19.5	51.6	22.5	16.7	23.9
Энгийн ажил мэргэжил	3.0	5.4	8.4	7.5	6.9	0.5	7.4	5.2	29.9	5.1	3.4
Зэвсэгт хүчний зэрэг, цол бүхий офицер	1.5	1.9	2.8	3.8	1.1	0.0	1.2	1.6	1.5	42.9	2.3
Бусад	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.0
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100

Ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалаад 20-34 насны өдөө аж ахуйн мэргэшсэн эмэгтэй ажилчдын 99.0 хувь, 35-49 насны энэ мэргэжлийн эмэгтэй ажилчдын 97.4 хувь нь ижил мэргэжлийн эрэгтэйтэй гэрлэсэн байна. Үүний гол шалтгаан нь өдөө орон нутагт хөдөө аж ахуйн мэргэжил зонхилдогтой холбоотой юм. Энэ үзүүлэлт нь бусад мэргэжлийн хамгийн өндөр хувиас даруй 43.9-45.8 пунктээр илүү байна. Үүний дараа машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагчид болон зэвсэгчний зэрэг, цол бүхий офицер эмэгтэйчүүд ижил мэргэжлийн эрэгтэйчүүдтэй гэрлэсэн хувь 42.9-55.1 байна.

Энэ үзүүлэлт хамгийн багатай нь контор үйлчилгээний ажилчид ердөө 4.7-5.7 хувь байна.

Ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалаад гэрлэсэн хосуудын эрэгтэйчүүд менежер; хөдөө аж ахуйн мэргэшсэн; үйлдвэрлэл, барилга, гар урлал; машин механизм; зэвсэгт үжинд илүү ихээр ажиллаж байгаа бол эмэгтэйчүүд мэргэжилтэн; техникч болон туслах мэргэжилтэн; контор үйлчилгээний ажил; энгийн мэргэжилд илүү ихээр ажиллаж байна.

7.3. Гэр бүлийн хосуудыг үндэс угсаагаар зэрэгцүүлсэн байдал

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор Монгол Улсын харьяат иргэдийн үндэс угсааны талаарх мэдээллийг 29 бүлгээр цуглуулан авсан. Гэр бүлийн хосуудыг үндэс угсаагаар нь судлахдаа хүн амд эзлэх хувь хамгийн өндөр халх (82.4%), казак (3.9%), дөрвөд (2.8%), баяд (2.2%), буриад (1.7%) гэсэн 5 бүлгийг авч хүн амд эзлэх хувь 1.7%-с бага бүлгийг “бусад” гэж нэгтгэсэн.


Хориос гучин өдөр насны гэр бүлийн хосуудыг харвал хамгийн өндөр хувьтайгаар казак (96.51), халх (93.93) эмэгтэйд өөртэйгөө ижил үндэс угсаатай хүнтэй гэр бүл болж байгаа бол энэ үзүүлэлт буриад эмэгтэйчүүдийн хувьд хамгийн бага ердөө 36.1 хувь байна. Түүнчлэн дөрвөд, буриад, баяд болон бусад ястан, үндэстний эмэгтэйчүүд халх эрэгтэйтэй гэр бүл болох хувь хамгийн бага нь 25.0 байгаа бол хамгийн их нь 56.4 хувь байна.

Хүснэгт 7.3. Гэрлэсэн хосын тоо, өрхийн тэргүүлэгч болон эхнэрийн үндэс угсаа, эхнэрийн насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2010 он

Нөхрийн яс үндэс, эхнэрийн насны бүлгээр	Эхнэрийн яс үндэс											
	Халх		Казак		Дөрвөд		Буриад		Баяд		Бусад	
	2000	2010	2000	2010	2000	2010	2000	2010	2000	2010	2000	2010
20-34												
Халх	95.4	93.9	1.1	2.5	15.9	25.1	45.4	56.4	14.1	23.7	19.8	27.8
Казак	0.1	0.1	98.2	96.5	0.1	0.2	0.2	0.0	0.1	0.1	0.4	0.5
Дөрвөд	0.8	1.0	0.1	0.1	68.1	57.1	1.1	1.1	13.3	12.9	2.4	2.7
Буриад	0.9	1.1	0.0	0.1	0.5	0.5	48.1	36.1	0.2	0.7	0.8	0.8
Баяд	0.6	0.8	0.0	0.0	10.4	10.3	0.6	0.7	70.0	59.2	0.8	1.0
Бусад	2.3	3.1	0.6	0.7	4.9	6.8	4.6	5.7	2.4	3.3	75.8	67.1
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	143 174	153 642	9 083	7 272	5 152	5 023	2 414	2 763	4 035	3 804	12 463	13 131
35-49												
Халх	94.1	94.2	1.3	1.7	20.1	19.4	44.9	51.6	18.9	19.6	23.9	25.7
Казак	0.1	0.1	98.0	97.4	0.2	0.2	0.3	0.2	0.2	0.0	0.2	0.3
Дөрвөд	0.9	0.9	0.1	0.1	63.5	63.2	0.9	1.3	14.1	14.1	2.2	2.2
Буриад	0.6	1.2	0.0	0.0	0.3	0.7	47.5	40.8	0.3	0.3	0.9	0.9
Баяд	1.3	0.7	0.1	0.0	10.4	11.4	0.7	0.8	64.0	63.3	0.8	0.8
Бусад	2.9	2.9	0.6	0.8	5.4	5.1	5.7	5.3	2.6	2.7	72.0	70.0
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	120 889	155 557	5 931	7 661	4 190	5 522	2 791	3 010	3 304	4 482	10 535	13 904

Зураг 7.1-ээс харахад эмэгтэйчүүдийн ижил үндэс угсаатантай гэр бүл болсон хувийг 2000 оны тооллоготой харьцуулахад бүх бүлэгт 1.5 -12 пунктээр буурсан байгаа нь залуучуудын хувьд гэр бүл болоход үндэс угсааны ялгаа чухал биш болсоор байгааг харуулж байна.

Зураг 7.1. 20-34 насны эмэгтэйчүүдийн ижил үндэст угсаатантай гэр бүл болсон хувийг хоёр тооллогоор харьцуулсан байдал



Харин 35-49 насны эмэгтэйчүүдийг 20-34 насны эмэгтэйчүүдтэй харьцуулахад ижил үндэс угсаатантай гэрлэсэн хувь 2000 оны тооллогоор 0.2-6 пунктээр бага гарч байсан бол 2010 оны тооллогоор эмэгтэйчүүд эсрэгээрээ 35-49 насны эмэгтэйчүүд 20-34 насны эмэгтэйчүүдээс 0.3-6.1 пунктээр өндөр байгаа нь гэр бүлийн бүтцэд тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарч байна гэж үзэх үндэстэй юм.

7.4. Гэр бүлийн хосуудыг шашин шүтлэгээр зэрэгцүүлсэн байдал

Дэлхийн улс орнуудад шашин шүтлэг нь нийгмийн харилцаанд ихээхэн гүнзгий нөлөөтэй байдаг. Тиймээс нийгмийн харилцааны салшгүй нэг хэсэг болох гэр бүл, гэрлэсэн хосуудын асуудлыг авч үзэхэд шашин шүтлэгийг зайлшгүй анхаарах шаардлагатай юм.

Хүснэгт 7.4-өөс 20-49 насны гэрлэсэн хосуудыг шашин шүтлэгээр нь харьцуулан судалж үзэхэд эрэгтэйчүүдийн (эмэгтэйчүүдийн) 38.4 хувь (32.9%) нь шүтлэггүй, 53.6 хувь (58.2%) нь буддын шашин, 1.3 хувь (1.9%) нь христийн шашин, 3.5 хувь (3.54%) нь лалын шашин, 2.7 хувь нь (3.06%) бусад шашин, 0.35 хувь нь (0.34%) нь бусад шашиныг шүтдэг байна. Эндээс харахад шашин шүтдэггүй болон буддын шашин шүтдэг гэрлэсэн хосууд нийт гэрлэсэн хосуудын 90-ээс дээш хувийг эзэлж байна.

Хүснэгт 7.4. 20-49 насны гэрлэсэн эмэгтэйн болон нөхрийн шашин шүтлэг, дүнд эзлэх хувиар, 2010 он

Гэрлэсэн хосууд, шашин шүтлэгээр	Нийт		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Шүтдэггүй	38.4	33.0	40.0	34.0	35.5	31.2
Будда	53.7	58.2	52.3	57.2	56.1	60.0
Христ	1.3	1.9	1.8	2.6	0.4	0.6
Ислам	3.6	3.5	2.2	2.2	6.0	5.9
Бөө	2.8	3.1	3.3	3.7	1.8	1.9
Бусад	0.3	0.3	0.4	0.4	0.3	0.3
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	376 774		240 049		136 725	

Шашин шүтлэгийг хот, хөдөөгөөр ялгаатай авч үзэхэд буддын шашин, лалын шашин шүтдэг гэрлэсэн хосууд хөдөөд өндөр хувьтай байгаа бол шашин шүтдэггүй, христийн шашин, бөөгийн шашин, бусад шашин шүтдэг гэрлэсэн хосууд хотод илүү өндөр хувьтай байна.

Гэр бүл бологсад нь эхнэрээ (нөхрөө) сонгоход шашин шүтлэг нөлөөлдөг байж болох талтай. Хүснэгт 7.5 -аас харахад лалын шашинтай эрэгтэйч эмэгтэйчүүдийн хоорондоо гэр бүл болсон хувь хамгийн өндөр 95.7 хувь, шүтлэггүй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хоорондоо гэр бүл болсон хувь 89.9, буддын шашин шүтдэг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хоорондоо гэр бүл болсон хувь 86.1 хувь байгаа бол энэ үзүүлэлт христийн шашин шүтдэг хосуудын хувьд хамгийн бага буюу 54.1 хувьтай байна.

Хүснэгт 7.5. 20-49 насны гэрлэсэн эмэгтэйн болон нөхрийн шашин шүтлэгийн холбоо, дүнд эзлэх хувиар, 2010 он

Нөхрийн шашин шүтлэг	Эхнэрийн шашин шүтлэг					
	Шүтдэггүй	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
Шүтдэггүй	90.0	12.9	27.7	3.1	17.2	19.2
Будда	8.6	86.1	16.4	0.7	12.2	11.5
Христ	0.3	0.2	54.1	0.1	0.2	0.9
Ислам	0.3	0.1	0.6	95.7	0.3	0.6
Бөө	0.8	0.6	0.9	0.2	69.8	2.3
Бусад	0.1	0.1	0.3	0.0	0.3	65.5
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	124 186	219 267	7 157	13 351	11 522	1 291

Гэрлэсэн хосуудыг 20-34, 35-49 гэсэн насны ялгаатайгаар авч үзэхэд шүтдэг шашины өрөл, хот хөдөөгийн ялгавартай байдал ойролцоо хувьтай гарч байгаа тул насны ялгаа гэрлэсэн хосуудын шашиныгүзэх үзэлд нөлөөлдөггүй гэж дүгнэж болохоор байна.

7.5. Гэр бүлийн хосуудыг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нь зэрэгцүүлсэн байдал

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримтлах бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжлэх үйл явцыг нэг чухал үйлдэхүүн хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх үнэн зөв бодит мэдээлэлтэй байх явдал байдаг. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх судалгаа сүүлийн үед харьцангуй сайн хийгдэж байгаа ч нэг гэр бүлийн хосууд, хоёул хөгжлийн бэрхшээлтэй байх тохиолдлыг нарийвчлан судалсан судалгаа төдийлөн хангалттай бус байна.

Нийгэмд идэвхтэй байр суурь эзэлдэг 20-49 насныхны хувьд гэр бүлийн хосууд хоёул хөгжлийн бэрхшээлтэй өрх 2289 байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хосуудыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр харуулсан Хүснэгт 7.6-аас харахад бусад гэсэн өрөлд эрэгтэй, эмэгтэй харгалзан 24.6 хувь, 29.1 хувь хамгийн өндөр байгаа бол үүний дараагаар сонсголын бэрхшээлтэй эрэгтэй, эмэгтэй харгалзан 23.9 хувь, 20.6 хувь тус тус байна.

Хосуудын хөгжлийн бэрхшээлийн төрлийг хот, хөдөөгийн ялгавартайгаар авч үзэхэд харааны болон сэтгэцийн гэсэн төрөл нь хөдөөд өндөр хувьтай, ярианы болон сонсголын гэсэн төрөл нь хотод өндөр хувьтай, хөдөлгөөний болон бусад гэсэн төрөл нь хот, хөдөөд харьцангуй жигд байна.

Хүснэгт 7.6. 20-49 насны гэрлэсэн хөгжлийн бэрхшээлтэй хосууд, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010 он

Гэрлэсэн хосуудын хөгжлийн бэрхшээлийн төрлөөр	Нийт		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Харааны	13.9	11.1	13.0	10.8	15.2	11.4
Ярианы	7.1	7.3	8.7	9.5	4.6	4.0
Сонсголын	15.5	15.0	16.7	16.8	13.7	12.3
Хөдөлгөөний	23.9	20.6	23.9	19.0	23.9	23.1
Сэтгэцийн	15.0	16.9	12.9	14.6	18.3	20.2
Бусад	24.6	29.1	24.7	29.3	24.4	29.0
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	2289		1374		915	

Хосуудыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр Хүснэгт 7.7 -оос харахад харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл дотроо хөдөлгөөний бэрхшээлтэй эрэгтэйчүүдтэй гэр бүл болж байгаа хувь нь 21.7 хувь, мөн сэтгэцийн өөрчлөлттэй эмэгтэйчүүд мөн л хөдөлгөөний бэрхшээлтэй эрэгтэйчүүдтэй гэр бүл болж байгаа хувь нь 23.6 хувь байгаа нь хамгийн өндөр хувь болж байна.

Хүснэгт 7.7. 20-49 насны гэрлэсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн болон нөхрийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, холбоо, эзлэх хувиар, 2010 он

Өрхийн тэргүүлэгчийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, эхнэрийн насны бүлгээр	Эхнэрийн хөгжлийн бэрхшээлийн төрөл					
	Харааны	Ярианы	Сонсголын	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Бусад
20-34						
Харааны	44.4	0.0	5.8	10.5	7.6	12.1
Ярианы	2.5	63.6	9.2	3.2	7.6	5.2
Сонсголын	11.1	18.2	63.3	12.6	12.7	12.1
Хөдөлгөөний	21.0	9.1	10.8	53.7	19.0	19.0
Сэтгэцийн	8.6	6.1	9.2	13.7	45.6	6.9
Бусад	12.3	3.0	1.7	6.3	7.6	44.8
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	81	66	120	95	79	58
35-49						
Харааны	34.9	6.9	14.7	14.3	13.7	9.2
Ярианы	3.5	61.4	4.5	1.1	2.6	0.8
Сонсголын	12.8	10.9	33.0	13.0	9.1	7.2
Хөдөлгөөний	22.1	9.9	22.8	38.5	24.8	18.9
Сэтгэцийн	10.5	5.0	9.8	15.4	35.8	9.2
Бусад	16.3	5.9	15.2	17.8	14.0	54.7
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	172	101	224	377	307	609
20-49						
Харааны	37.9	4.2	11.6	13.6	12.4	9.4
Ярианы	3.2	62.3	6.1	1.5	3.6	1.2
Сонсголын	12.3	13.8	43.6	12.9	9.8	7.6
Хөдөлгөөний	21.7	9.6	18.6	41.5	23.6	18.9
Сэтгэцийн	9.9	5.4	9.6	15.0	37.8	9.0
Бусад	15.0	4.8	10.5	15.5	12.7	53.8
Бүгд - Хувь	100	100	100	100	100	100
Бүгд - Тоо	253	167	344	472	386	667

Ижил төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд харилцан бие биенээ ойлгох, бие биедээ тус дэмжүүлэх, аливаа арга хэмжээнд цуг оролцох гэх мэт олон шалтгааны үүднээс хоорондоо хамгийн өндөр хувьтайгаар гэр бүл болдог гэж үзэх үндэслэлтэй юм. Гэхдээ ижил төрлийн хөгжлийн бэрхшээлтэй гэрлэсэн хосуудаас хамгийн бага хувьтай нь сэтгэцийнх (37.82), харааных (37.9%) байгаа бол хамгийн өндөр нь (62.3%) ярианы бэрхшээлтэй иргэд болж байна.

Энэхүү үзүүлэлтийг 20-34, 35-49 гэсэн насны ялгаатайгаар авч үзэхэд 20 -34 насанд ижил төрлийн бэрхшээлтэй хүмүүс хоорондоо гэр бүл болох нь 35-49 насныхнаас илүү байна. Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хоорондоо гэр бүл болох нь 20 -34 насных 35-49 насныхтай харьцуулахад 30.3 пунктээр, хөдөлгөөний бэрхшээлтэй хосын хувьд 15.22 пунктээр тус тус илүү байна.

БҮЛЭГ 10. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

8.1. Дүгнэлт

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 713.8 мянган өрх тоологдсон нь 2000 оныхтой харьцуулахад 31.9 хувиар нэмэгдсэний дотор хотын өрх 61.9 хувиар өсч, хөдөөгийн өрх 4.3 хувиар буурчээ. Энэ нь хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой байна. Энэ нөгөө талаасаа хөдөө орон нутаг, хөдөөд амьдрах нь гэр бүлийн сайн сайхан амьдрах орчин биш болсон, манай оронд хөдөөгийн амьдралын орчны ялгаа эрс нэмэгдсэнийг нотолж байна.

Төрөөс сүүлийн 10-аад жилд гэр бүлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрүүд, тухайлбал, хүүхдийн мөнгө, шинэ гэр бүлд олгосон тэтгэмжүүд зэрэг нь өрх, гэр бүлийн тооны өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна. 1963-2010 оны хооронд 44 жилд хүн амын тоо 2.6 дахин нэмэгдсэн байхад өрхийн тоо 3 дахин буюу илүү хурдан өсчээ. 2008 оноос өрхийн тоо эрс нэмэгдэж, өмнөх жилүүдэд нь 14 -21 мянгаар нэмэгдэж байсан өрхийн тоо 2008 онд даруй 32 .1 мянгаар, 2006 онд 38.7 мянган өрхөөр өсчээ. Үүний нэг шалтгаан нь гэрлэх боломжтой насны хүн амын нийт үж амд эзлэх хувь нэмэгдсэнтэй холбоотой байсан нэг шалтгаан нь төрөөс өрх гэр бүлийг дэмжиж хүүхдийн мөнгө, шинэ гэр бүлд 500 мянган төгрөгийн урамшуулал олгож эхэлснээр залуу гэр бүлийн тоо өссөн байна. Энэхүү тэтгэмжийг авахаар залуучууд өмнөх жилүүдтэй харьцуулбал олноороо гэр бүл болсон нь харагдаж байна. Харин уг тэтгэмжийг 2010 оноос зогсоосны дараа өрхийн тооны цэвэр өсөлт эргээд буурчээ.

Тоологдсон нийт өрхийн 62 хувийг ам бүлээрээ амьдарч байгаа өрх эзэлж байна. Нийт өрхөд нийлмэл өрх 25 хувь, ганц бие өрх 11 хувь, харин холимог өрх 2 хувийг эзэлж байна. 2010 онд ганц бие 75.8 мянган өрх тоологдсоноос 65-аас дээш болон 20-29 насныхан 42.4 хувийг эзэлж байна. 2010 онд олон ам бүлтэй, тухайлбал, 8 ба түүнээс дээш ам бүлтэй 13 мянган өрх тоологдсон нь нийт өрхийн 1.8 хувийг эзэлж байна.

Эмэгтэй тэргүүлэгчтэй 153.6 мянган өрх тоологдсоноос 75 хувь нь хотод, 25 хувь нь хөдөөд байна. Эдгээр өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээгээр 21.5 хувь байхад Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь аймагт харьцангуй өндөр байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй 108.1 мянган хүн 46.1 мянган өрхөд тоологдсон. Нийт өрхөд эзлэх хөгжлийн бэрхшээлтэй өрхийн тоогоороо Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд улсын дунджаас дээгүүр байна.

Харин гэр бүл цуцлалтын тоо 2000-2010 онд нэмэгдсэн нь 2006 оноос эрс өссөн гэрлэлтийн тооны улмаас гэр бүл цуцлалтын тоо дагаад нэмэгдсэний зэрэгцээ 2008 оноос зарим залуучуудын олон тэтгэмж авах зорилготой “тохиролцооны шинэ гэр бүлүүд” эргээд цуцлагдсан байж болзошгүй байна. Энэ талаар тусгайлсан нэмэлт судалгааг залуучуудын дунд явуулж судлах шаардлагатай байна.

Гэр бүлүүдийн хувьд эхнэр, нөхрийн боловсролын түвшин өндөр байх тутам тухайн өрхийн ам бүлийн тоо цөөн байх хандлага ажиглагдаж байна.

Өрхийн ам бүлийн тоо үндэс угсаагаар ялгаатай байна. Монгол Улсад байнга оршин сууж байгаа гадаадын харьяат өрхүүдийн 61.2 хувь нь 1-2 ам бүлтэй байхад монгол өрхүүдийн 27 хувь нь л 1-2 ам бүлтэй байна.

Монгол Улсын зарим угсаатнуудын өрхийн ам бүлийн тоо улсын дунджаас дээгүүр, олон ам бүлтэй байна. Тухайлбал, Монгол Улсын дунджаар нийт өрхийн 26 хувь нь 5 болон түүнээс дээш ам бүлтэй байхад казак өрхүүдийн 45.7 хувь, хотон өрхийн 40.9, мөн захчин, тува өрхийн 33.2-33.6 хувь нь 5 болон түүнээс дээш ам бүлтэй байна. Харин харчин, сахар, хотгойд өрхүүдийн 16.4-22.3 хувь нь 5 болон түүнээс дээш ам бүлтэй байгаа нь улсын дунджаас нэлээн доогуур, харьцангуй цөөхүүлээ амьдардаг байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 713.8 мянган өрх тоологдсоны 519.3 мянга буюу нийт өрхийн 72.5 хувь нь хөдөлмөр эрхлээгүй наад зах нь нэг гишүүнтэй байжээ. Гэхдээ энэ нь бүгд ажилгүйчүүд гэсэн үг биш бөгөөд энд эдийн засгийн идэвхгүй хүн ам, үүний дотор оюутан сурагчид, хөдөлмөрийн чадваргүй, гэрийн ажилтай, өндөр настан, өвчтөн асардаг хүмүүс орсон болно.

Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн тоо нэмэгддэг зүй тогтол харагдаж байна. Өрхийн ам бүлийн тоо 7 ба түүнээс дээш болоод ирэхэд хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 90-ээс дээш гарч байна. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам өрхийн хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн тоо нэмэгдэх магадлал өндөр байна.

Гэрлэлтийн байдлыг тодорхойлох чухал үзүүлэлт гэрлэлтийн тусгай коэффициент 1989 оны тооллогоос хойш эрс буурсаар иржээ. 1979 онд арван найм ба түүнээс дээш насны 1000 хүн тутамд 15 гэрлэлт ногдож байсан бол 2000 оны тооллогоор 9, 2010 онд дөнгөж 3 гэрлэлт ногдож байна.

1989 он хүртэл хүн амын гэрлэлт тогтвортой байсан бол 1989 -2000 он хүртэл буурч, харин сүүлийн 10 жилд батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийн тоо өмнөх тооллогын үеэс өссөн байна.

Сүүлийн 30 жилийн байдлаар гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн ам өссөөр ирсэн бол бэлбэсэн хүн ам буурсаар байна. Гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын хувийн жин 1979 онд 1.85 хувь, 1989 онд 1.6, 2000 онд 2.7, 2010 онд 3.1 хувь болох хандлагатай байна. Сүүлийн 30 жилээр авч үзэхэд бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо бэлбэсэн эрэгтэйчүүдийн тооноос илүү байгаа нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс бага байдагтай холбоотой юм.

Нийт хүн амд гэр бүл тусгаарласан болон цуцалсан хүний эзлэх хувиар хамгийн их нь Орхон аймагт 4.3 хувь, Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Хэнтий аймагт 3.7 хувь, Говьсүмбэр аймагт 3.6 хувь байна. Уг үзүүлэлтээр хамгийн бага байгаа нь Баян-Өлгий аймаг 0.8 хувь, Увс аймаг 1.1 хувь, Ховд аймаг 1.3 хувь, Завхан аймаг 1.3 хувьтай байна.

Нийт хүн амд бэлбэсэн хүн амын эзлэх хувиар хамгийн их нь Архангай болон Баянхонгор аймаг 7 хувь, Увс аймаг 6.6 хувьтай байна. Үзүүлэлтээр хамгийн бага байгаа нь Өмнөговь аймаг 4 хувь, Улаанбаатар хот 4.8, Дорноговь 4.9 хувьтай байна.

2010 оны тооллогоор гэр бүлтэй болон хамт амьдардаг хүн амын 86 хувь нь батлуулсан, 14 хувь нь батлуулж гэр бүлтэй байна. Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүн ам хотод хөдөөнөөс илүү оршин сууж байна.

Огт гэрлээгүй хүн амын эзлэх хувь сүүлийн 10 жилд буурсан байна. 1979 оны тооллогоор арван тав ба түнээс дээш насны эрэгтэйчүүдийн 27.7 хувь нь огт гэрлээгүй байсан бол энэ тоосч явсаар 2010 онд 34.4 хувьтай болсон байна. 1979 оны тооллогоор арван тав ба түнээс дээш насны эмэгтэйчүүдийн 18.5 хувь нь огт гэрлээгүй байсан бол өссөөр 2010 онд 28.2 хувьд хүрсэн байна. Ийнхүү огт гэрлээгүй эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо жилээс жилд өссөөр байгаа хэдий ч огт гэрлээгүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийхээс өндөр байна.

Арван тав, түнээс дээш насны огт гэрлээгүй хүн амын 74 хувь нь хотод байгаа нь хөдөөд хоттой харьцуулахад гэрлэлт өндөр хувьтай байгааг харуулж байна. Огт гэрлээгүй хүн амын ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 2010 оны тооллогоор арван тав, түнээс дээш насны огт гэрлээгүй, эдийн засгийн идэвхтэй хүн амын 75.8 хувь нь ажил эрхэлдэг, 24.2 хувь нь ажил хайж байна. Ажил эрхэлдэг хүн амын 65.3 хувь нь хотын, 34.7 хувь нь хөдөөнийх бол ажил хайж байгаа хүн амын 68.2 хувь нь хотын, 31.8 хувь нь хөдөөнийх байна.

Огт гэрлээгүй хүн амыг харьяалал, үндэс угсаагаар, дүнд эзлэх хувиар авч үзвэл цаатан 36.4 хувь, узбек 34.7 хувь, халимаг 34.4 хувь нь огт гэрлээгүй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Анхны гэрлэлтийн дундаж нас хойшилсоор байна. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр улсын дунджаар эмэгтэйчүүд 24.2 насандаа, эрэгтэйчүүд 26.2 насандаа анх гэр бүл болж байна. Хүн ам, орон сууцны 1979-2010 оны хоорондох 4 тооллогын дүгээс харахад манай оронд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насны ялгаа ойролцоогоор хоёр насны зөрүүтэй байна. Анхны гэрлэлтийн дундаж нас 1989, 2000 оны хооронд 2.4-2.6 жилээр нэмэгдсэн бол сүүлийн 10 жилд энэ зөрүү эрс багасчээ.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжилт хийсэн сүүлийн 20 жилийн эдийн засаг, нийгмийн амаргүй хүнд бэрх нөхцөл, өнөөгийн залуучууд нийгэмд эзлэх байр сууриа олох, өрсөлдөөнт нөхцөлд ажлын байр олж өдөлмөр эрхлэх, сайн сайхан амьдрахын тулд сурч боловсрох, гадаад улс орнуудад явж, өдөлмөр эрхэлж, мөнгө хуримтлуулах зэргээр амьралынхаа багц цаг хугацааг зарцуулах болсон зэрэг олон шалтгаанаар өмнөх үеийнхнээсээ хожим гэрлэх болсон гэж үзэж болно.

2010 оны байдлаар манай орны их, дээд сургуульд нийтдээ 216.9 мянган оюутан залуус суралцаж байсан нь 20-24 насны нийт залуучуудын (оюутнууд хэдийгээр бүгд энэ насанд хамаарахгүй ч гэсэн) 70 хувь болж байна. Эндээс залуучуудын хувьд их, дээд сургуульд суралцаж, гэрлэлтээ хойшлуулах хэрэгцээ шаардлага байгаа нь тодорхой байна.

Нөгөө талаараа манай оронд олон мянган залуучууд ажилгүйчүүдийн эгнээнд байна. Хүн ам орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр ажилгүйдлийн түвшин 20-24 насны залуучуудын дунд 23.8 хувь байгаа нь улсын дунджаас (15.3) ихээхэн өндөр байгаа бөгөөд энэ насны ажиллах хүчнээс тооцоход нийтдээ 40 орчим мянган залуучууд ажил эрхлэж байна гэсэн үг юм.

Амьдралд хөлөө олоогүй, ажил хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудын хувьд мөн гэрлэлтээ хойшлуулж байж болох талтай. Ингээд суралцаж байгаа болон ажилгүй залуучууд 20-24 насны нийт залуучуудын ойролцоогоор 83 хувь болж байгаа нь анхны гэрлэлтийн дундаж нас хойшлогдоход нөлөөлж байна.

Хөдөөгийн залуус хотынхоос арай эрт гэрлэдэг байна. Ялангуяа хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн гэрлэлтийн дундаж насны зөрүү нэлээд байна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр хотын эмэгтэйчүүд дунджаар 25 насандаа анх гэрлэж байхад хөдөөд 22 насандаа гэрлэж байна. Гэтэл эрэгтэйчүүдийн хувьд хот, хөдөөгийн ялгаа бараг байхгүй бүгд дунджаар 26 насандаа анх гэрлэж байна.

1979 оны хүн ам, орон сууцны тооллогоос хойших хугацаанд хөдөөгийн эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 4.1 жилээр хойшлогдсон бол хотын эмэгтэйчүүдийнх бүр 5.4 жилээр хойшлогдсон байна.

2000 болон 2010 оны тооллогын дүнгээс харахад Улаанбаатар хот, Говь - Алтай аймгийн эрэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас улсын дунджаас дээгүүр, бусад аймаг, хотынхоос орой гэрлэж байжээ. Гэтэл хоёр тооллогын аль алинд нь говийн бүсгүйчүүд, тухайлбал, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас сүүлийн 2 тооллогын дүнгээр улсын дунджаас доогуур, харьцангуй эрт гэрлэсэн байна.

Монголд амьдардаг гадаадын харьяатуудын анхны гэрлэлтийн дундаж нас монголчуудынхаас хойно байгаагийн дотор эмэгтэйчүүдийнх нь хамгийн өндөр 28.9 байгаа нь гадаадын харьяат эрэгтэйчүүдээс 2 насаар хойно байна. Харин Монголын үндэс угсаатнуудаас дархад, хотгойд эмэгтэйчүүд дунджаар 23 хүрэлгүй анх гэрлэдэг бол торгууд бүсгүйчүүд хамгийн орой, дунджаар 26 хүрч байж гэрлэдэг байна. Гэтэл хотон эрчүүд бусдаас эрт дунджаар 25 хүрэлгүй гэрлэдэг бол торгууд эрчүүд хамгийн орой, дунджаар 26.6 настай анх гэрлэдэг байна.

Сүүлийн 2 тооллогын дүнгээс харахад анхны гэрлэлтийн дундаж нас эрэгтэйчүүдийн хувьд боловсролын түвшин өндөр байх тусам бага, харин боловсролын түвшин бага байх тусам өндөр гарчээ. Өөрөөр хэлбэл, бага боловсролтой залуучууд өндөр боловсролтой үе тэнгийнхнээсээ илүү орой гэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл, бага боловсролтой эрэгтэйчүүдийн гэрлэх магадлал дээд боловсролтой эрэгтэйчүүдийнхээс бага байна гэсэн үг юм.

Сүүлийн 2 тооллогын дүнгээр судалж үзэхэд ажил хийдэг эрэгтэй, эмэгтэйчүүд ажил эрхэлдэггүй залуучуудаас арай эрт гэрлэдэг ерөнхий зүй тогтол ажиглагдлаа. Харин эдийн засгийн идэвхгүй хүн амын дийлэнх төрөл дээр залуучууд ерөнхийдөө хамгийн орой гэрлэж байна.

Хоёр тооллогын дүнгээр менежер эрэгтэйчүүд хамгаас эрт гэрлэсэн байна. Тэдэнд эрт гэрлэх боломжгүй байжээ. Гэтэл энгийн ажил мэргэжлийн эрэгтэйчүүд дунджаар бусад мэргэжлийнхнээс арай хожуу гэрлэжээ.

Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин ерөнхийдөө өндөр болсны улмаас дийлэнх олонх нь (2/3-оос дээш хувь нь) өөрөөсөө доогуур боловсролтой нөхөртэй байна. Гэр бүлийн хосуудыг ажил мэргэжлийн ангиллаар аваад үзэхэд

менежер гэсэн бүлэгт багтах эрэгтэйчүүд өөрсдөөсөө албан тушаалын зэрэглэл багатай эмэгтэйчүүдтэй гэрлэсэн хувь өндөр байна.

Гэр бүлийн хосуудыг үндэс угсаагаар зэрэгцүүлэн үзэхэд казак (96.51), халх (93.93) эмэгтэйчүүд өөртэйгөө ижил үндэс угсаатай хүнтэй гэр бүл болж байгаа бол энэ үзүүлэлт буриад эмэгтэйчүүдийн хувьд хамгийн бага ердөө 36.1 хувь байна.

Гэр бүл бологсдыг шашин үзлэгээр нь авч үзэхэд лалын шашинтай эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хоорондоо гэр бүл болсон хувь хамгийн өндөр 95.7 хувь, шүтлэггүй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хоорондоо гэр бүл болсон хувь 89.9, буддын шашин үздэг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хоорондоо гэр бүл болсон хувь 86.1 хувь байгаа бол үзлэлт христийн шашин шүтдэг хосуудын хувьд хамгийн бага буюу 54.1 хувьтай байна.

Нийгэмд идэвхтэй байр суурь эзэлдэг 20-49 насныхны хувьд гэр бүлийн хосууд хоёул хөгжлийн бэрхшээлтэй байгаа өрх 2289 байна.

8.2. Зөвлөмж

1. УИХ-аас 2004 онд баталсан “Монгол Улс төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-д хүн амын өсөлтийг төрөөс дэмжихээр тусгасан. Өргөн уудам нутагтай, цөөхөн хүн амтай манай орны хувьд хөгжлийн түвшнээ нэмэгдүүлэхэд хүн амын тоогоо өсгөх онцгой хэрэгцээ шаардлага байдаг. Төрөөс сүүлийн 10 -аад жилийн хооронд гэрлэлийг дэмжихэд чиглэсэн өгөлбөрүүд, тухайлбал, хүү хдийн мөнгө, шинэ гэр бүлд олгосон тэтгэмжүүд зэрэг нь өрх, гэр бүлийн тооны өсөлтөнд эерэгээр нөлөөлснийг дээрх дүгнэлтэнд тэмдэглэсэн. Анхны гэрлэлтийн дундаж нас хойшилж, гэрлэлтийн тусгай коэффициент буурсаар байсний нөхцөлд төрөөс гэр бүлийг дэмжсэн өгөлбөрүүдийг цаашид тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна.
2. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр нийт өрхийн тоо 2000 оныхтой харьцуулахад 31.9 хувиар нэмэгдсэний дотор хэргийн 61.9 хувиар өсч, харин хөдөөгийн өрх 4.3 хувиар буурчээ. Энэ нь өдөө орон нутаг нь тэнд амьдрах гэр бүлийн сайн сайхан амьдрах орчин биш болсныг нотолж, хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн сүүлийн 10 жилд ихэссэнийг харуулж байна. 2010 оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр хотын өрхүүдийн дунд ядуурлын хамралт 32.2 хувьтай байсан бол өдөөд бүр 47.8 хувь гарсан нь хөдөө орон нутагт ядуурал ихээхэн үнзгийрснийг харуулав. Энэ бүх баримт нь хөдөө, орон нутгийг хөгжүүлэх, тэнд хүн ажиллаж, амьдрах таатай орчинг бий болгох талаар өнөөгийн төрийн бодлогод эрс өөрчлөлт хийх шаардлагатайг харуулж байна.

3. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 713.8 мянган өрх тоологдсоны 519.3 мянга буюу өрхийн 72.5 хувь нь хөдөлмөр эрхлээгүй наад зах нь нэг гишүүнтэй байжээ. Манай орны хүн ам насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуужих хандлагатай болж, нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрч, хүн ам зүйн цонхны нэн таатай үе эхлээд байна. Эрдэмтэн, судлаачдын тооцоогоор хүн ам зүйн цонхны энэ үе 2025 он хүртэл үргэлжилнэ. Тиймээс энэ таатай үеийг ашиглаж эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг хөдөлмөрийн нөөцөө бүрэн ашиглахуйц ажиллах хүчний шингээлт сайтай ажлын байр бий болгоход чиглэсэн оновчтой бодлогыг төрөөс үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү судалгаанаас үзэхэд ажил хөдөлмөр эрхэлдэг залуучуудын анхны гэрлэлтийн дундаж нас ажилгүй залуучуудынхаас арай эрт байна. Энэ нь ажил эрхлэлт үүрэгт тоо нэмэгдэх, өрх, гэр бүлийн амьдралын төвшинг дээшлүүлэх анхдагч үндсэн нөхцөл болж байгааг харуулж байна.
4. Төрөх насны эмэгтэйчүүдийн тоо өндөр байгаа энэ үед хүн амын зохистой төрөлтийг дэмжин, тогтвортой өсөлтийг хангах замаар хүн ам зүйн цонхны үеийг цаашид урт удаан хугацаанд үргэлжлүүлэх боломж ийг бүрдүүлэх шаардлага байна. Төр өс үнэхээр хүн амын өсөлтийг дэмжих байгаа бол залуу охид, эмэгтэйчүүдийн дунд дэлгэрсэн замбараагүй үр хөндөлтийг хуулиар цэгцлэх шаардлагатай болжээ. Манай оронд 2010 оны байдлаар төрсөн 5 хүүхэд тутамд нэг үр хөндөлт ногдож байна. Үр хөндөлтийн тоонд хувийн эмнэлгүүдэд голчлон хийгддэг үр хөндөлтүүд бүрэн ороогүй бөгөөд зарим судлаачдын тооцоогоор төрсөн нэг хүүхэд тутамд нэг үр хөндөлт ногдож байна. Энэ нь манай орны хүн амын тоог өсгөх ихээхэн боломж байгааг харуулж байна.
5. Залуу гэр бүлийг төрөөс дэмжиж, 100 айлын орон сууцны төлбөрийг эхлүүлснийг цаашид эрчимтэй хэрэгжүүлэх, эрдэс баялгийн ашиглалт, уул уурхайн салбарын хөгжлөөс олсон орлогыг хүн амд бэлнээр олгож байгаа өнөөгийн практикийг зогсоож, цаашид энэхүү хөрөнгийг орон сууцны урт хугацааны зээлийн сан байгуулах, залуу гэр бүл орон сууцны урт хугацааны, хөнгөлттэй зээл авах боломжийг олгох, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, сургуулийг хүн ам төвлөрсөн газруудад олноор бий болгоход нэн тэргүүнд зарцуулах шаардлагатай байна.
6. Сүүлийн 2 тооллогын дүнгээс харахад гэр бүл цуцлалтын тоо нэмэгдсээр байна. Ажилгүйдэл, архидалт, амьжиргааны доройтол нь гэр бүлийн доторх харилцаанд таагүй нөлөөлж, улмаар гэр бүл салахад нөлөөлсөөр ирсэн нь нууц биш. Өөр нэг шалтгаан нь залуу гэр бүлийн зар им гишүүд гадаадад цөөнгүй жилээр ажил хөдөлмөр эрхлэх болж, гэр бүлийн гишүүд 2 тусдаа салангид амьдрахад хүрч, яваандаа салж сарних, хүүхдүүд өнчрөх, улмаар хүүхдийн хүмүүжилд хүртэл сөргөөр нөлөөлөх үзэгдэл газар авч байна. БНСУ болон бусад орнуудад амьдардаг залуучуудыг гэр бүл, хүүхэдтэй нь

хамт явуулах, виз олгох асуудлыг гадаад харилцааны шугамаар шийдвэрлэх шаардлагатай байна.

7. Монгол гэр бүл судлалыг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний төслийн хүрээнд гэр бүлийн уламжлал, шинэчлэл, орчин үеийн залуучуудын дунд дэлгэрч байгаа гэр бүлийн бус амьдралын хэв маяг, уламжлалт бус гадны нөлөөг судлах, цаашид гэр бүл цуцлалтын шалтгааныг нарийвчлан судлах шаардлагатай байна.
8. Эцэст нь ~~үн~~ ам, орон сууцны дараагийн 2020 оны тооллогод өрхийн тодорхойлолтыг өөрчлөх шаардлагатай болжээ. НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан газар, түүний Статистикийн хэлтсээс хоёрдахь удаагаа засаж сайжруулан 2009 онд гаргасан ~~АЖ~~ ~~аж~~, орон сууцны тооллогод холбогдох зарчим, ~~өвлөмжүүд~~ гэсэн аргачлалд “өрхийн аж ахуй” (Household) гэдэг ойлголт нь ахуйн хэвшилд тулгуурласан ойлголт бөгөөд хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг ~~үбэг~~ хүмүүсийг хэлнэ гэж тодорхойлжээ. Манай өрхийн тодорхойлолтонд зөвхөн хэсэг бүлэг хүмүүсийг л өрх гэж ойлгоод ганц бие өрхийг орхигдуулсан байна. Гэтэл өрхийн бүтцийг 4 төрлөөр тодорхойлохдоо ганц биөрх гэж оржээ. Энд тодорхойлолт, өрхийн ангилал хоёр хоорондоо эрчилтэй тусгагдсан тул цаашид нэг мөр өөрчлөх шаардлагатай.

ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Өрхийн тоо, өрхөд тоологдсон хүний тоо, өрхийн хэлбэрээр, 2010 он

Ам бүлийн тоо	Бүгд		Өрхийн хэлбэрээр							
			Ганц бие		Ам бүлээрээ		Нийлмэл ам бүлтэй		Холимог ам бүлтэй	
	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам
Бүгд	713 780	2 553 753	75 917	75 917	445 048	1 594 314	177 898	815 639	14 917	67 883
1	75 917	75 917	75 917	75 917	-	-	-	-	-	-
2	114 642	229 284	-	-	91 952	183 904	20 802	41 604	1 888	3 776
3	165 873	497 619	-	-	132 768	398 304	30 347	91 041	2 758	8 274
4	171 733	686 932	-	-	129 298	517 192	39 200	156 800	3 235	12 940
5	103 933	519 665	-	-	61 931	309 655	39 027	195 135	2 975	14 875
6	50 085	300 510	-	-	21 186	127 116	26 606	159 636	2 293	13 758
7	18 601	130 207	-	-	5 830	40 810	11 963	83 741	808	5 656
8	7 693	61 544	-	-	1 585	12 680	5 595	44 760	513	4 104
9	2 941	26 469	-	-	371	3 339	2 359	21 231	211	1 899
10	1 338	13 380	-	-	95	950	1 113	11 130	130	1 300
11	529	5 819	-	-	22	242	464	5 104	43	473
12	259	3 108	-	-	8	96	226	2 712	25	300
13	109	1 417	-	-	2	26	89	1 157	18	234
14	74	1 036	-	-	-	-	64	896	10	140
15	23	345	-	-	-	-	16	240	7	105
16+	30	501	-	-	-	-	27	452	3	49

Хүснэгт 2. Өрхийн тоо, аймаг, нийслэл, ам бүлийн тоогоор, 2010 он

Аймаг, нийслэл	Бүгд	Өрхийн ам бүлийн тоогоор								Ам бүлийн дундаж тоо
		1	2	3	4	5	6	7	8+	
Бүгд	713 780	75 917	114 642	165 873	171 733	103 933	50 085	18 601	12 996	3.6
Архангай	24 551	3 306	4 264	5 729	6 073	3 436	1 315	310	118	3.3
Баян-Өлгий	19 225	681	1 938	3 419	4 372	3 872	2 859	1 390	694	4.4
Баянхонгор	21 695	2 989	3 422	4 987	5 073	3 139	1 458	450	177	3.4
Булган	15 807	1 992	3 081	3 845	3 866	2 055	717	167	84	3.3
Говь-Алтай	14 562	1 703	2 205	3 354	3 781	2 286	878	246	109	3.5
Дорноговь	16 543	2 413	2 795	3 999	3 822	2 059	998	266	191	3.3
Дорнод	18 895	2 361	3 197	4 403	4 154	2 578	1 328	511	363	3.5
Дундговь	10 895	1 276	1 958	2 501	2 652	1 552	644	190	122	3.4
Завхан	18 574	2 279	3 155	4 366	4 601	2 730	1 038	289	116	3.4
Өвөрхангай	28 051	2 893	4 685	6 560	7 098	4 204	1 824	517	270	3.5
Өмнөговь	14 939	2 217	2 726	3 568	3 326	1 910	808	245	139	3.3
Сүхбаатар	14 145	1 325	2 181	3 585	3 672	2 107	852	276	147	3.5
Сэлэнгэ	26 889	2 880	4 734	6 709	6 405	3 560	1 673	579	349	3.5
Төв	24 687	3 458	4 737	5 873	5 621	3 166	1 265	393	174	3.3
Увс	18 641	1 685	2 626	3 812	4 174	3 372	1 867	741	364	3.8
Ховд	18 944	1 641	2 513	3 862	4 344	3 443	1 942	777	422	3.9
Хөвсгөл	33 007	4 047	5 487	7 868	8 168	4 715	1 906	523	293	3.4
Хэнтий	19 147	2 876	3 403	4 372	4 306	2 549	1 072	373	196	3.3
Дархан-Уул	24 227	2 313	4 192	6 008	5 866	3 320	1 584	567	377	3.5
Улаанбаатар	302 242	28 835	46 488	69 869	73 207	44 218	22 521	9 219	7 885	3.7
Орхон	24 273	2 152	4 152	6 262	6 311	3 195	1 347	501	353	3.5
Говьсүмбэр	3 841	595	703	922	841	467	189	71	53	3.3

Хүснэгт 3. Өрхөд тоологдсон хүн амын тоо, хот, хөдөө, ам бүлийн тоо, өрхийн хэлбэрээр, 2010 он

Ам бүлийн тоо	Бүгд	Өрхийн хэлбэрээр			
		Ганц бие	Ам бүлээрээ байгаа өрх	Нийлмэл ам бүлтэй өрх	Холимог ам бүлтэй өрх
Бүгд	2 553 753	75 917	1 594 314	815 639	67 883
1	75 917	75 917	-	-	-
2	229 284	-	183 904	41 604	3 776
3	497 619	-	398 304	91 041	8 274
4	686 932	-	517 192	156 800	12 940
5	519 665	-	309 655	195 135	14 875
6	300 510	-	127 116	159 636	13 758
7	130 207	-	40 810	83 741	5 656
8	61 544	-	12 680	44 760	4 104
9	26 469	-	3 339	21 231	1 899
10	13 380	-	950	11 130	1 300
11	5 819	-	242	5 104	473
12	3 108	-	96	2 712	300
13	1 417	-	26	1 157	234
14	1 036	-	-	896	140
15	345	-	-	240	105
16+	501	-	-	452	49
Хот - Бүгд	1 734 761	47 246	960 251	674 653	52 611
1	47 246	47 246	-	-	-
2	153 414	-	119 460	31 200	2 754
3	340 776	-	262 350	72 033	6 393
4	464 484	-	325 436	129 116	9 932
5	342 800	-	169 180	162 485	11 135
6	202 284	-	59 478	132 444	10 362
7	92 379	-	17 108	70 721	4 550
8	46 936	-	5 136	38 344	3 456
9	21 627	-	1 512	18 414	1 701
10	11 640	-	430	10 090	1 120
11	5 115	-	99	4 609	407
12	2 844	-	36	2 520	288
13	1 378	-	26	1 118	234
14	1 022	-	-	882	140
15	315	-	-	225	90
16+	501	-	-	452	49
Хөдөө - Бүгд	818 992	28 671	634 063	140 986	15 272
1	28 671	28 671	-	-	-
2	75 870	-	64 444	10 404	1 022
3	156 843	-	135 954	19 008	1 881
4	222 448	-	191 756	27 684	3 008
5	176 865	-	140 475	32 650	3 740
6	98 226	-	67 638	27 192	3 396
7	37 828	-	23 702	13 020	1 106
8	14 608	-	7 544	6 416	648
9	4 842	-	1 827	2 817	198
10	1 740	-	520	1 040	180
11	704	-	143	495	66
12	264	-	60	192	12
13	39	-	-	39	-
14	14	-	-	14	-
15	30	-	-	15	15
16+	-	-	-	-	-

Хүснэгт 4. Өрхийн тоо, ам бүлийн тоо болон өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар, 2010 он

Бүгд

Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа	Бүгд	Өрхийн ам бүлийн тоогоор															
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16+
Бүгд	713 780	75 917	114 642	165 873	171 733	103 933	50 085	18 601	7 693	2 941	1 338	529	259	109	74	23	30
Халх	586 611	63 617	95 798	139 100	142 649	83 219	38 361	13 739	5 835	2 310	1 108	440	229	95	64	19	28
Казак	22 498	868	2 275	4 027	5 043	4 465	3 263	1 664	625	189	48	14	9	4	1	2	1
Дөрвөд	19 496	1 675	2 883	4 101	4 632	3 275	1 811	709	250	86	42	19	7	3	3	-	-
Буриад	13 533	1 801	2 477	3 021	2 894	1 831	934	329	147	55	26	11	1	3	2	1	-
Баяд	15 288	1 354	2 263	3 257	3 481	2 647	1 442	562	176	63	26	12	2	-	2	-	1
Дарьганга	8 088	684	1 331	2 021	2 079	1 243	485	157	58	19	6	2	2	-	-	1	-
Урианхай	7 447	760	1 147	1 652	1 699	1 187	643	226	80	36	9	7	1	-	-	-	-
Захчин	8 760	829	1 185	1 844	1 963	1 527	860	343	138	40	22	4	2	1	2	-	-
Дархад	6 012	742	910	1 342	1 396	912	455	153	58	25	10	6	2	1	-	-	-
Торгууд	3 972	390	551	881	994	672	303	111	48	14	6	2	-	-	-	-	-
Өөлд	4 730	567	769	1 064	1 149	684	317	106	51	15	5	1	-	2	-	-	-
Хотон	2 671	228	307	489	554	395	369	182	95	37	8	7	-	-	-	-	-
Мянгад	1 789	154	256	362	414	328	163	61	32	13	5	1	-	-	-	-	-
Барга	917	106	141	217	216	124	64	26	11	9	3	-	-	-	-	-	-
Үзэмчин	775	80	120	181	181	134	50	18	8	-	3	-	-	-	-	-	-
Харчин	55	9	6	18	13	4	2	2	-	1	-	-	-	-	-	-	-
Цахар	47	17	5	10	6	5	3	1	-	-	-	-	-	-	-	-	-
Хотгойд	4 715	538	807	1 103	1 218	664	263	82	25	11	3	-	1	-	-	-	-
Элжигэн	361	38	55	81	91	61	22	7	5	1	-	-	-	-	-	-	-
Цаатан	90	10	13	20	26	10	3	5	2	-	1	-	-	-	-	-	-
Сартуул	405	40	74	92	102	58	25	9	3	1	-	-	1	-	-	-	-
Тува	1 348	102	210	275	314	220	126	63	23	11	4	-	-	-	-	-	-
